



ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

Улаанбаатар хот
2018 он



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ.....	5
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН 2 ДУГААР ЗААЛТЫН ТАНИЛЦУУЛГА:	6
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ	11
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	13
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН 70 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ (2018 оны 8 дугаар сарын байдлаар).....	50
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ (2018 оны 8 дугаар сарын байдлаар).....	56
ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА	75
I. ИНФЛЯЦИ	75
II. БОДИТ СЕКТОР.....	79
2.1. Нийт нийлүүлэлт	79
2.2. Нийт эрэлт.....	80
III. УЛСЫН ТӨСӨВ.....	81

IV. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ	86
4.1. Төсөөлөлд ашигласан гадаад зах зээлийн таамаглал	86
4.2. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	90
4.3. Инфляцийн төсөөлөл	94
4.4. Төсөөллийн тодорхой бус байдал	94
V. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	97
5.1. Мөнгөний нийлүүлэлт, зээл.....	97
5.2. Мөнгөний зах, хүүний түвшин	101
5.3. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш	103
VI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗАХ ЗЭЭЛ.....	106
6.1. Төлбөрийн тэнцэл	106
6.2. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц.....	111
6.3. Монгол Улсын нийт гадаад өр.....	116
VII. ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР	120
VIII. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	121
8.1. Санхүүгийн салбар.....	121
8.2. Банкны салбарын өнөөгийн байдал, цаашдын төлөв	126
8.3. Банкны салбарын эрсдэл даах чадвар	130

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус даалгасугай.

- 1/ Монгол Улсаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авсан арга хэмжээнд олон улсын байгууллагаас хийсэн үнэлгээг дээшлүүлэх шат дараалсан арга хэмжээг төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;
- 2/ Гадаад валютын нөөцийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан түвшинд дунд хугацаанд хүргэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх;
- 3/ “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах;
- 4/ “Чанаргүй активыг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах;
- 5/ Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах эрх зүйн орчинг бий болгож, хэрэгжилтийг хангах чиглэлээр зохих арга хэмжээг авах;
- 6/ Санхүүгийн салбарыг дэмжиж, тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах;

Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Д.Дамба-Очир/-нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ УИХ-ЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН 2 ДУГААР ЗААЛТЫН ТАНИЛЦУУЛГА:**

2. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд тус тус даалгасугай.

1/ Монгол Улсаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авсан арга хэмжээнд олон улсын байгууллагаас хийсэн үнэлгээг дээшлүүлэх шат дараалсан арга хэмжээг төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх;

Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ)-аас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тогтолцоо болон 2012-2016 оны хооронд энэ чиглэлээр авсан арга хэмжээний үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Үнэлгээний тайланг 2017 оны 7 дугаар сард АНДББ-ын ээлжит чуулганы үеэр хэлэлцэж, “Эрчимтэй хяналт (enhanced expedited)” оруулах шийдвэр гаргасан. Үүнээс гадна АНДББ-аас 2018 оны 10 дугаар сар хүртэл хугацаат үүрэг өгсөн бөгөөд тэрхүү үүргийг хангалтгүй биелүүлсэн тохиолдолд Монгол Улсыг “Эрчимтэй хяналт”-аас ФАТФ-ын “саарал жагсаалт”-д шилжүүлж болзошгүйг анхааруулсан¹.

Монгол Улсын Засгийн газар 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 327 дугаар тогтоолоор 2017 оны 12 дугаар сараас 2018 оны 10 дугаар сарын хооронд авч хэрэгжүүлэх “Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г баталж Монголбанк, Санхүүгийн Мэдээллийн Албатай /СМА/ хамтран хэрэгжүүлж байна.

УИХ-аас 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр МУТСТ тухай хууль болон дагалдах хуулиудын нэмэлт, өөрчлөлтүүдийг баталсан нь Монгол Улсын МУТСТ тогтолцоог ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлэх, хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг эрсдэлд суурилан гүйцэтгэх, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг эрс чангатгахад чухал алхам болов.

АНДББ-ын 2018 оны 7 дугаар сард хуралдсан ээлжит чуулганы үеэр Монгол Улс холбогдох хууль тогтоомжоо шинэчилснийг харгалзан үзэж эрчимтэй хяналтад байх хугацааг дахин 12 сараар сунгасны дээр хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд авсан арга хэмжээний тайланг 2019 оны 1 дүгээр сарын 30-ны дотор АНДББ-д хүргүүлэх үүргийг Монгол Улсад өгөөд байна.

¹ ФАТФ нь Мөнгө угаалт, терроризмын санхүүжилт болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх үйл ажиллагаатай тэмцэх үндсэн чиг үүрэгтэй олон улсын байгууллага юм.

Ийнхүү “Эрчимтэй хяналт”-ын хугацааг дахин 12 сараар сунгасан нь “Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г амжилттай хэрэгжүүлэх ховор боломжийг Монгол Улсад олгосон явдал боллоо. Үлдэж буй хугацаанд Монгол Улсын эрх бүхий байгууллагуудаас хугацааны хоцролттой буюу гүйцэтгэл нь хангалтгүй байгаа ажлуудыг эрчимжүүлж, ойрын хугацаанд дуусгах, энэ чиглэлээр хангалттай хэмжээний хөрөнгө мөнгө, хүний нөөцийг хуваарилах нь туйлын чухал ач холбогдолтой байна.

Ийнхүү “Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г 2018 оны 10 дугаар сар хүртэл төдийгүй 2019 онд ч үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бодит хэрэгцээ шаардлага байгааг харгалзан үзэж “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийг батлах тогтоолын төслийн 2 дугаар заалтын 1 дэх хэсэгт: “Монгол Улсаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авсан арга хэмжээнд олон улсын байгууллагаас хийсэн үнэлгээг дээшлүүлэх шат дараалсан арга хэмжээг төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх”-ээр тусгаад байна.²

2/ Гадаад валютын нөөцийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан түвшинд дунд хугацаанд хүргэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх;

Сүүлийн 5 жилд Монгол Улс жилд дунджаар 4,616 сая ам.доллартай тэнцэхүйц бараа, бүтээгдэхүүн, 1,923 сая ам.доллартай тэнцэхүйц үйлчилгээг гадны улс орнуудаас импортолж байжээ. Үүнээс үзвэл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3.3-д заасны дагуу гадаад валютын улсын нөөцийг дунд хугацаанд хамгийн багадаа 6.5 тэрбум ам.долларт хүргэх шаардлагатай юм.³

Гадаад валютын улсын нөөцийг хүрэлцээт түвшинд хуримтлуулах нь ирээдүйд учирч болзошгүй гэнэтийн гадаад сөрөг нөлөөллөөс улс орны эдийн засгийг хамгаалж, түүний хор уршгийг бууруулах, улс орны эдийн засгийн аюулгүй байдал, дархлааг бэхжүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой. Энэ нь 2008-09 онд тохиосон Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын туршлагаас тодорхой харагддаг бөгөөд тухайн үед гадаад валютын нөөц харьцангуй өндөртэй улс орнууд хямралыг хохирол багатай даван туулж, банк, санхүүгийн гүнзгий хямралыг тойрч гарсан байдаг⁴.

Харин гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд экспорт, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар дамжуулан валютын орох урсгалыг нэмэгдүүлэх нь чухал. Үүний тулд Монгол Улсад үйлдвэрлэж буй бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах

² "Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх стратеги"-ийн 7.1-д мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэх тухай заасан.

³ "МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын суурь зарчимд гадаад валютын нөөцийн зохистой хэмжээг байнга бүрдүүлж байх тухай тусгасан.

⁴ IMF (2011). *Assessing Reserve Adequacy*. IMF Policy Papers.

хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, тогтвортой хадгалах, мөн түүнчлэн эдийн засгийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлж, эдийн засагт тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгоход чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр бодлогын арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлснээр эдийн засаг, санхүүгийн салбарт дарамт багатайгаар, харьцангуй богино хугацаанд гадаад валютын нөөцийг бүрдүүлэх боломж бүрдэх бөгөөд гагцхүү төрийн эрх бүхий байгууллагуудын нягт хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой юм.

3/ “Зээлийн хүү бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах;

Манай орны банкны салбарын зээлийн хүү нь дундаас доогуур орлоготой орнуудын дундажтай харьцуулахад 5 нэгж хувь, Зүүн Ази, Номхон Далайн орнуудын дундажтай харьцуулахад 10 гаруй нэгж хувиар өндөр байна. Зээлийн хүүний одоогийн түвшин нь хөрөнгө оруулалт, бизнес эрхлэлтийг дэмжихүйц түвшинд хүртэл буураагүй хэвээр байна. Иймд Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 70 дугаар тогтоолд ‘Зээлийн хүүг бууруулах стратеги’ боловсруулах үүргийг Засгийн газар, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороонд тус тус өгсөн.⁵

Энэ дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А-167/139/399/37 дугаар тушаалаар “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ийг баталсан. Энэхүү стратеги нь зээлийн хүү буурах макро орчныг бүрдүүлэх, мөнгөний бодлогын хүүний шилжих нөлөөг нэмэгдүүлэх, банкны салбарын эрсдэл даах чадвар, үр ашиг, засаглалын сайжруулахад шаардлагатай эрх зүй, удирдлага, үйл ажиллагааны үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн.

Уг стратегийг хэрэгжүүлэх тодорхой хугацаатай, олон улсын туршлагад суурилсан ажлын төлөвлөгөөг боловсруулж байна. Энэхүү стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Төрийн эрх бүхий байгууллагууд (Засгийн газрын яамд, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпораци зэрэг)-ын хамтын ажиллагаа чухал байгаа тул Улсын Их Хурлын тогтоолд тусгах нь зүйтэй гэж үзсэн болно.

4/ “Чанаргүй активыг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах;

Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн чанар, эргэн төлөлтийг сайжруулах шаардлагатай байна. Банкны салбарын активын чанар муудаж, эргэн төлөлт удаашрах тохиолдолд эдгээр активыг түргэн хугацаанд шийдвэрлэх буюу эргэн төлөлтийг хурдасгах эсвэл актив болон активт хамаарах барьцаа хөрөнгийг бодит үнэ цэнээр борлуулах зах зээлийг бий болгох, холбогдох эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага, хэрэгцээ гарч байна. Эдгээр арга

⁵ "МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын суурь зарчимд банк, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн зээл, хүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх тухай тусгасан.

хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд банкуудын үйл ажиллагааны зардал буурч, банкны зээлийн хүүгийн түвшин буурах нөхцөл бүрдэх юм.

Сангийн Яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Хадгаламжийн даатгалын корпорациас 2018 оны 6 дугаар сард “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”-ийг хамтран баталсан. Энэхүү стратегид чанаргүй активыг бууруулахад хүндрэл учруулж буй асуудлуудыг үр дүнтэй шийдвэрлэх талаар дэлгэрэнгүй байдлаар тусгасан. Үүнд банкуудын чанаргүй активыг шийдвэрлэх чадамжийг сайжруулах, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд үүсч байгаа хүндрэл бэрхшээлийг арилгах, барьцаа хөрөнгийн бүртгэл, татварын зохицуулалтыг боловсронгуй болгож, үүргийн гүйцэтгэлийг хангуулах, чанаргүй активыг худалдан борлуулах зах зээлийг хөгжүүлэх зэрэг асуудалд анхаарал хандуулсан болно.

Уг стратегийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил тутам Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд танилцуулж, ажлын үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардлагатай тохиолдолд тухай бүр өөрчлөлт оруулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллахаар болсон.

5/ Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах эрх зүйн орчинг бий болгож, хэрэгжилтийг хангах чиглэлээр зохих арга хэмжээг авах;

Банк санхүүгийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн байдалд эергээр нөлөөлөх байдлаар зохицуулах нь чухал ач холбогдолтой байна. Олон улсад шинээр бий болж буй стандарт, шилдэг туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх шаардлагатай байна. Үүнд санхүүгийн бүтээгдэхүүний нөхцөл, шаардлагыг илүү ил тод болгох, харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах, өргөдөл, гомдлыг түргэн шуурхай, зардал багатай шийдвэрлэх, улмаар санхүүгийн зуучлалын хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ багтана.

Энэ чиглэлээр олон улсын байгууллагуудаас тухайлбал, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкнаас тодорхой зөвлөмж өгч байсан. Эдгээр зөвлөмжийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай” хуулийн төсөл боловсруулах тусгай ажлын хэсгийг байгуулаад байна. Уг ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ)-ын төлөөллүүд орж ажиллаж байна.

Уг хуулийг боловсруулах ажлын хүрээнд Монголбанкнаас 2018 оны 01 дүгээр сараас 5 дугаар сарын хооронд “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян”-г орон даяар зохион байгуулсан. Аянд СЗХ, ШӨХТГ, Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК), Монголын Ипотекийн Корпораци (МИК), Бичил санхүүгийн хөгжлийн сан (БСХС), Монголын банкуудын холбоо болон арилжааны 14 банкыг оролцуулж, хуулийн төсөлд оруулах асуудлын талаар санал авсан. Эдгээр арга хэмжээний үр дүнд хуулийн төслийг эхний байдлаар боловсруулж, УИХ-д өргөн барих бэлтгэл ажлыг хийж байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Монгол Улсад банк, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тогтолцоог олон улсын туршлага, стандарт, зөвлөмжид нийцүүлэн тогтооно.
- Монголбанк, бусад эрх бүхий байгууллагын хэрэглэгчийн санхүүгийн эрх ашгийг хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.
- Банк, санхүүгийн салбарт маргааныг шүүхийн бус замаар /Санхүүгийн омбудсман/ шийдвэрлэх тогтолцоог бий болгоно.
- Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах асуудлыг санхүүгийн боловсрол олгохтой хавсран хэрэгжүүлнэ.⁶
- Хууль тогтоомжийн дагуу хуулийн төслийг холбогдох бүрдлийн хамт боловсруулж, өргөн мэдүүлэх, батлуулах, ажлын хэсэгт оролцон ажиллах зэрэг арга хэмжээг авна.

6/ Санхүүгийн салбарыг дэмжиж, тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах;

Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, эрх зүйн орчныг сайжруулах, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр “Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр”, Засгийн газраас баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, “Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги” болон “Зээлийн хүүг бууруулах стратеги”-д тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Ялангуяа эдгээр баримт бичигт тусгасан банкны салбараас бусад санхүүгийн салбарт хийх ажлуудын уялдаа холбоог хангаж ажиллах нь зүйтэй. Уг хөтөлбөрүүдэд тусгагдсан ажлыг түргэн шуурхай гүйцэтгэж, цаашид амжилттай үргэлжлүүлэхэд Монголбанкнаас Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй дотоод хэргийн яам болон бусад эрх бүхий байгууллагатай нягт хамтран ажиллах нь чухал юм. Санхүүгийн салбарыг дэмжиж, тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дотоод санхүүгийн эх үүсвэр хангалттай бус байгаа тул Олон улсын байгууллагаас Монголбанк болон бусад эрх бүхий байгууллагад хэрэгжүүлж буй төслийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулах хэрэгцээ нэмэгдэж байна. Хөтөлбөрүүдийн хүрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл шинэчлэн батлуулах хууль тогтоомжтой холбоотойгоор дагалдан боловсруулах шаардлагатай журам, зааврыг боловсруулж, мөрдүүлэх шаардлагатай. Банкны эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үйл ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарын дэд бүтцийг сайжруулах чиглэлээр бусад орны хяналт шалгалтын эрх бүхий байгууллагуудтай хамтран хөтөлбөрт тусгасан хяналт шалгалтын аргачлалыг боловсронгуй болгох, эрсдэлд суурилсан хянан шалгалт хийхэд шаардлагатай хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх зэрэг чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөж байна.

⁶ "Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх стратеги"-ийн 6.2 дахь зорилгод иргэдийг санхүүгээ зохистой удирдах мэдлэг, чадвартай болгох тухай тусгасан.

Монгол Улсын Их Хурлын
2018 оны ... сарын ... –ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

Мөнгөний бодлого нь эдийн засгийн болон санхүүгийн системийн тогтвортой байдлыг бэхжүүлж, санхүүгийн зах зээлийн хөгжлийг хөтлөхөд чиглэнэ.

1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1. Мөнгөний бодлогын зах зээлийн зарчимд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2019-2020 онд жилийн 8 хувь, дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулна.

1.2. Эдийн засгийн дархлааг дэмжих, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.3. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

1.4. Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулж, бодлогын нөлөөг дээшлүүлнэ.

2. Санхүүгийн салбарын тогтвортой байдлын хүрээнд:

2.1. Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлнэ.

2.2. Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдал, эрсдэл даах чадварыг хадгалах зорилгоор банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.3. Олон улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэл, хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

2.4. Банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжилтэд хяналт шалгалт хийх тогтолцоог сайжруулна.

3. Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1. Үндэсний төлбөрийн системийн найдвартай ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн системийн нэгдсэн зохицуулалтыг бий болгох ажлыг үргэлжлүүлнэ.

3.2. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

3.3. Олон улсад мөрдөж буй тогтвортой санхүүжилтийн нийтлэг зарчим, шилдэг туршлагыг нэвтрүүлнэ.

3.4. Банк санхүүгийн салбарт технологийн дэвшил, шинэ ололтыг нэвтрүүлэх замаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулах, мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангахад чиглэсэн дэд бүтцийг хөгжүүлж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2019 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын эдийн засаг, банк, санхүүгийн салбарт өнгөрсөн жилүүдэд тулгарсан олон хүнд сорилтын дийлэнхийг амжилттай шийдвэрлэсний үр дүнд эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдал бэхжиж, ойрын ирээдүйн төлөв сайжирч байна. Гэсэн хэдий ч дунд, урт хугацаанд эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй улсын секторын өрийн дарамтыг бууруулах, гадаад өрийн эргэн төлөлтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, гадаад валютын нөөцийг зохистой түвшинд хүргэж нэмэгдүүлэх, банк, санхүүгийн салбарын эрсдэл даах чадварыг улам сайжруулах шаардлагатай. Үүний тулд макро бодлогуудыг оновчтой хослуулан хэрэгжүүлэх шаардлага хэвээр байгааг харгалзан Мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг боловсруулан, танилцуулж байна.

Манай улсын гадаад эрэлт сайн байгаа боловч цаашид буурах эрсдэлтэй байна. Импортын зардалд том дүн эзэлдэг газрын тосны үнэ өсч байгаа хэдий ч зарим нүүрс болон алтны үнийн бууралт бага байгаа нь манай гадаад худалдааны нөхцөл харьцангуй тогтвортой байхад эерэг нөлөө үзүүлж байна. Мөн уул уурхайн хөрөнгө оруулалт үргэлжлэн тэлж, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн итгэл сэргэж бизнесийн орчин алгуур сайжирч байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт эрчимжиж 6.3 хувьд хүрч, ажил эрхлэлт 3.1 хувиар өсөв.

Инфляци нам түвшинд байх нь иргэдийн бодит орлогыг хамгаалдаг бол инфляци хэлбэлзэл багатай, тогтвортой байх нь бизнесийн макро орчны тодорхой бус байдлыг бууруулдаг. Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг урт хугацааны тэнцвэрт түвшин болох 8 хувийн орчимд тогтворжуулах зорилтыг ирэх онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр Үндсэн чиглэлд тусгалаа. Ийнхүү УИХ-аас баталсан 2018-2020 оны инфляцийн зорилтот түвшин болох 8 хувийг хэвээр хадгалах нь гадаад эрэлт, түүхий эдийн үнийн хэлбэлзэл өндөр байгаа энэ үед эдийн засгийн идэвхжил, ажил эрхлэлтийг бүх салбарын түвшинд дэмжихийн зэрэгцээ инфляцийн хүлээлтийг тогтворжуулахад чухал ач холбогдолтой. Инфляци 2018 оны 8 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд жилийн 6 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд жилийн 6.4 хувьд хүрээд байна. Цаашид эдийн засгийн өсөлттэй уялдан эрэлтийн гаралтай инфляци нэмэгдэх, дэлхийн зах зээл дээрх нефтийн үнийн өсөлттэй холбоотойгоор шатахууны үнэ өсөх зэрэг хүлээлттэй байгаа хэдий ч, нөгөө талаас нийлүүлэлтийн болон нэг удаагийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөө саарснаар инфляци 2018 онд зорилтот түвшний орчимд хадгалагдах төлөвтэй байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар экспорт өсч, төсвийн гадаад санхүүжилт нэмэгдэж, уул уурхайн бүтээн байгуулалт эрчимжихийн зэрэгцээ барааны импорт, тээвэр, санхүүгийн үйлчилгээтэй холбоотой гарах урсгал зардал, гадаад зээлийн хүүний төлбөр өсч, улмаар төлбөрийн тэнцлийн алдагдал өмнөх оноос нэмэгдлээ. Эдийн засагт гарсан эерэг өөрчлөлтүүдээс шалтгаалан өнгөрсөн оноос эхэлсэн төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарах хандлага энэ оны эхний 2 сард үргэлжилсэн боловч ханш эхний хагас жилийн дийлэнх хугацаанд харьцангуй тогтвортой байлаа. Харин импорт тэлж, хүлээгдэж байсан том дүнтэй төлбөрүүд хийгдэж, гадаад өрийн хүүний төлбөр өссөн нь гадаад валютын эрэлтийг нэмэгдүүлж сүүлийн үед төгрөгийн ханш бага зэрэг сулрахад нөлөөлөв. Монголбанк гадаад валюттай харьцах ханшийн уян хатан бодлогыг гадаад зах зээлд бий болсон аливаа өөрчлөлтийн бодит секторт үзүүлэх сөрөг нөлөөг зөөлрүүлэх, экспортын болон импортыг орлох салбарын өрсөлдөх чадварыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, гадаад валютын улсын нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэхэд анхаарна.

Санхүүгийн салбарт хуримтлагдсан эмзэг байдал нь гадаад, дотоод гэнэтийн цочролын нөлөөгөөр сэдэрч, улмаар бодит эдийн засгийн хямралыг даамжруулж, мөчлөгийн далайцыг нэмэгдүүлдэг. Тухайлбал, түүхий эдийн үнийн өсөлт, уналт нь үйлдвэрлэл, ажилэрхлэлтийн түвшинг өсгөх, бууруулах, цаашлаад эдийн засагт халалт эсхүл хүндрэл үүсэх шалтгаан болохоос гадна зарим салбарт зээлийн төвлөрөл өндөр байх эсхүл зээлийн чанар муудах нөхцөл болдог нь эдийн засгийн өнгөрсөн хямрал, хүндрэлүүдээс үлдсэн гол сургамж юм. Үүнээс гадна сүүлийн жилүүдэд банкны салбараас олгосон иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт эрчимжсэнээс өрхийн өрийн дарамт нэмэгдэж иргэд татварын дараах орлогынхоо дийлэнх буюу дунджаар 69-70 хувийг зээлийн төлбөрт зарцуулж, амьжиргааныхаа наад захын хэрэгцээгээ танах эсхүл дахин зээл авах байдлаар зээлийн циклд орох эрсдэл нэмэгдэж байна. Ийнхүү өрхийн өрийн дарамт болон өр, орлогын харьцаа нэмэгдэж байгаа нь эдийн засгийн өсөлт саарч, иргэдийн орлого буурах тохиолдолд банкны салбарын эмзэг байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. Иймээс банк, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлээс сэргийлэхэд макро зохистой бодлогын арга хэмжээг тухай бүр авч банк, санхүүгийн системийн дархлааг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Өмнөх жилүүдэд тохиосон эдийн засгийн хүндрэл банкны зээлийн чанарыг муутгаж, улмаар банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй байдалд сөргөөр нөлөөлсөн. Хэдийгээр эдийн засгийн өнөөгийн болон ойрын төлөв сайжирсан боловч банкны салбарын зээлийн чанар төдийлөн сайжрахгүй байна. Тухайлбал, банкны салбарын хугацаа хэтэрсэн зээлийн өрийн

үлдэгдэл 2018 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 16.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарлаа. Иймээс банкны салбарын тогтвортой байдал, эрсдэл даах чадварыг хадгалах хүрээнд банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээг үргэлжлүүлэх хэрэгцээ, шаардлага хэвээр байна.

Мөнгөний бодлогын шийдвэрийн үр нөлөөг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, институцийг бэхжүүлэх нь санхүүгийн зохицуулагч байгууллагуудын хувьд улам бүр чухал болж байна. Иймээс ирэх онд Монголбанк энэ чиглэлээр холбогдох арга хэмжээг авч, санхүүгийн зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хууль, эрх зүйн зохицуулалтыг олон улсын зарчим, стандартад нийцүүлэх, харилцагч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, банкны салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор банк, санхүүгийн салбарын хууль тогтоомжийг шинэчлэх, сайжруулах хэрэгцээ, шаардлага хэвээр байна. Монголбанк, банк санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэн, шинээр батлагдсан болон шинэчлэн найруулсан нэмэлт, өөрчлөлт орсон холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж, шаардлагатай дүрэм, журмыг шинэчилж, хэрэгжүүлнэ.

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоход байгаль орчин, нийгэмд ээлтэй тогтвортой санхүүжилтийн олон улсад мөрдөж буй нийтлэг зарчмуудыг эдийн засаг, бизнесийн салбар бүрт нэвтрүүлэх нь нэн чухал болж байна. Иймд санхүүгийн зуучлал үзүүлэн бизнес эрхлэгчдийг эргэлтийн болон хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хангадаг банкны бизнест байгаль экологид ээлтэй санхүүгийн бүтээгдэхүүний шинэ стандартыг дунд, урт хугацаанд нэвтрүүлнэ. Уур амьсгалын өөрчлөлт, хөрс-агаар-усны бохирдол, эрчим хүчний эх үүсвэр, байгалийн нөөц, хоол хүнсний хомстол, хүлэмжийн хийн ялгарал зэрэг асуудлууд нь ядуурал, амьжиргааны чанар болон түвшинг дордуулах, эдийн засаг, нийгмийн тогтвортой өсөлтөд сөргөөр нөлөөлж эхлээд байгаа нь дэлхийн нийтийн өмнө тулгарч буй гол бэрхшээл болж байна. Монгол Улсын хувьд байгалийн нөөц, баялагт тулгуурласан эдийн засгийн бүтэц давамгайлж, бидний хэрэглээ, үйл ажиллагаа хүрээлэн буй орчноо доройтуулах, хүлэмжийн хийн ялгаралтыг нэмэгдүүлэн цаашид байгаль экологид сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл өндөр байна. Энэ хүрээнд Монголбанк ирэх оноос эхлэн ногоон зээлийн албан ёсны статистик мэдээллийг нэгтгэн мэдээлэх, банкны тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаанд газар дээр хийх хяналт шалгалтын хамрах хүрээг тодорхойлж, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил хурдтай өрнөж буй энэ үед технологийн дэвшилд тулгуурласан санхүүгийн бүтээгдэхүүн,

үйлчилгээний зарчим, стандартыг тодорхойлж нэвтрүүлэх шаардлагатай байна. Энэ нь банкны харилцагчдын мэдээллийн аюулгүй байдал алдагдах, банкны төлбөр тооцоо болон бусад системийг гадны аливаа халдлагад өртөх эрсдэлээс сэргийлнэ. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд сүүлийн үед эрчимтэйгээр нэвтэрч буй техник, технологийн дэвшил, шинэ ололтууд нь (Финтек) санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хялбар, түргэн шуурхай үзүүлэх, өртгийг бууруулах, улмаар санхүүгийн зуучлалын хүртээмжийг нэмэгдүүлэх давуу талыг олгож байна. Иймд Монголбанкны зүгээс шинэ тутам үүсч буй техник технологийн дэвшлийг банкны салбарт нэвтрүүлэхдээ нийгэм, эдийн засаг, хэрэглэгчдэд үзүүлэх ач холбогдолд анхааран бүтээмж, үр ашигт байдал нэмэгдэхийг дэмжихийн зэрэгцээ системийн тогтвортой байдал, хэрэглэгчийн эрх ашгийг боломжит эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн шаардлагатай зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв сайжирч байгаа хэдий ч Олон Улсын Валютын Сан (ОУВС)-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” дууссаны дараах 3 жилд эргэн төлөгдөхөөр хүлээгдэж буй гадаад өрийн хэмжээ өндөр байгаа нь дунд, урт хугацаанд эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй байна. Иймээс дунд, урт хугацаанд гадаад өрийн дарамтыг бууруулахын тулд төсвийн төлөвийг үргэлжлүүлэн хатуу хадгалахын зэрэгцээ гадаад секторын тэнцвэртэй байдлыг алдагдуулахгүй, тэр дундаа гадаад худалдааны тэнцлийг ашигтай гаргахад чиглэсэн макро эдийн засгийн бодлогын арга хэмжээг цогцоор нь тодорхойлж, ирэх оноос хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Цаашид макро эдийн засагт гарч буй эерэг үр дүнг бэхжүүлэхийн зэрэгцээ үүсч болзошгүй эрсдэлүүдээс сэргийлж, макро эдийн засаг, ажил эрхлэлтийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд макро эдийн засгийн бодлогыг чиглүүлэх шаардлагатай байна. Монголбанкны ирэх жилүүдийн бодлого, үйл ажиллагаа энэхүү зорилтыг хангахад чиглэнэ.

1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

ЗОРИЛТ 1.1

Мөнгөний бодлогын зах зээлийн зарчимд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2019-2020 онд жилийн 8 хувь, дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулна.

Үндэслэл

Эдийн засгийн бүтэц, санхүүгийн салбарын хөгжилтэй холбоотойгоор инфляцийн түвшин өндөр, түүний хэлбэлзэл их байна. Монгол улсын эдийн засаг төрөлжөөгүй, боловсруулах үйлдвэрлэлийн хөгжил сул, экспортын орлогын $\frac{3}{4}$ нь гол гурван бүтээгдэхүүнээс бүрддэг учраас гадаад зах зээлийн өөрчлөлтөд хялбар өртөж, түүнээс улбаалсан тогтворгүй байдал төсөв, санхүүгийн салбар, бодит эдийн засагт үүсч байна. Эдийн засгийн гадаад хүчин зүйлээс хамаарах хамаарал, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хэрэгцээтэй уялдуулан инфляцийг Монголбанк эдийн засгийн тэлэлтийг хүчтэй хязгаарлахгүйгээр, дунд хугацааны тэнцвэр хангагдах, тооцоолсон түвшний орчимд **тогтворжуулах** зорилт дэвшүүлж байна. Энэ нь дунд хугацаанд инфляцийг аажмаар тогтвортой бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Инфляцийг тогтвортой түвшинд хадгалах нь нийгмийн амьжиргаа, иргэдийн бодит орлогыг хамгаалахаас гадна макро эдийн засгийн өрнөл, уналтын савлагааг


бууруулж, тогтвортой байдлыг хадгалах зайлшгүй нөхцөл болдог. Инфляцийн дарамт нь макро эдийн засгийн халалт, хөрөлт үүсэх буюу нийт эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдах эрсдэлийг урьдчилж илэрхийлэх, дохиологч индикаторын үүргийг гүйцэтгэдэг. Тиймээс дунд, урт хугацааны инфляцийн тогтвортой байдлыг зорих нь урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад эдийн засгийн эрэлтийн талын зохицуулалтаар дэмжлэг үзүүлсэн мөнгөний бодлогын хөтөч үзүүлэлт болдог.

Гадаад эрэлт, түүхий эдийн үнэ өндөр хэлбэлзэлтэй үед эдийн засгийн идэвхжил, ажил эрхлэлтийг дэмжихийн тулд УИХ-аас баталсан 2018-2020 оны инфляцийн зорилтот түвшинг ирэх 2 жилийн хувьд хэвээр хадгалж, 2021 оноос инфляцийн зорилтод түвшинг бууруулах нь инфляци, түүний хүлээлтийг эхэлж тогтворжуулаад, цаашид аажмаар бууруулах мөнгөний бодлогын зорилгод нийцтэй юм.

Инфляци, түүний хүлээлтийг тогтворжуулах нь инфляцийг дунд хугацаанд бууруулах зайлшгүй нөхцөл юм. Манай эдийн засаг

гадаад орчноос хамаарал ихтэй, байгаль цаг уурын цочир өөрчлөлтөд өртдөг, гэнэтийн өөрчлөлтийг даван туулах, эсвэл дасан зохицох чадвар сул учраас эдгээрийн үр дагавар инфляцийн тогтворгүй байдлаар илэрдэг (Зураг-1).

Зураг 1. Инфляцийн хэлбэлзэл, түүний зорилтот түвшин



Эх үүсвэр: Монголбанк

Бараа, бүтээгдэхүүний үнэ хэлбэлзэл ихтэй байх нь бизнесээ урт хугацаагаар төлөвлөхөд хүлээлт учруулахаас гадна худалдан авагчдад үнэ хурдан өөрчлөгдөх хүлээлт бүрдүүлнэ. Ирээдүйн үнийн талаарх тодорхой бус байдал их байвал борлуулалтын шат дамжлага бүрт үнэ өсөх бөгөөд инфляцийн хэлбэлзэл нэмэгдэнэ. Ингэж инфляцийн хэлбэлзэл нэмэгдэх тусам бодит эдийн засагт тодорхой бус байдал өснө.

Инфляцийн өндөр хэлбэлзлээс үүсэх үнийн өсөлт нийгмийн амьжиргаанд халгаатай төдийгүй, хүлээлтээр дамжин цаашид хэвээр үргэлжлэх шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл, инфляци өсч, тогтворгүй болсон үед үнэ тогтоох аливаа

шийдвэр нь болзошгүй үнийн өсөлт агуулж, инфляци нэмэгдэнэ. Товчоор хэлбэл, хүлээлтээс шалтгаалан инфляциас инфляци үүсэх болно. Инфляцийг тогтворжуулах нь хүлээлтийг тогтворжуулж, тодорхой бус байдлаас үүсч байгаа үнийн өсөлтийг бууруулах зорилт юм.

Ийнхүү үнэ олон хүчин зүйлс, тэдгээрийн харилцан үйлчлэлээс хамаардаг тул инфляцийн зорилтыг бүрэн хангахад хүндрэлтэй. Зарим төв банк инфляцийн хэлбэлзлийг багтаасан интервал зорилт тавьдаг. Манай улсын хувьд инфляци өмнө дурдсанаар ихэвчлэн бүтцийн эсвэл нийлүүлэлтийн шалтгаантай хэлбэлзэж байна. Эдгээрээс үүдэн үнэ өөрчлөгдөх далайц нь тухайн нөхцөлөөс шалтгаалж өөр өөр байх ба таамаглах боломж хязгаарлагдмал байдаг. Эмпирик судалгаагаар инфляцийн хэлбэлзлийн 50 орчим хувь нь экспортын үнэ, гадаадын хөрөнгө оруулалт зэрэг гадаад хүчин зүйлээс хамаарч байна. Хэдийгээр инфляцийн тал хувь нь гадаад хүчин зүйлсээс хамаарч байгаа хэдий ч Монголбанк эдийн засгийн идэвхжилийг зохистой түвшинд хадгалах эрэлтийн талын зохицуулалтаар дамжуулан инфляцийг бууруулах бодлогоо тогтвортой хэрэгжүүлнэ.

Монголбанк бусад төв банкуудын адилаар эрэлтийг удирдахад чиглэсэн зах зээлийн зарчимд суурилсан хэрэгслүүдийг ашиглан мөнгөний

бодлогыг хэрэгжүүлж байна. Мөнгөний бодлогын хүү санхүүгийн зах дээр богино хугацааны хүүнд нөлөөлж эдийн засгийн идэвхжилийг тэтгэх эсвэл сааруулж инфляцид нөлөөлнө. Инфляци болон эдийн засгийн бусад үзүүлэлтүүдэд үзүүлэх мөнгөний бодлогын нөлөө нэг жилээс цааш хугацаанд үргэлжилнэ. Мөнгөний бодлогын инфляцид үзүүлэх нөлөөллийн үрдүнтэй байдал нь санхүүгийн зах зээлийн төлөвөөр дамжуулан хөрөнгө оруулагчид, худалдан авагчид болон санхүүгийн зах зээлд оролцогчдын шийдвэр гаргалтад хэрхэн нөлөөлөхөөс шууд хамааралтай.


Стратеги

- Монголбанк мөнгөний бодлогын арга хэрэгслийн үйлчлэх цар хүрээ, үзүүлэх нөлөөг харгалзан, хүлээлтийг удирдах, эрэлтийн шинжтэй инфляцийг зохистой түвшинд барих замаар эдийн засгийн өсөлтөөс бий болох нэрлэсэн орлогын өсөлтийг иргэдийн худалдан авах чадварын өсөлт болгоход мөнгөний бодлогоо чиглүүлнэ.
- Монголбанкнаас мөнгөний бодлогын дунд хугацааны үндсэн зорилтыг тодорхойлж, 2019-2020 онд жилийн инфляцийг 8 хувийн орчимд тогтворжуулан 2021 оноос эхлэн аажмаар бууруулахыг чухалчилж байна.
- Түүхий эдийн үнэ, макро эдийн засаг, санхүүгийн салбарт гарч болзошгүй гэнэтийн өөрчлөлтүүд нь инфляци тодорхой хугацаанд зорилтот түвшнээс зөрөх шалтгаан болно. Ийм нөхцөл байдалд шокийн шалтгаан, үр дагавар цар хүрээ, үргэлжлэх хугацаа, үнэ болон инфляцид үзүүлэх нөлөөллийн тооцоонд үндэслэн ирээдүйг харсан мөнгөний бодлогын шийдвэр гаргана.
- Мөнгөний бодлогын төлөвийг өөрчилж буй хүчин зүйл байнга өөр байх тул бодлогын нөлөө мэдрэгдэх хугацаа ялгаатай байна. Хүүний түвшинг өөрчлөх шийдвэр болон түүний бодит хувьсагчдад (үйлдвэрлэл болон ажил эрхлэлт) болон инфляцид үзүүлэх хамгийн их нөлөө шийдвэр гарснаас 4-6 улирлын дараа үзүүлж байна¹. Ийм учраас богино хугацааны нэг удаагийн шинжтэй инфляцийн хөдөлгөөнд хариу үйлдэл үзүүлэх нь үйлдвэрлэлийг бууруулах, хэлцлийн зардлыг нэмэгдүүлэх тул инфляци зорилтоосоо зөрөх зөрүү бүрт Монголбанк бодлогын тохиргоо хийх шаардлагагүй байж болно.
- Мөнгөний бодлогын үр дүн эдийн засгийн бүтцийн онцлогоос хамаарна. Үнийн

¹ Энэ нь эдийн засгийн мөчлөгөөс цаг хугацааны турш өөрчлөгдөж байдаг.

хэлбэлзэл нь дан ганц мөнгөний бодлогоор нөлөөлж болохуйц эрэлтийн хүчин зүйлээс шалтгаалдаггүй бөгөөд нийлүүлэлтийн хүчин зүйлсийн улмаас өөрчлөгдөх нь их байна. Манай хүнсний бүтээгдэхүүний үнэ хэрэглээний сагсны 20 орчим хувийг эзэлдэг бөгөөд хүнсний бүтээгдэхүүний үнэд цаг агаар, ургац хураалт зэрэг мөнгөний бодлогоос хамааралгүй хүчин зүйлс нөлөөтэй байдаг. Мөн зарим импортыг орлох боломжгүй бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ инфляцид шууд нөлөөлдөг.

Зураг 2. Инфляцийн задаргаа



(Нэг удаагийн нөлөө гэдэгт хатуу түлш, хүнсний ногоо болон суудлын машины үнийн огцом өөрчлөлтийг оруулав)

- Иймд нийлүүлэлтийн гаралтай инфляцид мөнгөний бодлогоор нөлөөлөх гэж оролдохгүй бөгөөд түүний хоёр дахь үеийн болон дам нөлөө өндөр үед мөнгөний бодлогын арга хэрэгслийг ашиглана. Учир нь хоёрдахь үеийн болон дам нөлөө өндөр байх нь инфляцийг цаашид эрчимжүүлэх эрсдэлтэй (Зураг-2).
- Засгийн газартай хамтран ажиллаж, макро эдийн засаг болон мөнгөний бодлогын үр дүнг дээшлүүлнэ. Мөнгөний бодлого нийцтэй байх нь тодорхой бус байдлыг бууруулан дотоод эдийн засгийн тогтвортой байдлыг хангахыг зорьж байгаа бөгөөд энэ нь эдийн засгийн агентуудад одоогийн үйл ажиллагаа, ирээдүйн төлөвлөлт хийхэд ойлгомжтой, тодорхой байдлыг бий болгоно.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Монголбанк нь төрийн мөнгөний бодлогын шийдвэрийг Мөнгөний бодлогын хороогоор хэлэлцэн, бие даасан, хараат бусаар хамтын зарчимд тулгуурлан гаргана. Мөнгөний бодлогын хороог жилд 4-өөс доошгүй удаа хуралдуулна. Мөнгөний бодлогын хорооны хурлын товыг оны эхэнд зарлана.
- Эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдал, түүний шинжилгээ, богино болон дунд хугацааны макро эдийн засгийн төсөөлөл, эдийн засагт тулгарч болохуйц эрсдэлүүд, түүн дээр үндэслэсэн хувилбар тооцоолол дээр тулгуурлан Мөнгөний бодлогын хороо шийдвэр гаргана.
- Мөнгөний бодлогын шийдвэр гаргахад ашиглах тооцоо, судалгааны чанарыг сайжруулах хүрээнд;
 - Тоон болон чанарын мэдээллийн баазыг өргөжүүлнэ.
 - Макро эдийн засгийн суурь судалгааны хамрах хүрээг өргөжүүлнэ.
 - Төсөөлөл, симуляци шинжилгээний загваруудыг сайжруулж, шинэ загварыг хөгжүүлнэ.
- Мөнгөний бодлогын шийдвэрийн үндэслэл, хүлээгдэж буй үр дүнг олон нийтэд шуурхай түгээх зорилгоор мөнгөний бодлогын мэдэгдэл, инфляцийн тайлангийн агуулга, хүртээмжийг сайжруулна.

ЗОРИЛТ 1.2

Эдийн засгийн дархлааг дэмжих, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Гадаад валютын улсын нөөц нь ирээдүйд учирч болзошгүй гэнэтийн гадаад сөрөг нөлөөллөөс улс орны эдийн засгийг хамгаалах дархлаа, уг нөлөөг бууруулах баталгаа болж байдаг. 2008-2009 онд тохиосон Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үеэр гадаад валютын нөөц ихтэй улс орнууд хямралыг хохирол багатай давсан байдаг². Харин гадаад валютын нөөцийн хүрэлцээ багатай улс орнууд гэнэтийн гадаад сөрөг нөлөөнд өртсөнөөр хөрөнгийн гадагшлах урсгал нэмэгдэх, хөрөнгө санхүүгийн дансны нөөц нь урсгал дансны алдагдлыг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй болж төлбөрийн тэнцлийн хүндрэл үүсэх нийтлэг дүр зураг ажиглагдаж байв³. Төлбөрийн тэнцлийн хүндрэл үүсэх нь тухайн улсын валютын ханшийг сулруулах, гадаад валютын нөөцийг бууруулах, гадаад өрийг нэмэгдүүлж, өрийн тогтворгүй байдалд хүргэх, бизнесийн идэвхжилийг сулруулах, зээлийн чанарыг муутгах зэргээр

санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг. Гадаад валютын нөөц хүрэлцээтэй байх нь төлбөрийн тэнцлийн хямралын хор хохирлыг бууруулахын зэрэгцээ тухайн улсын зээлжих зэрэглэлтэй шууд хамааралтай үзүүлэлт юм. Гадаадын хөрөнгө оруулагч, зээлдүүлэгчдийн хувьд тухайн улсын гадаад валютын нөөц нь зээл, санхүүжилтийн эргэн төлөлтийн баталгаа болдог тул зээлжих зэрэглэл тогтоох гол шалгуур үзүүлэлтийн нэг болдог.

Монгол Улсын нийт өргөн хэрэглээний барааны 40 орчим хувийг импортын бараа эзэлдэг бөгөөд гадаад өрийн дарамт хэдийгээр буурч байгаа боловч өндөр түвшинд хэвээр байгаа нь гадаад валютын нөөцийг хуримтлуулах хэрэгцээ шаардлагыг улам нэмэгдүүлж байна.

ОУВС-гаас боловсруулсан гадаад валютын албан нөөцийн хүрэлцээт байдлыг тооцох зөвлөмжийн дагуу улс орны гадаад валютын албан нөөц нь (i) гурван сарын импортын бараа, үйлчилгээний хэрэгцээг хангах (ii) зах зээлд дэх мөнгөний нийлүүлэлтийн 20 хувиас багагүй байх (iii) нэг жилийн дотор төлөгдөх гадаад зээлийн төлбөрийг төлөхөд хүрэлцэхүйц байх ёстой. Харин

² IMF (2011). *Assessing Reserve Adequacy*. IMF Policy Papers.

³ Сонгодог банкны хямралын үед банкуудын харилцагчид банкнаас хадгаламжаа маш хурдтай татдагийн адил гадаад валютын нөөц хомс улсын гадаад секторын үзүүлэлтүүд муудахад гадны хөрөнгө оруулагчид оруулсан хөрөнгөө амжиж гадагш шилжүүлэхийг эрмэлздэг.

Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2, 3.3 дахь заалтад *“Гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын нэг жилийн хэрэгцээг хангах хэмжээнээс багагүй түвшинд байлгана. Цаашид нөөцийг нэмэгдүүлэх, удирдлагыг боловсронгуй болгох урт хугацааны арга хэмжээг хэрэгжүүлнэ”* гэж заасан байдаг.

2018 оны 6 дугаар сарын байдлаар Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2,989.4 сая ам.доллар байна. Энэ нь импортын бараа, үйлчилгээний 5.2 сарын хэрэгцээг хангах, М2 мөнгөний нийлүүлэлтийн 41.9 хувьтай тэнцэх, богино хугацаат гадаад өрийн 89.6 хувьтай тэнцэх хэмжээ юм. Дээрхээс үзэхэд гадаад валютын албан нөөцийн хэмжээ Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан хэмжээнээс 43 хувь доогуур, богино хугацаат гадаад өр төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй буюу олон улсын жишиг түвшнээс 10.4 нэгж хувиар бага байна. Түүнчлэн Засгийн газар, төв банкны гадаад өрийн хэмжээ 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар 9.4 тэрбум ам.доллар байгаагийн 20.4 хувь буюу 1.9 тэрбум ам.долларыг богино хугацаат өр бүрдүүлж байна. Дээрх үзүүлэлтэд үндэслэн ОУВС-гаас Монгол Улсын гадаад өрийн дарамт туйлын өндөр байна гэж дүгнэсэн байдаг.

Арилжааны нөхцөлөөр авсан зээл, бондын эргэн төлөгдөх хугацаа

ойртсон үед, эдгээрийг хугацаанд нь барагдуулах шийдэл тодорхойгүй байх нь зээлжих зэрэглэлийг муутгаж, гадаад валютын дотогшлох урсгалыг зогсонги байдалд оруулдаг болох нь 2016-17 онд тодорхой харагдсан. Иймд гадаад валютын албан нөөцийг хангалттай түвшинд хүртэл хуримтлуулах замаар ирээдүйд төлөх гадаад өрийн эргэн төлөлтийн эх үүсвэрийг бүрдүүлж, гадаад хөрвөх чадварыг сайжруулах, үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Стратеги

- Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх хүчин зүйл болсон гадаад хөрөнгө оруулалт орж ирэх таатай макро орчныг бүрдүүлэхийн тулд мөчлөг сөрсөн мөнгөний болон макро зохистой бодлого хэрэгжүүлнэ. Эдийн засгийн дотоод тэнцвэр алдагдахаас сэргийлсэн бодлого нь импортын хэт өсөлтөөр өдөөгдсөн төлбөрийн тэнцлийн дарамтаас сэргийлнэ.
- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь инфляци, эдийн засгийн өсөлт, санхүүгийн тогтвортой байдал зэрэг эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримтална.
- Экспортын үнийн болон гадаад эрэлтийн сөрөг шок

үүсэх тохиолдолд суурь хүчин зүйлстэй нийцтэй валютын ханш нь гадаад худалдааны тэнцэлд дэмжлэг үзүүлнэ.

- Валютын зах дээрх мөнгөн хөрөнгийн урсгалын хугацааны

зөрүүг харгалзан ханшийн богино хугацааны огцом савлагаанаас сэргийлэх нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Төв банкны мөнгөний бодлогын хэрэгслүүдийг боловсронгуй болгож, зах зээл дэх нөлөөг сайжруулна. Үүнд:
 - Гадаад валютын дотоодын захад ашиглаж буй төв банкны хэрэгслүүдийг нөөц хуримтлуулах чиглэлд ашиглах боломжийг судлах, шаардлагатай тохиолдолд өөрчлөх,
 - Банкуудын гадаад зах зээлээс эх үүсвэр татах боломжийг нэмэгдүүлэх үүднээс ам.доллараас бусад валютаар урт хугацаат своп хэлцэл байгуулах талаар судлах, боломж бүрдсэн нөхцөлд нэвтрүүлэх.
 - Ханшийн эрсдэлийг удирдах санхүүгийн үүсмэл хэрэгслийг зах зээлд түгээмэл ашиглах эрх зүйн орчин, дэд бүтцийг бүрдүүлнэ.
- Засгийн газар олон улсын зах зээлээс эх үүсвэр босгоход дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
- Дотоодын санхүүгийн зах дээрх урт хугацаатай хэрэгслүүдийг ашиглан гадаадын хөрөнгө оруулагчдаас эх үүсвэр татах боломжийг бүрдүүлнэ.

Дотоодын зах зээлээс алт худалдан авах ажиллагааг боловсронгуй болгож, худалдан авах алтны хэмжээг нэмэгдүүлнэ.


ЗОРИЛТ 1.3

Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлээс сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Санхүүгийн салбарын эмзэг байдал нь гадаад орчны хувьсамтгай байдлын нөлөөгөөр сэдэрч, улмаар бодит эдийн засгийн хямралыг даамжруулж, мөчлөгийн далайцыг нэмэгдүүлнэ. Банкны эрсдэл даах чадварыг сайжруулах, тогтвортой байдлыг хадгалах, харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Монголбанк микро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг банкны хяналт шалгалтад ашигладаг боловч энэ нь тухайн нэг банкны хувьд тулгарах эрсдэлийг удирдахад чиглэсэн бодлого юм. Олон улсын туршлагаас харахад санхүүгийн системийн эмзэг байдлыг бууруулж, банк, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдах, мөчлөгийн далайц нэмэгдэх эрсдэлийг бууруулахад мөнгөний бодлогыг мөчлөг сөрсөн макро зохистой бодлогын хэрэгслүүдтэй хослуулан хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байна. (Bruno, Shin, & Shim, 2015)

Зураг 3. Бодит эдийн засаг, санхүүгийн мөчлөг



Санхүүгийн мөчлөгийг Drehmann et al (2012) дагуу тооцсон.

Эх сурвалж: Монголбанк


Бодлогын хүүгээр дамжуулан хэрэгжүүлж буй мөнгөний бодлого нь төлбөрийн тэнцлийн савалгаа өндөртэй эдийн засгийн хувьд макро тогтвортой байдлыг хангахад хангалттай биш байдаг. Энэ нь дан ганц мөнгөний бодлогоор дамжуулан бодит бизнесийн мөчлөгт хүчтэй нөлөөтэй санхүүгийн салбарын мөчлөгийг удирдахад хангалтгүй байдагтай холбоотой. Тиймээс санхүүгийн салбарын мөчлөгийг удирдах, түүний мөчлөгийн далайцыг бууруулах, системийн эрсдэл хуримтлагдахаас сэргийлсэн макро зохистой бодлого нь хүүд суурилсан мөнгөний бодлогоор макро тогтвортой байдлыг хангах бодлогын орон зайг нэмэгдүүлж,

бодлогын үр нөлөөг дээшлүүлдэг.

Иймд санхүүгийн системийн эмзэг байдлыг бууруулах, санхүүгийн системийн тодорхой нэг хэсэгт эрсдэл хуримтлагдан улмаар системийн шинжтэй эрсдэл үүсэхээс сэргийлэхэд макро зохистой бодлогыг чиглүүлнэ:

- Банкны салбарын зээлийн төвлөрөл өндөр байна. Уул уурхай, барилга, худалдааны салбарын болон хэрэглээний зээлийн чанар муудаж эдгээр салбарын төлөвөөс хамаарч, банкны системийг эмзэг болгож байна;
- Түүхий эдийн үнэ, гадаад эрэлтийн гэнэтийн өсөлт, уналтыг дагаад санхүүгийн эх үүсвэр уул уурхайн болон уул уурхайн бус салбарын хооронд тогтмол шилждэг. Бүтцийн энэхүү онцлогийн улмаас уул уурхай болон эдийн засгийн бусад салбаруудын өсөлт, ажлын байрны хэлбэлзэл нэмэгдэж, богино хугацаанд эдийн засгийн хүндрэл, даамжраад хямрал болох магадлал нэмэгддэг;

Зураг 4. Эдийн засгийн салбаруудад олгосон зээлийн хувь




Эх сурвалж: Монголбанк

- Сүүлийн жилүүдэд хэрэглээний зээл хурдтай өсч, өрхийн өрийн дарамт нэмэгдсэн. Цаашид өрхийн бодит орлого буурвал иргэдийн төлбөрийн чадвар суларч дагаад зээлийн чанар муудан, нийт хэрэглээ огцом хумигдвал эдийн засгийн уналт болох эрсдэлтэй.⁴ Мөн өрийн дарамт өндөр үед хямралаас гарах хугацаа урт байдаг;
- Дотоод хөрөнгийн эх үүсвэрийн хүрэлцээ муу, гадны хөрөнгө оруулалтаас өндөр хамааралтай учраас эдийн засгийн төлөв байдал нь санхүүгийн салбарын актив, пассивын долларжилт өндөр, гадаад эрэлт, хөрөнгийн урсгалаас өндөр хамааралтай⁵;

⁴ Өрхийн өр, хэрэглээний зээлийн талаар дэлгэрэнгүйг Шигтгээ ...-ээс үзнэ үү.

⁵ Долларжилтын эдийн засагт үзүүлэх нөлөөний талаар дэлгэрэнгүйг Шигтгээ ...-ээс үзнэ үү.

Зураг 5. Хөрөнгийн урсгал болон зээлийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

- Ханшийн эрсдэлийг удирдах санхүүгийн дериватив зах хөгжөөгүйгээс валютаар олгосон зээлийн хувьд зээлдэгч болон банкууд аль аль нь зээлийн болон ханшийн эрсдэлд өртөх эмзэг байдал үүсдэг;
- Хадгаламжийн төвлөрөл өндөр учраас санхүүгийн системд эх үүсвэрийн төвлөрлийн эрсдэл өндөр байна.

Стратеги

Төв банкны тухай хуульд 2018 онд нэмэлт өөрчлөлт орж Монголбанк үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн үүргийн хүрээнд болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх, санхүүгийн мөчлөгийн далайцыг бууруулах, эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх зорилгоор мөчлөг сөрсөн макро зохистой бодлого хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Энэ зорилгоор Монголбанк дараах стратеги баримтлан ажиллана. Үүнд:

- Банкны салбарын эмзэг байдлыг бууруулах, системийн дархлааг нэмэгдүүлэх, гадаад хөрөнгийн урсгалын хэлбэлзлээс бий болох санхүүгийн мөчлөгийн далайцыг бууруулж, улмаар мөчлөг дагасан зээлийн огцом тэлэлтээс сэргийлэх, системийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн мөчлөг сөрсөн макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ. Энэ нь хөрөнгийн урсгалаас үүдсэн хэт халалт, түүний дараах хямралаас урьдчилан сэргийлэх, хямралыг хохирол багатай даван туулах, макро тогтвортой байдлыг хадгалах, инфляцийн зорилтыг хангахад чухал ач холбогдолтой.
- Макро зохистой бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөг урьдчилан тооцох нь бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, сөрөг үр дагаврыг бууруулах, цаг хугацааны хувьд оновчтой шийдвэр гаргах боломжийг нэмэгдүүлэх тул бодлогын урьдач болон дараах шинжилгээ хийх загвар хөгжүүлэх, санхүүгийн салбарын эмзэг байдлыг тодорхойлох шинжилгээний арга зүйг боловсронгуй болгоно.
- Макро зохистой бодлогын шийдвэр, түүний үр дагавар нь санхүүгийн зах зээлд өргөн

хүрээнд, захын оролцогчдын үйлажиллагаанд шууд нөлөөлөх тул Монголбанкны бодлогын шийдвэр гаргах процесс, санхүүгийн бусад зохицуулагч байгууллагуудтай хамтран

ажиллах боломж, бодлогын шийдвэрийг мэдээлэх суваг зэргийг тодорхойлсон макро зохистой бодлогын стратегийг боловсронгуй болгоно..

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Макро зохистой бодлогын тооцоо, шинжилгээнд ашиглах мэдээллийн сан бий болгоно.
- Санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийг үнэлж, макро зохистой бодлогын санал боловсруулж, Мөнгөний бодлогын хороонд танилцуулна.
- Олон улсын шилдэг туршлагыг судалж, өөрийн орны онцлогт нийцсэн макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг нэвтрүүлнэ.
- Макро зохистой бодлогын үр нөлөөг тооцох загвар, шинжилгээний аргуудыг өөрийн орны санхүүгийн системийн бүтэц, онцлог шинж чанарыг тусгасан байдлаар хөгжүүлнэ.
- Макро зохистой бодлогын шийдвэрийг олон нийтэд хүргэх, таниулах стратегийг олон улсын шилдэг туршлагад үндэслэн боловсруулна.
- Макро зохистой бодлогын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс санхүүгийн салбарын зохицуулагч эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

ЗОРИЛТ 1.4

Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулж, бодлогын нөлөөг дээшлүүлнэ.

Үндэслэл

Эдийн засгийн төлөвийн талаарх хүлээлт ямар байхаас зах зээлд оролцогчдын цаашдын үйл хөдлөл, санхүүгийн шийдвэрүүд хамаардаг. Иргэд, аж ахуйн нэгжүүдийн хүлээлт нь хэрэглэх, хадгалах эсвэл эх үүсвэр бүрдүүлэх, хөрөнгө оруулалт хийх шийдвэрүүдийг тодорхойлох тул эдийн засгийн идэвхжил, үнийн түвшинд шууд нөлөөлдөг. Зах зээл дээрх хүлээлт ийнхүү ирээдүйн инфляци, эдийн засгийн өсөлтийг тодорхойлох чухал хүчин зүйл болдог. Иймд төв банк үндсэн зорилтоо хангаж чадах эсэх буюу мөнгөний бодлогын үр дүнтэй байдал нь хүлээлтийг хэрхэн удирдахаас ихээхэн шалтгаална.

Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагаа нь инфляцийг зорилтот түвшин орчимд хадгалан үнийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг хэрэгсэл болдог. Энэ нь (i) Төв банкны үндсэн зорилт, (ii) үндсэн зорилтоо биелүүлэхийн тулд хэрэгжүүлэх мөнгөний бодлогын стратеги, (iii) эдийн засгийн төлөв, түүнтэй уялдуулан гаргасан бодлогын шийдвэрийн үндэслэл, (iv) цаашид үүсч болох эрсдэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг олон нийтэд тайлбарлах үйл ажиллагааны цогц

юм.

Төв банк олон нийттэй харилцах үйл ажиллагаагаар дамжуулан дээрх мэдээллүүдийг олон нийтэд ойлгомжтой, тогтмол давтамжтай, хүртээмжтэй байдлаар тайлбарлан хүргэснээр зах зээл дээрх мэдээллийн тэгш бус байдлыг бууруулдаг. Түүнчлэн, мэдээллийн ил тод байдал нь төв банкинд итгэх итгэлийг дээшлүүлэх ач холбогдолтой. Иймд төв банкны нээлттэй, ил тод байдлыг хангаж, олон нийттэй харилцах үйл ажиллагааг үр ашигтай, зөв зохистой байдлаар хөгжүүлснээр бодлогын арга хэмжээний үр нөлөө нэмэгдэнэ.

Стратеги

Монголбанкны олон нийттэй харилцах үйл ажиллагаанд олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлнэ. Үүнд:

1. Олон нийтэд хүргэх мэдээллийн агуулгын хөгжүүлэлт

- Төв банкны үндсэн зорилт, хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын арга хэлбэр, бодлогын шийдвэрийн үндэслэлийг олон нийтэд мэдээлэхдээ олон улсын жишигт нийцсэн арга хэлбэрээр хүргэнэ.
- Төв банкны эдийн засагт гүйцэтгэх үүрэг, оруулах хувь нэмэр, үнийн тогтвортой

байдлын ач холбогдлыг олон нийтэд ойлгомжтой, энгийн хэлбэрээр тайлбарлан таниулна.


2. Мэдээлэл түгээх үр дүнтэй сувгуудын хөгжүүлэлт

- Мэдээллийг хурдтай бөгөөд хүртээмжтэй хүргэх орчин үеийн технологийн дэвшилд тулгуурласан сувгуудыг ашиглана.
- Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагаанд ашиглаж буй хэвлэмэл бүтээгдэхүүн, цахим хуудас болон бусад сувгийг олон улсын шилдэг туршлага, мэдээлэл хүлээн авагчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэх зорилгоор тогтмол хөгжүүлнэ.

3. Зорилтот бүлгүүдийн оновчтой ангилал

- Төв банкнаас өгөх мэдээ, мэдээллийг санхүүгийн зах зээлийн оролцогчид, төрийн шийдвэр гаргах байгууллагууд, судалгааны болон хэвлэл мэдээллийн байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгжүүд тус бүрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон хэлбэрээр түгээнэ.
- Төв банк, зорилтот бүлгүүдийн онцлог (нас, боловсрол мэргэжил, газарзүйн байршил зэрэг)-ийг нарийвчлан тодорхойлсны үндсэн дээр тохирсон арга хэлбэрээр мэдээллийг түгээнэ.

Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагааны бүдүүвч



ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Инфляцийн зорилтыг хангах, хүлээлтийг удирдах зорилгоор олон нийтэд мэдээлэл түгээх арга хэлбэрийг боловсронгуй болгоно. Энэ ажлын хүрээнд сургалт зохион байгуулах, түүвэр судалгаа хийх, мэдээллийн сувгуудыг оновчтой байдлаар ашиглах арга хэмжээг авна.
- Мөнгөний бодлогын шийдвэр, түүний үндэслэл, үр нөлөөг олон нийтэд хүргэх сувгуудыг хөгжүүлэх. Үүнд:
 - Мөнгөний бодлогын шийдвэрийг олон нийтэд тайлбарлах үндсэн хэрэгсэл болох инфляцийн тайлангийн агуулгыг сайжруулж, хүртээмжийг дээшлүүлнэ;
 - Мөнгөний бодлогын мэдэгдлийг олон улсын шилдэг туршлагатай нийцүүлнэ;
 - Мөнгөний бодлогын шийдвэрийг танилцуулах хэвлэлийн хурлыг тогтсон хуваарийн дагуу зохион байгуулна;
 - Төв банкны олон нийттэй харилцах үйл ажиллагаанд ашиглаж буй сувгуудын үр дүнтэй байдалд үнэлгээ хийж, оновчтой сувгуудыг тодорхойлно;
 - Мэдээлэл түгээх орчин цахим хэлбэрт эрчимтэй шилжиж байгаатай холбоотойгоор мэдээллийг үр дүнтэй түгээх технологийн дэвшлүүдийг ашиглана;
 - Орон нутагт мэдээлэл түгээх үр дүнтэй сувгуудыг хөгжүүлнэ;
- Мөнгөний бодлого, эдийн засгийн бусад бодлогын уялдааг хангах, хэрэгжилтийг олон нийтэд тайлбарлаж таниулахад эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана;

2. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

ЗОРИЛТ 2.1

Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлнэ.

Үндэслэл

Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээл эрчимтэй хөгжиж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ олноор нэвтэрч байгаа тул эрх зүйн орчинг боловсронгуй болгох, харилцагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр зохицуулалт бий болгох шаардлага байна. Энэ талаар Улсын Их Хурлын 2016 оны 68 дугаар тогтоол, 2017 оны 11 болон 70 дугаар тогтоол, түүнчлэн 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-т энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ авахыг үүрэг болгосон.

Үүний дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар “Банкны салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд дараах хуулиудыг Улсын Их Хурлаас баталсан. Үүнд:

- Үндэсний төлбөрийн системийн тухай хууль
- Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай хууль

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль зэрэг болно.
- Эдгээр хуулийг дагалдан гарах дүрэм, журам, эрх зүйн актыг шинээр боловсруулан, хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлж байна.
- Цаашид санхүүгийн салбарын дэд бүтцийг сайжруулах, валютын зохицуулалтыг боловсронгуй болгох, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр эрх зүйн шинэтгэлийг төрийн эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Стратеги

- Валютын зах зээлийн зохицуулалтыг сайжруулан үр ашгийг нь нэмэгдүүлэх, банк хоорондын захыг идэвхжүүлэх, санхүүгийн үүсмэл хэрэгсэлтэй холбоотой олон улсын шилдэг туршлагыг

нэвтрүүлэх, төлбөр тооцооны болон ханшийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

- “Чанаргүй активыг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд, актив удирдлагын хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх, хувийн хэвшилд суурилсан чиг үүрэг бүхий актив удирдлагын мэргэшсэн институцийг бий болгох, барьцааны зүйлээр зээлдүүлэгчийн шаардлагыг богино хугацаанд хангуулах, өр төлбөрийг шүүхийн журмаар түргэн шуурхай барагдуулах, татварын дарамтыг бууруулах чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага, стандартыг шинэчлэн тогтоох замаар санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, маргаан үүссэн тохиолдолд тэдгээрийг үр дүнтэй шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудлыг тусгасан хууль, эрх зүйн актыг эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулж Улсын Их Хуралд

өргөн барина.

- Эрдэнэсийн сангийн эрх зүйн зохицуулалтыг Соёлын өвийг хамгаалах тухай хуультай нийцүүлнэ. Энэ ажлын хүрээнд төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагын эрх, үүргийг тодорхой болгох, түүх, соёлын өвийг Эрдэнэсийн санд шилжүүлэх шаардлагыг шинэчлэн тогтоох чиглэлээр хуулийн төслийг эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулна. Вексель болон түүнтэй адилтгах төлбөрийн хэрэгслийг зүй бусаар ашиглах эрсдэлийг бууруулах зорилгоор Векселийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх арга хэмжээг төрийн эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд орсон нэмэлт, өөрчлөлтийг дагалдан гарах дүрэм, журам, эрх зүйн актыг батлан хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. Үүнд Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийх хяналт шалгалтыг боловсронгуй болгох, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зэрэг асуудалд онцгой анхаарал хандуулна.

ЗОРИЛТ 2.2

Банк санхүүгийн салбарын тогтвортой байдал, эрсдэл даах чадварыг хадгалах зорилгоор банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Монгол Улс “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид тус хөтөлбөрт тусгасан зорилтуудыг шат дараатайгаар, шуурхай хангахаар ажиллаж байна. Энэ хүрээнд Монгол Улсад анх удаа банкуудын активын чанарт иж бүрэн, хараат бус үнэлгээг амжилттай хийлгэж, үр дүнг олон нийтэд танилцуулсан. Түүнчлэн Банкны тухай хуульд 2018 оны 2 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд уг хуулиар банкинд авч хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх болон албадлагын арга хэмжээний цар хүрээг өргөжүүлж, Монголбанкны холбогдох эрх мэдэл, хариуцлагыг нэмэгдүүлсэн.

Монголбанкнаас хийлгэсэн Активын чанарын иж бүрэн үнэлгээгээр өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан банкуудаар хөрөнгийн дутагдлыг нөхөх ажлын төлөвлөгөөг гаргуулах, төлөвлөгөөг үндэслэлтэй эсэх талаар үнэлэлт, дүгнэлт өгөх болон хөрөнгийн дутагдлыг нөхөх хугацаатай үүрэг даалгаврыг өгч ажиллаж байна. Энэ хүрээнд холбогдох банкуудад тогтмол хяналт тавих, үүрэг

даалгаврын хэрэгжилтийг үнэлэх шаардлага гарч байна. Банк тус бүрээс ирүүлсэн төлөвлөгөөнд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох нь банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулах, банкныг хүндрэлээс богино хугацаанд гаргах, төлбөрийн чадварыг шуурхай сэргээхэд чухал ач холбогдолтой байна.

Цаашид “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т санхүүгийн салбарын бодлоготой холбоотой тусгагдсан шаардлагыг хангах, өөрийн хөрөнгийн дутагдлыг заасан хугацаанд нөхөж чадаагүй системд нөлөө бүхий банкны хувь эзэмшлийг “Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай” хуульд заасан шаардлагын дагуу түр хугацаагаар өөрчлөх замаар банкны салбарт учирч болзошгүй байсан хүндрэлээс сэргийлэх нөхцөл бүрдээд байна. Нөгөө талаас, системд нөлөө бүхий банкнаас бусад банкинд гарсан аливаа хүндрэлийг шинээр баталсан “Банкны тухай хууль”-д заасан албадлагын арга хэмжээний дагуу шийдвэрлэх боломжтой болсон.

Ази Номхон далайн бүсийн байгууллагаас Мөнгө угаах,

терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлд санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, банк санхүүгийн байгууллага болон олон нийтийн ойлголтыг сайжруулах зорилгоор банк, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг эрсдэлд суурилсан аргачлалд шилжүүлэх талаар зөвлөмжийг манай улсад өгөөд байна.

Түүнчлэн банкууд дахь чанаргүй зээлийн эргэн төлөлтийг хангуулах, төлбөр барагдуулах хугацааг богиносгох, барьцаа хөрөнгийн үүргийн гүйцэтгэлийг түргэтгэх, банкуудаас гарах зардлыг бууруулах, улмаар зээлийн хүү буурах нөхцөлийг

бүрдүүлэх хүрээнд “Чанаргүй зээлийг бууруулах стратеги”-ийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2018 оны 6 дугаар сард баталсан.

Стратеги:

- “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн санхүүгийн салбарын бодлоготой холбоотой тусгагдсан шаардлагын хэрэгжилтийг хангана.
- Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөрийн чадварыг сайжруулах арга хэмжээг Банкны тухай хууль, тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Активын чанарын иж бүрэн үнэлгээгээр тогтоосон өөрийн хөрөнгийн дутагдлыг заасан хугацаанд нөхөөгүй банкинд хуульд заасан арга хэмжээг шат дараатайгаар авч хэрэгжүүлнэ.
- Банкны өөрийн хөрөнгийн дутагдлыг төрөөс дахин хөрөнгөжүүлэх замаар шийдвэрлэсэн нөхцөлд холбогдох үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар хэрэгжүүлэн төрийн эрх бүхий байгууллагын ажлын уялдааг хангана.
- Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх үүднээс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг төрийн эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- Банкуудад хуримтлагдсан чанаргүй активын эргэн төлөлтийг нэмэгдүүлж, активын чанарыг сайжруулах зорилго бүхий “Чанаргүй зээлийг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана.

ЗОРИЛТ 2.3

Олон улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэл, хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

Үндэслэл

Банкны салбарын эрсдэл даах чадварыг оновчтой тогтоох, санхүүгийн салбарын оролцогчдыг үнэн зөв мэдээллээр хангахад олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг мөрдүүлэх нь чухал юм. Тухайлбал, банкны өөрийн хөрөнгө болон бусад эрсдэлийн үзүүлэлтийн доод шаардлага, үр нөлөөтэй хяналт шалгалтын зарчмыг тусгасан Базелийн цуврал стандартыг нэвтрүүлэх, банкуудад хяналт шалгалтын хүрээнд одоо мөрдүүлж буй журам, зааврыг шинэчлэх шаардлагатай байна.

Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл (IASB)-өөс баталсан “Санхүүгийн хэрэгслийг ангилах, хэмжих, түүний үнэ цэнийн бууралтыг тооцох” тухай Санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандарт (СТОУС/ IFRS 9)-ыг 2018 оноос эхлэн дэлхий нийтээр даган мөрдөх болсонтой холбогдуулан Банкуудын үйл

ажиллагаа, санхүүгийн тайлагналд уг стандартыг мөрдүүлэх цар хүрээ, хугацааг тодорхойлох, банкны зүгээс бэлтгэл ажлыг хангуулах шаардлага гарч байна.

Дээрх стандартуудыг нэвтрүүлснээр банкуудын төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн болон бусад эрсдэлийн үзүүлэлтэд үзүүлэх нөлөөлөл болон шинээр гарах хөрөнгө, зардлын тооцоо зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр уг стандартыг мөрдүүлэх нь зүйтэй юм.

Стратеги

- Банкинд мөрдүүлэх нягтлан бодох бүртгэлийн стандартыг Санхүүгийн тайлагналын олон улсын шинэ стандарттай нийцүүлнэ.
- Банкны зохистой харьцаа, төлбөрийн чадварын үзүүлэлт болон хяналт шалгалтын хүрээнд банкуудад тавих шаардлагыг Базелийн цуврал стандарттай нийцүүлнэ.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Базелийн цуврал стандартыг банкны салбарт нэвтрүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлж, банкны салбарт үзүүлэх нөлөөллийн шинжилгээг хийнэ.
- Банкуудад мөрдүүлэх нягтлан бодох бүртгэлийн багц материал болон зааврыг Санхүүгийн тайлагналын олон улсын шинэ стандарттай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх бэлтгэл ажлыг хангана.
- Олон улсад нийтээр мөрддөг хяналт шалгалт, зохистой харьцааны зарчим, стандартыг Монголын санхүүгийн салбарын онцлогт нийцүүлэн нэвтрүүлж, мөрдүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.

ЗОРИЛТ 2.4

Банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжилтэд хяналт шалгалт хийх тогтолцоог сайжруулна.

Үндэслэл

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” чиглэл шинээр нэмэгдсэн. Ингэснээр банкны салбарын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн шаардлагатай зохицуулалт, бодлогын арга хэмжээг Монголбанк хэрэгжүүлэх боломжтой болсон.

Санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах асуудал нь нэг чухал хүчин зүйл болохыг 2008 оны санхүүгийн хямралын дараа олон улс орон хүлээн зөвшөөрч, цаашид хөгжүүлэх шаардлагатай гэж үзэх болсон.

Банк, санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээлэл санхүүгийн хэрэглэгчдэд дутмаг байдгаас санхүүгийн эрсдэл хүлээх, хохирох тохиолдолд цөөнгүй гардаг. Иймээс хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, шаардлагатай бодлогын арга хэмжээг авахаар

Монголбанкнаас төлөвлөж байна.

Монгол Улсад банкны салбарт банкны харилцагч буюу хэрэглэгчийг хамгаалах зохицуулалт, хяналт шалгалт хангалттай түвшинд хөгжөөгүй байна. Одоогоор мөрдөн буй банкны тухай хууль тогтоомжийн хүрээнд Монголбанкнаас авч хэрэгжүүлэх хяналт шалгалтын үйл ажиллагаа нь банкны төлбөрийн чадварыг хангах, тогтвортой үйл ажиллагаа алдагдах, төлбөрийн чадварын эрсдэлд орохоос сэргийлэхэд чиглэдэг. Харин санхүүгийн байгууллагаас хэрэглэгчдэд үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, эрх ашиг нь зөрчигдсөн хэрэглэгчдийг хамгаалах тогтолцоог бий болгох хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байна.

Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага болон Их 20-ын улс орнуудаас гаргасан санхүүгийн салбарт хэрэглэгчийг хамгаалах зарчим, Дэлхийн банк болон Азийн Хөгжлийн банкны зөвлөхийн өгсөн зөвлөмжийг Монголбанк дэмжиж, хэрэгжүүлнэ.

Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог оновчтой бүрдүүлснээр санхүүгийн

байгууллагаас бүтээгдэхүүн үйлчилгээг үнэн зөв, хялбар, хүртээмжтэй байдлаар хангаж, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад шууд нөлөө үзүүлэх юм.

Түүнчлэн Монголбанкинд санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах бүрэн эрхийг хуулиар олгох⁶ буюу хэрэглэгчийг хамгаалах хяналт шалгалтын бие даасан нэгжийг бий болгож, энэ хүрээнд банкинд тавих шаардлага, стандартыг тусгасан журам, зааврыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих талаарх Олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд Монгол Улсад “Санхүүгийн омбудсман” буюу санхүүгийн байгууллага, хэрэглэгчдийн хооронд үүссэн санхүүгийн маргааныг богино хугацаанд үр дүнтэй, чирэгдэл багатай шийдвэрлэх байгууллагын үйл ажиллагааг бий болгож, санхүүгийн хэрэглэгчдийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх нь чухал байна.

Стратеги

- Олон улсын зөвлөхөөс банкны салбарт санхүүгийн хэрэглэгчийг хамгаалахад өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.
- Монголбанк банкны салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг санхүүгийн боловсролыг сайжруулах зэрэг алхмуудтай хамтатган хэрэгжүүлснээр санхүүгийн үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох боломжийг нээнэ.
- Банкны салбарт хэрэглэгчийн эрхийг хамгаалах дүрэм, журмыг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий бие даасан нэгж/газар бий болгоно.

⁶ Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 12-нд батлуулсан.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Банкуудын бүтээгдэхүүний ерөнхий болон тодорхой болзол, нөхцөлийг хэрэглэгчдэд хүртээмжтэй болгох зохицуулалтын шаардлагыг нэвтрүүлнэ.
- Бүтээгдэхүүн санал болгох, эсвэл зээл олгохын өмнө хэрэглэгчдийн тухай хангалттай мэдээлэл цуглуулах талаар банкуудад тавих шаардлагыг батална.
- Монголбанкнаас банкинд тавих шаардлагыг: дансны хуулгыг харилцагчдад тогтмол хүргүүлэх, хураамж болон бусад гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах аливаа санал болгож буй өөрчлөлтийг харилцагчид заавал бичгээр урьдчилан мэдэгдэх, хэрэглэгчийн хувийн мэдээллийг хадгалах, хамгаалах, хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүй байх, гомдол түргэн шуурхай шийдвэрлэх гэх мэт батлан мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавина.

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

ЗОРИЛТ 3.1

Үндэсний төлбөрийн системийн найдвартай ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн системийн нэгдсэн зохицуулалтыг бий болгох ажлыг үргэлжлүүлнэ.

Үндэслэл

Дотоод болон хил дамнасан төлбөр тооцоог түргэн шуурхай, үр ашигтай байдлаар гүйцэтгэх, холбогдох дэд бүтцийг бий болгох, тасралтгүй ажиллагааг хангах нь Үндэсний төлбөрийн системийн үндсэн зорилго юм.

Монголбанкнаас төлбөрийг найдвартай, түргэн шуурхай гүйцэтгэх үр ашигтай механизмыг бүрдүүлэх, цахим төлбөрийн хэрэгслийн давуу талыг ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Монголбанк төлбөр тооцооны системд хяналт тавих, үнэлгээ хийх, холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх замаар төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг ханган ажиллаж байна.

Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгосноор “Финтек” технологи дээр суурилсан аж ахуйн нэгж, байгууллагыг хөгжүүлэхэд түлхэц үзүүлээд байна.

“Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн хүрээнд төлбөрийн системийн оролцогч хоорондын

бага дүнтэй гүйлгээг боловсруулах клирингийн системийг 2019 онд шинээр нэвтрүүлснээр гүйлгээний нэр төрөл нэмэгдэх, гүйлгээний нууцлал аюулгүй байдал сайжрах, улмаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Олон улсын төлбөр тооцооны банкнаас гаргасан “Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд”-ын хэрэгжилтийг төлбөр тооцооны системүүд хэрхэн хангаж байгаад үнэлгээ хийж байна. Энэ үнэлгээний үр дүнд суурилан эдгээр зарчмын хэрэгжилтийн түвшинг ахиулна.

Монгол Улсын төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг дэмжих, хяналтын чадавхыг бэхжүүлэх, хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлд олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана. Үүнд төлбөрийн системтэй холбоотой дүрэм, журам, зааврыг хуульд нийцүүлэн боловсронгуй болгох арга хэмжээ авна.

Стратеги

- Үндэсний төлбөрийн системийн найдвартай ажиллагааг ханган ажиллана.
- Төлбөрийн системд банкнаас бусад байгууллага оролцох боломжийг хангах замаар бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээг дэмжиж, санхүүгийн
- хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хүрээнд төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний эрх зүйн зохицуулалтын орчинг боловсронгуй болгоно..

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Үндэсний төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, оролцогчдын тэгш, тэнцвэртэй оролцоо, системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтлан төлбөрийн системд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.
- Төлбөрийн системийн бодлого тодорхойлох, хяналт тавих үүрэг бүхий болон төлбөрийн системийн үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын байгууллагатай хамтарч ажиллана.
- “Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд”-ын хэрэгжилт нь “Банксүлжээ” системд хэрхэн хангагдаж байгааг тодорхойлж, үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээ авна.
- Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хүрээнд төлбөрийн систем, төлбөрийн хэрэгсэл, төлбөрийн үйлчилгээний эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, холбогдох журам, заавар, баримт бичгийг боловсруулна.

ЗОРИЛТ 3.2

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

Үндэслэл

Иргэдийн эдийн засгийн болон санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, мөнгөний бодлогын шийдвэр, түүний үндэслэлийг тайлбарлах нь макро эдийн засгийн төлөвийн талаарх олон нийтийн хүлээлтийг удирдахад чухал ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд банкны салбар эрчимтэй хөгжиж санхүүгийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ олноор нэвтэрч байна. Банкны зарим харилцагчийн хувьд эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл, ойлголт дутмаг байгаагаас шалтгаалж өөрийн хэрэгцээнд нийцсэн сонголтыг хийж чадахгүй байх тохиолдол гарсаар байна. Энэ нь банкны харилцагчийг дунд болон урт хугацаанд санхүүгийн хүндрэлд орох эрсдэлийг бий болгож байна.

Иймд олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах шаардлага гарсаар байна. Энэ хүрээнд Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх

ухаан, спортын яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байна. Үүнээс гадна Засгийн газраас 2017 онд баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ тусган хэрэгжүүлж байна.

Стратеги

“Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг дараах 4 тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад санхүүгийн мэдлэг олгох;
- Оюутан, залуучуудад санхүүгийн мэдлэг олгох;
- Орон нутаг, суурин газраас алслагдсан иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
- Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох..

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгоно:

- БСШУСЯ-ны ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгасан сонгон судлах “Бизнес судлал” хичээлийн хүртээмжийг дээшлүүлнэ;
- Санхүүгийн мэдлэг түгээх арга хэмжээг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ;

Их дээд сургуулиудын оюутнуудын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлнэ:

- “Хувь хүний санхүү” хичээлийг мэргэжил харгалзахгүйгээр их дээд сургуулиудад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;

Хөдөө, орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлын хүрээнд:

- Санхүүгийн мэдлэг түгээх сургагч багш нарыг бэлтгэнэ;
- Энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана;

Бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох арга хэмжээг үргэлжлүүлнэ.

Олон нийтэд санхүүгийн суурь мэдлэг олгох сургалтыг цахим хуудас болон шинэлэг технологид суурилсан арга хэрэгслээр олгож, хүртээмжийг сайжруулна. Үүнд сургалтын нэр төрөл, арга хэлбэрийг нэмэгдүүлэх асуудалд анхаарч ажиллана.

ЗОРИЛТ 3.3

Олон улсад мөрдөж буй тогтвортой санхүүжилтийн нийтлэг зарчим, шилдэг туршлагыг нэвтрүүлнэ.

Үндэслэл

Эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих үүднээс тогтвортой санхүүжилтийн⁷ олон улсын зарчмыг нэвтрүүлэн хэрэгжүүлэх шаардлага өндөр байна.

Үүнд төв банкны оролцоо чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь дараах хүчин зүйлстэй холбоотой юм. Үүнд: (i) байгаль, цаг уурын гамшиг санхүүгийн салбар болон макро эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг; (ii) зах зээл дээр үүсээд байгаа гажуудлыг хувийн хэвшил дангаар зохицуулж чадахгүй байгаа нөхцөлд төрийн оролцоо зайлшгүй шаардлагатай байдаг.

Иймд Монголбанкнаас энэ асуудалд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. Тухайлбал, 2013 оны 11 дүгээр сард “Монгол Улсын нийгэм, байгаль орчинд ээлтэй Тогтвортой санхүүжилтийн бодлогыг хөгжүүлэхийн төлөөх хамтарсан тунхаг бичиг”-ийг Монголбанкны дэмжлэгтэйгээр баталсан. Энэ тунхаг бичигт Монголын бүх арилжааны банкууд гарын үсэг

зурж, “Монгол Улсын Тогтвортой Санхүүжилт (ТоС)-ийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр тохиролцсон.

Цаашид банкуудаас олгож буй тогтвортой санхүүжилтийн үр дагаврыг бодитойгоор үнэлэх үүднээс Монголбанкнаас банкуудад хийх хяналт шалгалтын дүрэм журмыг боловсронгуй болгохоор төлөвлөж байна. Үүнд байгаль орчинд сөрөг үр дагавартай төсөл, хөтөлбөрийг банкуудаас санхүүжүүлэхгүй байх, эрчим хүчний хэмнэлтийг бий болгох асуудлуудад онцгой анхаарал хандуулж байна.

Стратеги

- Тогтвортой санхүүжилтийн зарчмыг нэвтрүүлэх ажлын хүрээнд банкуудын эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээг авна.
- Монголбанкнаас тогтвортой санхүүжилт (жишээ нь, ногоон зээл)-ийн статистик мэдээллийн санг бий болгож, олон нийтэд мэдээлнэ.

⁷ “Тогтвортой санхүүжилт” гэдэгт аливаа банк, санхүүгийн байгууллага нь хөрөнгө оруулалт хийх, зээл олгох болон аливаа санхүүгийн шийдвэр гаргахдаа тухайн бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг харгалзах, сөрөг үр дагавар үүсгэхээр бол түүнийг бууруулах арга хэмжээ авах, ноцтой хохирол учруулж болзошгүй бол санхүүжүүлэхээс татгалзах шийдвэр гаргах, түүнчлэн байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, хөтөлбөрийг дэмжин ажиллах тухай ойлгоно.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Тогтвортой санхүүжилтийн тодорхойлолт, ногоон санхүүжилт, ногоон зээлд тавих тусгайлсан шалгуурыг олон улсын шилдэг туршлагад үндэслэн тогтооно.
- Тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаанд Монголбанкнаас хийх хяналт шалгалтын дүрэм, журам, зааврын батлан хэрэгжүүлнэ.
- Ногоон зээлийн статистик мэдээллийн санг бий болгож, мэдээллийг олон нийтэд түгээнэ.
- Олон улсын байгууллагаас тогтвортой санхүүжилтийг дэмжих чиглэлээр олгож буй эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.

ЗОРИЛТ 3.4

Банк санхүүгийн салбарт технологийн дэвшил, шинэ ололтыг нэвтрүүлэх замаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулах, мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангахад чиглэсэн дэд бүтцийг хөгжүүлж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

Үндэслэл

Санхүүгийн салбарын үйл ажиллагаанд сүүлийн үед эрчимтэй нэвтэрч буй техник, технологийн дэвшил (Финтек) нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх боломжийг бий болгож байна. Монгол улсын хувьд эдгээр техник технологийг нэвтрүүлснээр төлбөр, тооцооны үйлчилгээг хэрэглэгчдэд түргэн шуурхай үзүүлэх, холбогдох өртөг, зардлыг бууруулах, улмаар санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэх бололцоотой болно.

Энэ хүрээнд Монголбанкнаас үндэсний төлбөрийн “F карт”-ыг олон улсын EMV/NFC технологид суурилсан чиптэй болгон хөгжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Ингэснээр төлбөр, тооцоог интернет, мобайл болон QR технологи ашиглан шуурхай гүйцэтгэх, Финтек-д суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх боломж бүрдэж байна.

Үүнд төлбөрийн системд банкнаас бусад санхүүгийн байгууллага болон технологийн компанийг оролцуулах нь чухал ач холбогдолтой байна.

Түүнчлэн банкууд шинэ технологийг дотоод бэлтгэл, холбогдох шаардлага, стандартыг бүрэн хангахгүйгээр нэвтрүүлснээр харилцагчдын мэдээллийн аюулгүй байдал алдагдах, банкны төлбөр тооцооны систем гадны халдлагад өртөх зэрэг эрсдэл бий болж болзошгүй байна.

Иймд Монголбанкны зүгээс шинэ техник технологи нэвтрүүлэх зөвшөөрөл олгохоос өмнө нийгэм, эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөг үнэлж, үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Монголбанкнаас зээлийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох ажлыг олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна. Энэ ажлыг хэрэгжүүлснээр банкны эрсдэлийн удирдлага сайжирч, банкнаас хувийн хэвшилд олгох санхүүжилтийн өртөг, зардал буурах бололцоо бүрдэнэ.

Төлбөрийн системийн шинэчлэлийн хүрээнд санхүүгийн систем дэх тоон гарын үсгийн системийг шинээр нэвтрүүлснээр

хэрэглэгчийг танихтай холбогдуулан банк тус бүр дээр гардаг зардал буурах, түүнчлэн хэрэглэгч нь ганц тоон гарын үсгээр бүх төрлийн санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломжтой болно. Тоон гарын үсгийн системийг “Токен” болон гар утасны “Сим карт”-нд суулгах боломжтой тул ашиглахад хялбар байх юм.

Стратеги

- Монголбанкны зээлийн мэдээллийн үйл ажиллагаанд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн дэвшилтэт мэдээллийн технологи, программ хангамжийг нэвтрүүлж, зээлийн мэдээллийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар банкны салбарын санхүүгийн зуучлал, үйл ажиллагааны зардлыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Төлбөрийн “₮ карт”-ын дэд бүтцэд технологийн шинэчлэл хийх картын нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах.
- Төлбөр тооцооны цахим хэлбэрийг нэмэгдүүлэх замаар бэлэн бус төлбөр тооцоог дэмжих.
- Төлбөрийн системд банкнаас бусад байгууллага оролцох боломжийг хангах замаар шинэ төлбөрийн үйлчилгээ, санхүүгийн технологийн хөгжлийг дэмжих..

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Үндэсний төлбөрийн Т картын нууцлал, аюулгүй байдлыг сайжруулна.
- Төлбөрийн системд банкнаас бусад байгууллага оролцох боломжийг нэмэгдүүлж, нээлттэй болгох зорилгоор дүрэм, журмыг баталж мөрдүүлнэ.
- Зээлийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд мэдээллийн технологийн дэвшил бүхий программ хангамжийг нэвтрүүлнэ.
- Нэгдсэн тоон гарын үсгийн систем хөгжүүлж цахим төлбөр тооцооны аюулгүй байдлыг хангаж, үр ашгийг нэмэгдүүлнэ.
- Санхүүгийн салбарт технологийн дэвшлийг нэвтрүүлэхтэй холбоотойгоор баримтлах зарчим, стандарт, шаардлагыг боловсруулах ажлыг олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- Зээлийн мэдээллийн санд бичил санхүүгийн байгууллагыг бүрэн хамруулах боломжийг судалж, шаардлагатай бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН 70 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

(2018 оны 8 дугаар сарын байдлаар)

2. Монголбанкны дүрмийн сангийн хэмжээг 2018 онд нэмэгдүүлэх арга хэмжээ авч Улсын Их Хуралд танилцуулах;

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А-10 дугаар тушаалаар Монголбанкны дүрмийн санг 55,0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, дүрмийн сангийн хэмжээг 60,0 тэрбум төгрөгт хүргээд байна.

3.1. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөөг 2018 оны 01 дүгээр сард багтаан баталж хэрэгжүүлэх, эрх зүйн орчныг олон улсын байгууллагаас тогтоосон стандарт, зөвлөмжтэй 2018 оны 07 дугаар сард багтаан нийцүүлж, хэрэгжилтийг 2018 оны 10 дугаар сараас өмнө хангах;

Ази, Номхон далайн бүсийн байгууллага (АНДББ)-аас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тогтолцооны 2 дахь удаагийн Харилцан үнэлгээг 2016-2017 онд хийж гүйцэтгэсэн билээ. Улмаар 2017 оны 7 дугаар сард Шри-Ланка Улсын Коломбо хотноо хуралдсан АНДББ-ын жилийн чуулганы үеэр Монгол Улсын Харилцан үнэлгээний тайланг хэлэлцэж “эрчимтэй хяналтад” оруулах шийдвэр гаргаж 2018 оны 10 дугаар сар хүртэл хугацаат үүрэг өгсөн ба тэрхүү үүргийг хангалтгүй биелүүлсэн тохиолдолд Монгол Улсыг эрчимтэй хяналтаас ФАТФ-ын “саарал жагсаалт”-д шилжүүлж болзошгүйг анхааруулаад байсан билээ.

Монгол Улсын Засгийн газар 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 327 дугаар тогтоолоор хэрэгжүүлэх “Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г баталж Монголбанк, СМА-тай хамтран хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр МУТСТ тухай хууль болон дагалдах хуулиудын нэмэлт, өөрчлөлтүүдийг баталсан нь Монгол Улсын МУТСТ тогтолцоог ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлж, хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг эрсдэлд суурилан гүйцэтгэх, хуулийн нэр томьёоны тодорхойлолтуудыг олон улсын стандартад нийцүүлэх, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг эрс чангатгахад чухал алхам болов.

2018 оны 7 дугаар сарын 21-27-нд Балба Улсын Катманду хотноо хуралдсан АНДББ-ын жилийн чуулганы үеэр Монгол Улс холбогдох хууль тогтоомжоо шинэчилснийг харгалзан үзэж эрчимтэй хяналтад байх хугацааг дахин 12 сараар сунгасны дээр хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд авсан арга хэмжээний тайланг 2019 оны 1 дүгээр сарын 30-ны дотор АНДББ-д хүргүүлэх үүргийг Монгол Улсад өгөөд байна.

3.2. Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэх;

Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2018 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2018 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, улмаар Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн дугаар А-58/51/134 хамтарсан тушаалаар баталсан. Цаашид СТБЗ-ийн Ажлын албанаас уг арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хагас жил тутам холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн дүгнэж, СТБЗ-ийн гишүүдэд танилцуулна.

“Монгол улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн биелэлтийг ирүүлэх тухай МБЕ-ийн 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн албан тоот бичгийг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах холбогдох 15 байгууллагад хүргүүлсэн. Улмаар СТБЗ-ийн Ажлын алба нь уг төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэн Монголбанкны Ерөнхийлөгчид 2018.06.29-ний өдөр танилцуулж, тус төлөвлөгөөний биелэлтийг СТБЗ-ийн гишүүдэд 2018.07.05-ны өдрийн А-1/853 тоот албан бичгээр хүргүүлсэн. Тус төлөвлөгөөнд тухайлсан нэг байгууллага эсвэл холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлэх нийт 90 арга хэмжээ туссанаас 2018 оны эхний хагас жилийн байдлаар 18 нь бүрэн биелсэн, 72 нь хэрэгжих шатандаа байна.

3.3. Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн дэд бүтцийг бэхжүүлж, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, баталсан Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр салбарын бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой банкны тогтворжуулалтын сан бий болгохоор зохицууллаа. Энэ сан нь банкнаас төлсөн хураамжаас бүрдэх бөгөөд татвар төлөгчийн мөнгөөр бус тухайн системээс бүрдүүлсэн

хөрөнгөөр хүндрэлд орсон банкинд бүтцийн өөрчлөлт хийх, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг хийх юм. Үүнээс гадна эрсдэлд орсон банкны өр төлбөрийг хувьцаанд хөрвүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож банкны өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүтцэд өөрчлөлт оруулах эрх зүйн орчин нээлээ. Өнөөдрийн байдлаар эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт журам, зааврыг боловсруулж, мөрдүүлэхээр ажиллаж байна.

Хадгаламжийн даатгал нь банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн суурь тогтолцооны нэг юм. Монгол Улсын Их Хурлын 2018 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа. Энэ өөрчлөлтөөр банкны бүтцийн арга хэмжээний хүрээнд Хадгаламжийн даатгалын корпорацийн оролцоог улам тодорхой болгож, банкинд санхүүгийн дэмжлэг, нөхөн олговор олгох зэрэг зохицуулалтыг боловсронгуй болгосон. Мөн Хадгаламжийн даатгалын корпорацийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж, зөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүллээ.

Санхүүгийн салбарт активын удирдлагын тогтолцоо хөгжүүлэх, шаардлагатай эрх зүйн орчин бүрдүүлэхээр 2017 онд Азийн хөгжлийн банктai хамтран ажилласан. Мөн Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яамны төлөөллийг багтаасан өргөтгөсөн ажлын хэсгийг байгуулан, Активын удирдлагын тогтолцоо хөгжүүлэх хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн бариулахаар болоод байна.

3.4. Зээлийн хүүг бууруулах стратеги боловсруулах;

Манай орны эдийн засагт зээлийн хүү нь хөрөнгө оруулалт, бизнес эрхлэлтийг дэмжихүйц түвшинд хүртэл буурахгүй байгааг сүүлийн хориод жилийн турш байнга ярьж, холбогдох бодлогын баримт бичиг гаргаж хэрэгжүүлсэн хэдий ч зээлийн хүү өндөр хэвээр байна. Иймд зээлийн хүүг цаашид хэрхэн бууруулах арга замыг эрэлхийлэх, бодлого болоод стратегийн хүрээнд ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг тодорхойлох нь чухал юм. Энэ хүрээнд “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ыг манай оронд явуулсан судалгаа, уг стратегийн төслийг боловсруулах ажлын хэсгийн судалгааны үр дүнгийн тайланд суурилан боловсруулсан бөгөөд холбогдох байгууллагуудтай зөвлөлдөж саналыг нь тусгасан болно. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А-167/139/399/37 дугаар тушаалаар “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ыг баталсан. Үүний зэрэгцээ тодорхой хугацаатай, олон

улсын туршлагад суурилсан арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлж санал авах ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр батлуулахаар ажиллаж байна.

3.5. Эдийн засгийн төлөв, санхүүгийн чадавхтай уялдсан урт хугацаанд тогтвортой хэрэгжих боломжтой орон сууцны ипотекийн тогтолцоог хөгжүүлэх;

Сангийн сайдын 2017 оны 337 дугаар тушаалаар батлагдсан Засгийн газраас хэрэгжүүлэх ипотекийн хөтөлбөрийн тогтолцоог боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монголбанкны төлөөлөл оролцон ажилласан. Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог урт хугацаанд хэрэгжих боломж, хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс татааст суурилсан орон сууцны санхүүжилтийн схемийг хэрэгжүүлэх санал боловсруулж, Сангийн сайд, Барилга хот байгуулалтын сайдад тус тус танилцуулсан. “Татааст суурилсан орон сууцны санхүүжилтийн схем”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан “Засгийн газрын ипотекийн хөтөлбөрийн журам”-ын төслийг боловсруулж, оролцогч талууд болон Дэлхийн банкны зөвлөхийн саналыг тусган, журмын төслийг эцэслэсэн. Гэвч Засгийн газар ипотекийн хөтөлбөрийг татааст суурилсан хэлбэрээр хөтөлбөрийг өөр хувилбараар хэрэгжүүлэхээр судалж байгаа талаар хариу мэдэгдсэн. Үүнтэй холбогдуулан БХБЯ-наас шинээр боловсруулсан “Засгийн газрын ипотекийн зээлийн журам”-ын төсөлд хэд хэдэн удаа санал өглөө. Түүнчлэн Сангийн яамнаас боловсруулсан ипотекийн зээлийн хөтөлбөрийг Монголбанкнаас Засгийн газарт шилжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан олон улсын байгууллагуудаас санал авахаар хүргүүлээд байна.

Дэлхийн банк, ОУВС-тай тохиролцсоны дагуу Монголбанк 2018 онд ипотекийн зээлийн хөтөлбөрийг өөрийн өмчлөлийн ИЗББ-ын үндсэн төлбөрийн орлогоор санхүүжүүлж, улсын төсөвт тусгасан Засгийн газрын эх үүсвэрийг банкуудад дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Үүний хүрээнд 2018 оны 8 дугаар сарын байдлаар Монголбанкны эх үүсвэрээс нийт 127.7 тэрбум төгрөгийн санхүүжилт, Засгийн газрын эх үүсвэрээс 59.6 тэрбум төгрөгийн санхүүжилт буюу нийт 187.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкуудад олгоод байна.

3.6. Банкны салбар дахь чанаргүй зээлийг бууруулах, чанаргүй зээл үүсэхгүй байх орчинг бүрдүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэх;

Чанаргүй активыг шийдвэрлэх стратеги нь Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-өөр хэрэгжүүлэх санхүүгийн салбарыг хөгжүүлэх стратегийн хүрээнд тавигдах шаардлага юм. Иж бүрэн стратеги боловсруулахад өргөн хүрээний бодлогын арга хэмжээг авч үзэх шаардлагатай тул Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл зэрэг байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулсан.

Банкны салбар дахь чанаргүй активыг бууруулах, шинээр зээл чанаргүйдэх байдлыг арилгах зорилгоор Монголбанкнаас удирдан зохион байгуулж Стратеги төлөвлөгөө болон уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хамтад нь боловсруулсан. Уг төлөвлөгөөг боловсруулахад Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбооноос тус тус санал авсан.

ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд “Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг”-ийг Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 140/400/A-168/38 дугаар хамтарсан тушаалаар баталсан бөгөөд стратеги нь банкны системийн чанаргүй активын нөхцөл байдлыг тодорхойлох, хууль, эрх зүй болон шүүхийн шинэчлэлийг хийх, банкуудын чанаргүй зээлтэй ажиллах үйл ажиллагааг үр дүнтэй болгон сайжруулах бодлогын чиглэлээр хэрэгжинэ. Батлагдсан стратегийг олон нийтэд цахим хуудсаар дамжуулан мэдээлсэн.

Стратегийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Санхүүгийн тогтвортой байдлын ажлын алба хариуцан байгууллага тус бүрээр гүйцэтгэлийг хангуулахаар ажиллаж байна.

Стратегид тусгагдсан хууль, тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлийн ажилд тухай бүр байгуулагдсан ажлын хэсгүүдэд зохих байгууллагуудын төлөөллөөс томилогдон ажиллаж байна.

Чанаргүй зээлийг шийдвэрлэх орчин, хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь урт хугацааны санхүүгийн хөгжлийн үндэс суурийг бүрдүүлдэг тул одоо мөрдөж буй дараах хууль, тогтоомжид шаардлагатай өөрчлөлтүүдийг хийхээр ажиллаж байна:

- Чанаргүй активын удирдлага, тайлагналын журам,
- Дампуурлын хуулийн шинэчилсэн найруулга,
- Актив удирдлагын компанийн тухай хууль,
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт,

Активын удирдлагын хуулийн этгээдийн өмчлөлд хувийн өмчийн оролцоог давамгайл байдлаар хангаж, төрийн оролцоог багасгах үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалыг өөрчилж, хуулийн төслийн саналыг хууль санаачлагчид уламжлаад байна.

3.7. Засгийн газрын дотоодын үнэт цаасыг бууруулах, арилжааны банкин дахь Засгийн газрын үнэт цаасыг мөнгөний бодлогын арга хэрэгсэл болгон ашиглаж эхлэх;

Дээрх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗГҮЦ-ыг мөнгөний бодлогын хэрэгсэлд ашиглахад үүсч буй хүндрэлийг арилгах, банк хоорондын арилжааны идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор ЗГҮЦ-ны арилжааны программд хоёрдогч захын арилжаатай холбоотой өөрчлөлт оруулах, сайжруулах чиглэлээр дараах ажлыг гүйцэтгээд байна. Үүнд: i) ЗГҮЦ-ны хоёрдогч захад үүсч буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, ЗГҮЦ-ны программыг сайжруулах чиглэлээр Сангийн яам болон ҮЦТХТ ХХК-д хамтран ажиллах саналыг албан бичгээр хүргүүлж, программ сайжруулалтын асуудлыг шийдвэрлэх хүртэл эзэмшигчийн мэдээллийг сар бүрийн эцэст ҮЦТХТ-ээс ирүүлж байхаар тохиролцсон, ii) ТБҮЦ болон ЗГҮЦ-ны хоёрдогч захыг хөгжүүлэх, банк хоорондын арилжааны идэвхийг нэмэгдүүлэх, оролцогчдын тоог өсгөх чиглэлээр Цахим арилжааны ерөнхий гэрээ, Үнэт цаас худалдан авах нөхцөлтэй зарах ерөнхий гэрээнүүдэд холбогдох өөрчлөлтийг оруулан, оролцогчдын тоог нэмсэн.

Тайлант хугацаанд Сангийн яамнаас ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулаагүй бөгөөд энэ оны хуваарийг одоог хүртэл батлаагүй байна.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2018 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ


(2018 оны 8 дугаар сарын байдлаар)

1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.1 Мөнгөний бодлогын зах зээлийн зарчимд суурилсан хэрэгслийг ашиглан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2018-2020 онд жилийн 8 хувь орчимд тогтворжуулна;

ХҮИ-ээр илэрхийлэгдсэн инфляци 2018 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 6.0%, Улаанбаатар хотод 6.4% байна. Сүүлийн 3 улирлын турш эрэлтийн болон нийлүүлэлтийн хүчин зүйлсээс шалтгаалж инфляци 6-8 орчим хувьд хэлбэлзэж байна.

Зураг 6. УБ хотын сар, жилийн болон суурь инфляци



Зураг 7. УБ хотын жилийн инфляци (бүрэлдэхүүнээр)



Эх сурвалж: ҮСХ

Наймдугаар сарын Улаанбаатар хотын жилийн инфляци (6.4%)-ийг барааны бүлгүүдээр нарийвчлан авч үзвэл хүнсний бүтээгдэхүүн (1.5 нэгж хувь) болон дотоодын бараа (2.0 нэгж хувь)-ны үнийн өөрчлөлт голлох нөлөө үзүүлжээ (Зураг 7). Энэ нь дараах хүчин зүйлээс шалтгаалав.

- Хатуу түлшний үнэ сүүлийн 5 сар тогтвортой байгаа боловч цаг агаарын нөхцөлөөс үүдэн үнэ нь өнгөрсөн оны 8-11 дүгээр сар болон 2018 оны 1-3 дугаар сарын өсөлт жилийн дүнгээрээ нийт 60.6 хувийн өсөлтийг бий болгож инфляцийн 1.4 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Зарим аймагт гарсан малын шүлхий өвчний улмаас хорио цээрийн дэглэм тогтоосон, зуншлага оройтож, долдугаар сарын дунд хүртэл бороошсоноос махны нийлүүлэлт буурч, махны үнэ 6, 7 дугаар сараас эхлэн буурдаг хандлага алдагдсан байна.
- Дэлхийн зах зээл дээрх нефтийн бүтээгдэхүүн болон Монгол улсын

импортлож буй шатахууны хилийн үнэ 40 орчим хувиар өссөнөөс шалтгаалан дотоодын зах зээлд шатахууны үнэ өнгөрсөн оны мөн үеэс 250 орчим (тайлант оны 5-7 дугаар сард 130 орчим) төгрөгөөр нэмэгдсэн нь инфляцийг нэмэгдүүллээ.

Цаашид дэлхийн зах зээл дээрх нефтийн үнийн өсөлттэй холбоотойгоор шатахууны үнэ өсөж, инфляцийг нэмэгдүүлэх эрсдэл байгаа ч, нөгөө талаас одоогийн үнийн өсөлтийн багагүй хэсгийг тодорхойлж буй түр зуурын шинжтэй хүчин зүйлсийн нөлөө саарснаар инфляци 2018 онд зорилтот түвшинд хадгалагдах төлөвтэй байна.

Мөнгөний бодлогын шийдвэр

- Монголбанкны Мөнгөний Бодлогын Зөвлөл 2018 оны 03-р сарын 23-ны өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг нэг нэгж хувиар бууруулж 10 хувь болгох шийдвэр гаргасан. Эдийн засгийн идэвхжилийг даган эрэлтийн шалтгаантай инфляци алгуур сэргэж байгаа хэдий ч жилийн инфляци цаашид зорилтот түвшний орчим тогтворжих боломжтойгоос гадна, төсөв болон төлбөрийн тэнцэл дээрх эерэг өөрчлөлтүүдийг харгалзан үзээд мөнгөний бодлогын хүүг ийнхүү бууруулах шийдвэр гаргасан. Энэ удаагийн бодлогын шийдвэр нь банкны салбарын санхүүжилтийн эх үүсвэрийн хүүг бууруулж, улмаар зээлийн хүүгээр дамжин бизнесийн идэвхжилийг дэмжих нөлөө үзүүлнэ гэж үзсэн.
- Монгол Улсын Их Хурлаар батлагдсан Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт 2018 оны 4 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Шинэ хуулиар мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад хамтын удирдлагын зарчмыг нэвтрүүлж, Мөнгөний бодлогын хороог байгуулсан бөгөөд уг хороогоор мөнгөний бодлогын шийдвэр гарч байна. Мөнгөний бодлогын хорооны хурлын эхний хэлэлцүүлэг 2018 оны 6 дугаар сарын 11-нд болж, шийдвэр гаргах хурал 2018 оны 6 дугаар сарын 15-нд хуралдаж эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, эрсдэл, мөнгөний бодлогын төлөв, альтернатив хувилбаруудыг хэлэлцэж, олонхийн саналаар бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргасан. Бодлогын энэхүү шийдвэр нь инфляцийг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах, эдийн засгийн өсөлтөд үргэлжлэн дэмжлэг үзүүлж, макро эдийн засаг, санхүүгийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилттой нийцэж байгаа юм.
- Мөнгөний Бодлогын Хороо 2018 оны 09-р сарын 20-ны өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргасан.

Нийлүүлэлтийн шинжтэй инфляци буурч эрэлтийн шинжтэй инфляци алгуур нэмэгдсэнээр инфляци зорилтот түвшний орчим хэлбэлзэх төлөвтэй байна гэж дүгнэсэн. Хэдийгээр оны эхний хагаст олон улсын зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдсанаар уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, эдийн засгийн сэргэлтийг даган хөрөнгө оруулалт тэлж, улмаар эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж байгаа боловч гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдэж байна. Тухайлбал, том гүрнүүдийн хоорондох гадаад худалдааны хязгаарлалтын бодлогууд, зарим улс оронд хэрэгжүүлж буй олон улсын хориг арга хэмжээ нь эрдэс бүтээгдэхүүний үнэ, хөгжиж буй орнуудаас гадагшилж буй хөрөнгийн урсгалд сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр байна. Иймд инфляцийг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах зорилго болон эдийн засаг, бизнесийн идэвхжилийг дэмжих, гадаад секторын эмзэг байдал зэргийг харгалзан бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэр гаргасан. Макро зохистой бодлогын хүрээнд гаргасан Мөнгөний бодлогын хорооны шийдвэр, түүнтэй холбоотой тайлбар мэдээллийг 1.3 заалтын хэрэгжилтээс харна уу.

- Бодлогын шийдвэрүүдийг хэвлэлийн бага хурлаар олон нийтэд танилцуулж, мөнгөний бодлогын мэдэгдлийг Монголбанкны цахим хуудсанд байршуулсны зэрэгцээ хурлын хураангуй тэмдэглэлийг хурлаас хоёр долоо хоногийн дараа мөн цахим хуудсанд байршуулан Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллалаа.

1.2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцсэн, уян хатан тогтох зарчмыг баримтална;

Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримталж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцсон.


Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлт сайжирсан, ОУВС-гийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ сайн, Засгийн газраас 2018 оны 1 дүгээр сард төлөгдөх Чингис бондын 500 сая ам.долларын төлбөрийг 800 сая ам.долларын Гэрэгэ бондоор төлсөн, оны эхнээс урьдчилсан байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой валютын орох урсгал сайжирсан, гадаад валютын цэвэр урсгал эрс сайжирсан зэрэг эерэг үзүүлэлтүүдээс шалтгаалан төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хэлбэлзэл тогтворжсон хэдий ч оны хоёрдугаар хагасаас гадаад валютын

эрэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар оны эхнээс 1.91%-иар суларсан үзүүлэлттэй байна. Энэ нь 2018 оны 7 дугаар сарын байдлаар манай улсын импорт өмнөх оноос 40 хувиар өссөнтэй холбоотой байна.

Монголбанкнаас 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 70 удаагийн гадаад валютын дуудлага худалдааг зохион байгуулсан бөгөөд дуудлага худалдаа, банк хоорондын валют арилжааны цахим талбар болон бусад арилжаагаар нийт 81.3 сая ам.долларыг дотоодын валютын захад нийлүүлсэн байна. Түүнчлэн Монголбанк банкуудтай нийт 163.4 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийг байгуулжээ.


2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 0.21%-иар чангарч, 0.61%-иар суларч, өдрийн дундаж хэлбэлзэл 0.05% байв. Мөн тайлант хугацааны 97.0%-д төгрөгийн ам.доллартай харьцах ханш $\pm 0.2\%$ -ийн интервалд хэлбэлзсэн байна. Ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.05% байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 0.06 пункт, 2016 оны мөн үетэй харьцуулбал 0.16 пунктээр тус тус буурсан үзүүлэлт юм.

Зураг 8. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкны хаалтын ханшийн хэлбэлзэл (төгрөгөөр)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 9. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкны хаалтын ханшийн өөрчлөлт (хувиар илэрхийлсэн интервалаар)



Эх сурвалж: Монголбанк

Валютын захад нөлөөлөгч хүчин зүйлсийг судлах, мөнгөний бодлогын зорилтод нийцүүлэн мэдээлэл өгөх зорилгоор Монгол Улсын экспортын голлох түүхий эд болох зэс, нүүрс, төмрийн хүдэр, алт, түүхий нефтийн зах зээлийн орчны талаарх шинжилгээг улирал бүр боловсруулж бодлогын шийдвэр гаргахад ашиглаж байна. Энэхүү шинжилгээг гүйцэтгэснээр дотоодын валютын захад ирэх дарамт болон экспортын орлогод нөлөөлөх гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг мэдээлэх, урьдчилан тооцоолох нөхцөлийг бүрдүүлдэг.

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2018 оны 8 дугаар сарын байдлаар 12.2 тоннд хүрээд байна. Алтны мөнгөжүүлэлтийг шаардлагатай тухай бүр гүйцэтгэж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлсэн.

1.3. Санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ;

Банкуудын пассивын долларжилт, улмаар санхүүгийн салбарт ханшийн эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор заавал байлгах нөөцийн хувийг төгрөг болон гадаад валютын эх үүсвэрийн хувьд ялгаатай тогтоох шийдвэрийг 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Мөнгөний бодлогын зөвлөлийн хурлаар гаргасан. Тус хурлаар банкны пассивын долларжилтыг бууруулах, төгрөгөөр эх үүсвэр татах сэдлийг бий болгох зорилгоор төгрөгөөр татсан эх үүсвэрийн заавал байлгах нөөцийн хувийг 12 хувиас 1.5 нэгж хувиар бууруулж 10.5 хувь болгож, гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 12 хувьд хэвээр хадгалсан. ЗБН-ийн хувийг 10.5 хувь болгон бууруулснаар төгрөгийн хувьд банкуудын чөлөөт

эх үүсвэр нэмэгдсэн. Заавал байлгах нөөцийн хувийг ийнхүү төгрөг болон гадаад валютын хувьд ялгаатай тогтоох шийдвэр нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, ханшийн эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ боллоо.

Мөн Монголбанкнаас ажлын хэсэг байгуулагдан “Төв банк /Монголбанк/-наас макро зохистой бодлогын талаар баримтлах стратеги”-ийн төслийг боловсруулж, Мөнгөний бодлогын зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Уг стратегийг боловсруулах хүрээнд макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг ашигласан бусад улс орны сайн туршлагыг судалж, Монгол улсын хувьд ашиглах боломжтой арга хэрэгслүүдийг тодорхойлж, стратегийн төсөлд тусгасан. Энэхүү стратегийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А-76 дугаар тушаалаар баталж, Монголбанкны цахим хуудсанд байршуулсан. Цаашид тус стратегийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна.

Мөнгөний бодлогын хорооны 6 дугаар сарын хурлаар 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш шинээр олгох эсвэл нөхцөлийг өөрчлөх иргэдийн хэрэглээний зээлийн хувьд зээлдэгчийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувь байхаар тогтоосон. Энэ нь өрхийн өрийн дарамтыг бууруулж, санхүүгийн системийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, банкны эх үүсвэрийг ажлын байр нэмэгдүүлдэг бизнесийн зориулалттай зээлд чиглүүлэх, улмаар ажлын байрыг нэмэгдүүлж, иргэдийн орлогоор баталгаажсан өнөөгийн болон ирээдүйн хэрэглээг тогтворжуулах зорилготой шийдвэр байв. Тус шийдвэртэй холбогдуулан иргэдийн хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааг тооцох аргачлал, тоон мэдээллийг банкуудаас гаргуулан авах маягтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн А-176 дугаар тушаалаар баталж, Монголын банкны холбоо, бүх банкинд албан бичгээр хүргүүлж тушаалын биелэлтийг хангуулж байна.

Монгол Улсын санхүүгийн системийн бүтэц, онцлог шинж чанарт тулгуурлан макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх шинжилгээний арга зүйг хөгжүүлэх ажлын хүрээнд бусад улс оронд макро зохистой бодлогын шинжилгээнд ашиглаж буй макро зохистой бодлогын загваруудын талаар судалж, холбогдох судалгааг гүйцэтгэсэн. Тухайлбал, БНСУ-ын Төв банкны мэдлэг солилцох хөтөлбөрийн хүрээнд тус банкны мэргэжилтнүүдийн хамт Монгол Улсын санхүүгийн системийн онцлогийг БНСУ-ын туршлагатай харьцуулан судалж, макро зохистой бодлогын институцийн оновчтой арга хэлбэрийг тодорхойлох, Монгол улсын санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болохуйц эрсдэлүүдийг тодорхойлох, макро зохистой

бодлогын зарим хэрэгслүүдийн боломжит үр нөлөөг шинжлэхээр ажиллаж байна.

Макро зохистой бодлогын тооцоо шинжилгээнд ашиглах тоон мэдээллүүдийг шаардлагатай тохиолдолд банкууд болон орон нутаг дахь Монголбанкны салбар, хэлтсүүдээр дамжуулан авч өгөгдлийн санг үүсгэж эхлээд байна. Тухайлбал, иргэдийн хэрэглээний зээл, өр орлогын харьцааны талаарх мэдээллийг 2017 оны 10, 2018 оны 5 дугаар сард авч, боловсруулан 2017 оны 12, 2018 оны 6 дугаар сарын Мөнгөний бодлогын хорооны хуралд танилцуулсан. 2018 оны 6 дугаар сарын Мөнгөний бодлогын хорооны хурлаас гарсан макро зохистой бодлогын шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн А-176 дугаар тушаалын дагуу банкууд иргэдийн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны мэдээг 2018 оны 9 дүгээр сараас эхлэн сар бүр ирүүлэхээр болсон. Үүний зэрэгцээ, санхүүгийн системийн тогтвортой байдлыг үнэлэх, шинжилгээ хийхэд шаардлагатай бусад тоон мэдээллийг системийн хэмжээнд нэгтгэхээр ажиллаж байна.

1.4. Хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч, зах зээлд оролцогчдын итгэлийг сэргээн, хадгалах үүднээс ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогын хүрээнд үр нөлөөг дээшлүүлэх, бодлогын нээлттэй, ил тод байдлыг хангаж, олон нийттэй харилцах сувгийг хөгжүүлж, боловсронгуй болгоно;

Монголбанк бодлогын шийдвэр, түүний үндэслэлийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар тайлбарлан таниулж, Төв банкны нээлттэй, ил тод, хариуцлагатай байдлыг хангах ажлын хүрээнд хоёр бүлэг ажлыг хэрэгжүүллээ.

Мөнгөний бодлогын үр нөлөөг дээшлүүлж, тайлбарлах ажлын хүрээнд:

Төв банкны олон нийттэй харилцах гол арга хэрэгслүүдийн нэг болсон инфляцийн тайланд багтсан дүрслэл, графикуудыг MsExcel форматаар вебсайтад байршуулснаар эдийн засагчид, судлаач нарт тус тайланг ашиглахад дөхөм болсон сайн туршлага боллоо. Түүнчлэн, 2018 оны 2-р улирлаас эхлэн Инфляцийн тайлангийн “Хураангуй” хувилбарыг боловсруулж, олон нийтэд хялбарчилсан байдлаар хүргэдэг болов. Тайланг олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан тогтмол түгээж, тайлбарлан хүргэж байгаа ба нэгдсэн танилцуулгыг банк, санхүүгийн салбарын мэргэжилтнүүд болон хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, сурвалжлагчдад хүргэдэг болов.

2018 оны 3 болон 6 дугаар сард гаргасан Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг Хэвлэлийн хурлаар дамжуулан төвийн хэвлэл мэдээллийн

хэрэгслүүдээр олон нийтэд тухай бүрт нь түгээв. Мөн Мөнгөний бодлогын хорооноос гаргасан шийдвэр, түүний үндэслэлийг эдийн засагт оролцогч талууд буюу судлаач, шинжээчид, хөрөнгө оруулагчид, олон нийтэд тайлбарлахын тулд Монголбанкны албан ёсны веб хуудас, цахим хуудас / twitter, facebook, youtube/, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан тогтмол мэдээлэл хүргэж байна. Тэдгээрээс дурдвал, Bloomberg, Eagle телевизээр тусгай нэвтрүүлэг бэлтгэн түгээж байгаагаас гадна МБГ-ын удирдлагууд, Мөнгөний бодлогын хорооны хараат бус гишүүд сонин, сайт, телевизүүдэд тухай бүр тайлбар ярилцлага өгөв.

Мөн олон нийтийн цахим хаягуудаараа дамжуулан мөнгөний бодлогын хорооны шийдвэр, түүний үндэслэл, Төв банкны үндсэн зорилт, үйл ажиллагааны чиглэлийн талаар инфографик бэлтгэн, энгийн товч байдлаар тайлбарлаж сэтгүүлчдэд зориулсан сар бүрийн төлөвлөгөөт сургалтыг “Инфляцийн хүлээлтийн судалгаа”, “Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийн үр нөлөө” сэдвээр зохион байгуулж, танилцууллаа.

Сэтгүүлчдийг эдийн засгийн дүн шинжилгээ бүхий нийтлэл бичих идэвхийг нь хөхиүлэн дэмжиж, хагас жил тутам болдог эдийн засгийн шилдэг нийтлэл уралдааныг “Төв банкны олон нийттэй харилцах харилцаа” сэдвээр зохион байгуулж, мөнгөний бодлогын хорооны шийдвэрийн тухай эдийн засагчдын урьдчилсан таамгийг нэгтгэн олон нийтэд хүргэв. Тайлант хугацаанд нийт 11 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулснаас Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг танилцуулах хэвлэлийн хурлыг 2 удаа зарлан хуралдуулав. Үүнээс гадна Монголбанкнаас 42 ярилцлага, 27 нийтлэл, 105 мэдээг бэлтгэн хүргэж, “Монголбанкны цаг” ТВ нэвтрүүлгийг 18 удаа, “Зангиагүй уулзалт”-ыг 3 удаа зохион байгуулжээ.

Оюутнуудад Монголбанкны бодлого, үйл ажиллагааг таниулах ажлын хүрээнд “Сургагч оюутан багш” нарын сургалтыг 8 удаа зохион байгуулж, 1500 орчим оюутныг хамруулсан бол “Монголбанкны цаг” арга хэмжээг мөн 10 их, дээд сургуулийн 800 орчим оюутныг оролцуулан зохион байгуулав. Тухайлбал, “Монголбанкны цаг” арга хэмжээнд Монголбанкны Ерөнхийлөгч нар, газрын захирлуудыг урьж оролцуулснаар оюутнуудад Монголбанкны удирдлагуудын ажил, мэргэжлийн замнал болон Төв банкны бодлого шийдвэрийн талаарх сонирхолтой лекцүүдийг сонсох боломжийг олгосон өндөр ач холбогдолтой арга хэмжээ болов.

“Монголбанкны мэдээлэл” товхимол бэлтгэж түгээх ажлын хүрээнд тайлант хугацаанд нийт найман дугаар эрхлэн гаргаж, 4000 хувийг хэвлүүлэн, дугаар бүрийг МУЕТГ, УИХ, ЗГ, арилжааны банкууд, Монголбанкны газар нэгжүүд, орон нутаг дахь хэлтэс салбар, аймаг, сумын ЗДТГ, номын сан, сургуулиудад түгээж ажиллалаа.

Олон нийттэй харилцах сувгийг хөгжүүлж, боловсронгуй болгох ажлын хүрээнд:

Монголбанкнаас зохион байгуулдаг нийтлэлийн уралдааны сэдвийг цаг үеийн сэдвээр сонгож, Төв банкны бодлого шийдвэр болон оюутан, судлаачдын бүтээлийг олон нийтийн хүртээл болгох зорилгоор хагас жил тутамд зохион байгуулж байна. Мөн эдийн засгийн чиглэлээр сурч буй оюутан, судлаачдын судалгаа хийх чадварыг хөхиүлэн дэмжих, бүтээлийг нь нийтэд түгээн дэлгэрүүлж, олон нийтийн эдийн засгийн ойлголтыг дээшлүүлэх зорилгоор жил бүр болдог Монголбанкны нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурлыг 5-р сард оюутан болон судлаач гэсэн 2 ангилалд амжилттай зохион байгуулав.

Монголбанкны цаг үеийн асуудал, санхүү, банкны салбарын статистик үзүүлэлтийг мэдээлэх, тайлбарлах зорилгоор Хэвлэлийн бага хурлыг сар бүр зохион байгуулж байна. Ингэхдээ, мөнгөний бодлогын хорооны мэдэгдэл, Монголбанкны хэвлэлийн бага хурал болон цаг үеийн шуурхай хурлын үеэр Фейсбүүк орчинд шууд буюу LIVE нэвтрүүлэг хийж түгээдэг боллоо. Төв банкны олон нийттэй харилцах харилцаа нь иргэдийн Төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах, улмаар зах зээл дээрх хүлээлтийг үр дүнтэй удирдахад эерэг нөлөө үзүүлэхийг зорьдог болоод байна.

Эдийн засгийн гол үзүүлэлтүүд, тэдгээрийн төсөөллийг багтаасан “Инфляцийн төлөв байдлын тайлан”-г зөвхөн цахим хуудсанд байршуулахад анхаарч ирснийг сайжруулж, улирал бүр албан ёсоор танилцуулан олон нийтэд хүргэдэг болсон нь иргэдийн эдийн засгийн талаарх төсөөлөл, мэдээллийг нэмэгдүүлэхэд үр нөлөөгөө өгч эхлэв.

Эдгээрээс гадна, сард хоёр удаагийн давтамжтайгаар Bloomberg ТВ-д “Төв банк ба төгрөг”, Eagle ТВ-д “Монголбанкны мэдээлэл” нэртэйгээр тус бүр 15 минутын нэвтрүүлгийг тусгайлан бэлтгэж байна. Мөн Монголбанкны “Мэдээллийн цаг” нэвтрүүлэг бэлтгэн, МҮОНТ, Bloomberg ТВ, Eagle ТВ гол гурван телевизээр долоо хоногт 2 удаагийн давтамжтай түгээж байна. Монголбанкны бодлого, шийдвэр, 2017, 2018 онд явуулсан аянууд хөдөө, орон нутагт хэрхэн хэрэгжиж байгааг тандан судлах, Монголбанкнаас

явуулж буй үйл ажиллагааны талаарх иргэд, олон нийтийн мэдлэг, мэдээлэл ямар түвшинд байгааг сурвалжлахаар тусгай нэвтрүүлэг бэлтгэж эхлэв. Эдгээр нэвтрүүлгийг цуврал болон төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган аймгийг хамруулан “Төв банкны бодлого Төвийн бүсийн аймгуудад”, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийг хамруулан “Санхүүгийн боловсрол говь нутгийн иргэдэд” нэртэйгээр тус бүр 20 минутын нэвтрүүлэг олны хүртээл болоод байна. Цаашид буюу 9, 10 дугаар сард багтаан Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Архангай аймгийг хамруулсан 2 цуврал нэвтрүүлгийг цацахаар бэлтгэж байна.

“Монголбанкны сургагч оюутан-багш” хөтөлбөрийг эхлүүлж, 20 гаруй сургуулийн 1200 орчим оюутанд сургалт хийн, Төв банкны үндсэн зорилт, үйл ажиллагааг нийтдээ 5000 орчимд оюутанд таниулаад байна. Эдийн засгийн сэтгүүлчдийг мэргэшүүлэх “Төв банкны мэргэшсэн сэтгүүлчид клуб”-ыг байгуулж, тэднээр дамжуулан, олон нийтийн эдийн засгийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор тогтмол уулзалт зохион байгуулж байна.

Хөдөө орон нутгийн иргэдийг Төв банкны үйл ажиллагаа, эдийн засгийн мэдээллээр тогтмол хангах зорилгоор орон нутгийн сэтгүүлчдэд зориулсан сургалт уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, Төв банк, ханш, Монголбанкны алт худалдан авалт, банкны салбарын хууль эрх зүйн орчны шинэчлэлт сэдвээр сургалт зохион байгуулав. Орон нутгийн томилолтуудын хүрээнд бүс нутгийн сэтгүүлчдийг чадавхжуулах уулзалт, сургалтуудыг мөн тогтмол хийж хэвшээд байгаа бөгөөд олон нийтийн цахим сүлжээнд орон нутгийн сэтгүүлчидтэй харилцах бүлэг үүсгэн мэдээллээр тогтмол хангаж байна.

2. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

2.1. Санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөжүүлэх, банк санхүүгийн байгууллагын эрсдэл даах чадварыг дээшлүүлэх, улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор шаардлагатай тохиолдолд банкуудыг дахин хөрөнгөжүүлэх, санхүүгийн чадамжийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

Монголбанкнаас санаачлан хэрэгжүүлж байгаа Банкны салбарын хууль эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-ын 2017 оны намрын ээлжит чуулганаар тус тус баталлаа.

Банкуудад Активын чанарын үнэлгээг хийлгэж 2018 оны 1 дүгээр улиралд олон нийтэд болон банкуудад уг үнэлгээний үр дүнг нийтэлж, танилцуулсан болно. Активын чанарын үнэлгээний дараа банкуудын өөрийн хөрөнгийн болон бизнес төлөвлөгөөнд үнэлгээ хийж, түүний үр дүнд банкуудад шаардах өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагыг банкуудад тавиад байна.

Түүнчлэн Олон Улсын Валютын Сантай тохиролцсон “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн нөхцөлд активын чанарын үнэлгээгээр өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан системд нөлөө бүхий банкуудыг дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, эдгээр зарчмыг зохицуулсан хууль, эрх зүйн баримт бичгийг боловсруулахаар тохиролцсон. Энэ ажлын хүрээнд ОУВС-гийн Техник туслалцааны баг Монгол Улсад 2017 оны 10 сард ирж ажилласан бөгөөд өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан банкуудыг дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааны зарчмуудыг Монголбанк, Сангийн яамтай хамтран тодорхойлов. Банкийг дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагаанд дараах зарчмуудыг баримтлах юм. Үүнд:

- Банкийг дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ улс орны санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгыг нэн тэргүүнд тавих бөгөөд, төсвөөс гарах зардлыг хамгийн бага байлгах зарчмыг баримтална;
- Улс орны санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд Төрөөс банкийг дахин хөрөнгөжүүлэх арга хэмжээнд зөвхөн үйл ажиллагаагаа дунд, урт хугацаанд тогтвортой явуулах бололцоотой, банкны системийн нөлөө бүхий банкууд хамрагдах боломжтой;
- Төсвөөс гарах зардлыг бага байлгах зарчмыг хангахын тулд банкийг дахин хөрөнгөжүүлэх арга хэмжээ нь аль болох хувийн хөрөнгө оруулалт татах зорилгыг агуулсан байна;
- Банкны алдагдлыг хувьцаа эзэмшигчид нь хүлээж, банк нь дотоод нөөц бололцоо болон шинэ эх үүсвэр ашиглан өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх бүхий л арга хэмжээг авсны дараагаар Төр банкны өөрийн хөрөнгийн хэрэгслийг худалдан авч удирдах бөгөөд тодорхой хугацааны дараа худалдах замаар Төрөөс оруулсан хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэх болно.

Дээрх зарчмуудад үндэслэн Монгол Улсын Засгийн газраас Олон Улсын Валютын сантай хамтран хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Монголбанкны хяналт шалгалт, активын чанарын үнэлгээний үр дүнгээр өөрийн хөрөнгийн дутагдалтай байгаа банкуудын өөрийн хөрөнгийн шаардлагыг хангуулах, шаардлагатай тохиолдолд төрөөс

банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд оролцох харилцааг зохицуулсан Банкний дахин хөрөнгөжүүлэх хуулийн төслийн саналыг боловсруулж Сангийн яаманд уламжилсан бөгөөд Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуулийн төслийг УИХ-ын 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталлаа. Уг хуульд заасны дагуу банкнаас өөрийн хөрөнгийн дэмжлэг хүссэн хүсэлт гаргах, банкнийг шинэчлэх төлөвлөгөөний агуулгыг тодорхойлсон журмын төслийг Монголбанкнаас боловсруулсан бөгөөд Сангийн яамны саналыг тусгасан.

Гадаад валютын зохицуулалтын бодлого, гадаад валютын ханш зах зээлийн зарчмаар тогтох нөхцөлийг хангах, валютын захын үйл ажиллагааны зарчим, талуудын эрх үүрэг, төрийн оролцоог тодорхойлсон Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн саналыг Монголбанкнаас боловсруулж төсөлд Санхүүгийн зохицуулах хороо болон бусад байгууллагын саналыг авч хууль санаачлагчид уламжиллаа.

Векселийн тухай хууль, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хуулийг шинэчлэх, Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн төслийг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу боловсруулан ажиллаж байна.

2.2. Банкны салбарт итгэх итгэлийг дээшлүүлэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгоно;

ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Төв банк болон Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хурлаас баталж, 2018 оны 4 дүгээр сараас эхлэн мөрдөхөөр тогтоосон. Эдгээр хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг мөрдөж эхэлснээр Монголбанкнаас банкуудад хийх хяналт шалгалтыг гүйцэтгэлд суурилсан аргачлалаас эрсдэлд суурилсан аргачлалд шилжүүлэх боломж бүрдэж байгаа бөгөөд албадлагын арга хэмжээний үе шат, Монголбанкнаас эрсдэлтэй банкинд авч хэрэгжүүлэх шалгалтын арга хэрэгслийг уян хатан байдлаар тогтоосон. Ялангуяа, Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүд болон бусад төрлийн зохистой харьцааг одоогийн нөхцөлд хангаж байгаа боловч, ирээдүйд буюу ойрын хугацаанд хангахгүй байх эрсдэлтэй гэж дүгнэвэл банкуудад урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, учирч болзошгүй алдагдлын боломжит хэмжээг бууруулах боломжтой. Түүнчлэн, төлбөрийн чадвар муудсан банкинд авах албадлагын арга хэмжээг санхүүгийн салбарт үүсэх алдагдлыг хамгийн бага түвшинд байлгахуйц байдлаар шийдвэрлэх арга хэрэгслийг ашиглах сонголтыг Монголбанкинд олгож байгаагаараа

ОНЦЛОГ ЮМ.

Шинээр баталсан Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлттэй уялдуулан хяналт шалгалтыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах хүрээнд Монголбанкнаас дангаар болон бусад эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах шаардлагатай журам, зааврын жагсаалт, хуваарийн хамт боловсруулан Монголбанкны Ерөнхийлөгчийн А-47 дугаар тоот тушаалаар баталсан бөгөөд одоогоор эдгээр баримт бичгийг боловсруулах ажлыг хуваарийн дагуу хийж байна. Тухайлбал, банкны төвлөрлийн эрсдэлийг бууруулах хүрээнд том харилцагчдад тавих шаардлагыг оновчтой тогтоох, толгой болон зэргэлдээ компаниудаас банкинд учруулах эрсдэлийг бууруулах чиглэлээр хяналт шалгалтыг нэгдсэн байдлаар гүйцэтгэх, банкинд авах албадлагын арга хэмжээний үе шат, уян хатан нөхцөлийг оновчтой тодорхойлох, бүтцийн өөрчлөлт хийгдэж буй банкинд дахин төрөөс болон бусад эх үүсвэрээс санхүүжилт олгох шалгуурыг тогтоох, зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээг зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан тодорхойлох, банкны системд хуримтлагдсан чанаргүй активыг зардал багатайгаар шийдвэрлэх, активыг ангилж, эрсдэлийн сан байгуулах шалгуурыг уян хатан байдлаар тогтоох, банкны хувь эзэмшлийн бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны зөвшөөрөл олгох, зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, зохистой харьцааны үзүүлэлтийг сайжруулах, олон улсад мөрддөг Базел стандартыг нэвтрүүлэх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны зарчим, хяналт тавих журам, зааврыг боловсруулахаар ажиллаж байна.

Банкны тухай хуулийн дагуу “Банкинд зайнаас хяналт тавих аргачлал”-д “банкны хэвийн бус үйл ажиллагаатай” гэж тогтоосон, өндөр эрсдэлтэй аливаа үйл ажиллагааг тодорхойлох, хяналт тавихтай холбоотой бусад асуудлын талаарх зохицуулалтыг оруулах саналыг боловсруулсан.

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

3.1. Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэн, шинээр батлагдсан болон шинэчлэн найруулсан, нэмэлт, өөрчлөлт орсон холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж, шаардлагатай дүрэм, журмыг боловсруулна;

Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-д Банкны тухай хуулийн шинэчлэлтэй нийцүүлэн өөрчлөлт оруулж МБЕ-ийн тушаалаар батлуулсан.

Улсын Их Хурлын 2017 оны хаврын ээлжит чуулганаар баталсан Банкны

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасны дагуу банкны хяналт шалгалт, албадлагын арга хэмжээ, зохистой засаглал, эрсдэлийн удирдлага, банкны үйл ажиллагааны шаардлага, хязгаарлалттай холбоотой Монголбанкнаас гаргах шаардлагатай нийт 23 захиргааны хэм хэмжээний актыг батлахаар ажиллаж байна. Банкны зээлийн төвлөрөл тооцох, хяналт тавих, банкны үйл ажиллагаа болон удирдлагатай холбоотой зөвшөөрөл олгох, банкны урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ, банкны тогтворжуулалтын сан, нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зэрэг банкны эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд шилжихэд шаардлагатай журмын төслүүд багтаж байна.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А-75 дугаар тушаалаар “Банкны хяналт шалгалтын хорооны ажиллах журам”-ыг баталлаа. Хорооны ажиллах журамд банкинд хяналт тавих Монголбанкны үйл ажиллагаатай холбоотой шийдвэрүүдийг хэлэлцэх зохион байгуулалт, хорооны бүрэлдэхүүн, хурлын дэг, шийдвэрийн хэлбэр зэргийг тусгаад байна.

2018 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А-143 дугаар тушаалаар “Монголбанкны мөнгөний бодлогын хорооны ажиллах журам”-ыг баталсан бөгөөд хороо нь хоёр үе шаттайгаар хуралдаж, мөнгөний бодлогын шийдвэрийг гаргадаг тогтолцоотой болсон.

2018 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн А-103 дугаар тушаалаар Мөнгөний бодлогын хороо, Банкны хяналт шалгалтын хороо болон тусгайлан байгуулсан бусад зөвлөлийн хэлэлцэхээс бусад, Монголбанкны үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад зөвлөх чиг үүрэг бүхий “Монголбанкны Захирлуудын зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн баталсан.

3.2. Үндэсний төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, төлбөрийн хэрэгслийн нэгдсэн зохицуулалтыг бий болгоно;

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж байгаатай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Их болон бага дүнтэй төлбөрийн системийн журам, Төлбөрийн картын журам, Үндэсний цахим гүйлгээний төвийн төлбөрийн картын сүлжээний дүрэм зэргийг шинэчлэх, Цахим мөнгөний журмыг боловсруулж, батлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Төлбөрийн

системийн шинэчлэл” төслийн хүрээнд “RTGS-/Банксүлжээ/ системийн шинэчлэл” дэд төсөл амжилттай хэрэгжиж 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр системийн II хувилбарт бүрэн шилжсэн. Үүнтэй уялдуулан төлбөрийн системд мөрдөж байгаа гэрээ, хэлэлцээрийг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчилж, төлбөрийн системийн эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгон ажиллаж байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан олон нийтийг төлбөрийн системийн хууль, тогтоомжийн талаарх мэдээллээр хангах ажлын хүрээнд эрх зүйн шинэ зохицуулалт, түүний давуу тал, нийгэм эдийн засгийн үр ашиг, цахим мөнгө, криптовалютын талаарх мэдээллийг Монголбанкны цахим хуудсанд байршуулсан. Мөн үндэсний телевиз, радиогоор цахим мөнгөний тухай, хэвлэл мэдээллийн хэрэгслээр “Үндэсний төлбөрийн систем (ҮТС)-ийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах талаар Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай тус тус ярилцлага хийсэн. Түүнчлэн, эдийн засгийн бодлогын анхдугаар чуулганаар төлбөрийн систем, цахим мөнгө, криптовалют, финтекийн талаар мэдээлэл хийсэн.

Үндэсний төлбөрийн системийн болзошгүй эрсдэлийг удирдах, аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтлан төлбөрийн системийн оролцогчийн үйл ажиллагаа, холбогдох гэрээ, журам, зааврын хэрэгжилтэд иж бүрэн шалгалтыг хийж дууссан. Шалгалттай холбоотой зөрчил гаргасан банканд хугацаатай үүрэг өгч ажиллалаа.

3.3. Олон улс, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ;

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нь оролцогч талуудын хамтын ажиллагааны тэнцвэртэй байдлыг хангаж, авч буй арга хэмжээ, үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэн шаардлагатай арга хэмжээнд төвлөрөх боломжийг олгох зэрэг давуу талыг бий болгодог. Тус хөтөлбөр хэрэгжсэнээр иргэдийн санхүүгийн сахилгыг сайжруулах, санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжлийг дэмжих боломжтой болно.

Хөтөлбөрийг дараах 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- Сургуулийн насныханд санхүүгийн мэдлэг олгох

- Залуу үед санхүүгийн мэдлэг олгох
- Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох
- Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан санхүүгийн мэдлэг олгох

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах гол сэдвүүдэд чиглэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн талаарх суурь ойлголтууд;
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт;
- Хадгаламж;
- Зээл;
- Хөрөнгө оруулалт;
- Санхүүгийн эрсдэлээс хамгаалах (Даатгал гэх мэт) ;
- Тэтгэврийн хуримтлал үүсгэх;
- Нийгмийн даатгал болон татварын талаарх ойлголтууд;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын ойлголтууд;

Хөтөлбөрийн хүрээнд 2018 оны II улиралд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ:

БСШУС-ын сайдын 2018 оны 07 сарын 09-ний А/453 дугаар “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалаар санхүүгийн мэдлэг олгох “Бизнес судлал” хичээлийг ахлах ангиудад сонгон судлуулахаар батлав. “Дэлхийн мөнгөний долоо хоног-2018” олон улсын арга хэмжээнд нийт 137 улсын 23,738 байгууллага хамрагдан, залуусын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Мөнгөний асуудал бол чухал” агуулгын хүрээнд гуравдугаар сард зохион байгуулж байна. Энэ хүрээнд дэлхий даяар 72,759 арга хэмжээ зохиогдож буй бөгөөд тэдгээрт нийт 7 сая 800 мянга гаруй залуус хамрагдлаа. Монгол Улс ч “Дэлхийн мөнгөний долоо хоног-2018”-д нэгдсэнээр энэ долоо хоногийг хүүхэд залууст мөнгөний талаарх ойлголт, мэдлэгийг өгөх цуврал өдөрлөгүүдийг зохион байгуулан өнгөрүүлэв. Тодруулбал, Монголбанк, Монголын Банкны Холбоо, арилжааны банкууд хамтран ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 700 сурагчид “Мөнгөний асуудал бол чухал” сэдвээр хичээл заав. Мөн 80 сурагч Төв банкны Эрдэнэсийн сангаар зочлон, “Төв банкны бодлого иргэдэд хэрхэн нөлөөлдөг вэ”, “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ?” сэдвээр илтгэл сонсож өнгөрүүлээ.

Бага болон өсвөр насны хүүхдэд санхүүгийн мэдлэг олгох “Анар Ану хоёр” цуврал зурагт номын №1 “Хүсэл үү Хэрэгцээ юу?”, №2 “Мөнгө бол мөрөөдөлд хүрэх хэрэгсэл”, №3 “Мөнгөний мангас” дугаарууд дахин хэвлэгдэж, сурагчдын гарт хүрэв. 2018 оны 6-р сарын 4-ний өдөр “Өнөр

бүл” хүүхдийн төв болон “Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн төв”-ийн өсвөр насны 50 хүүхдэд санхүүгийн суурь боловсрол олгох сургалт, Монголбанкны Эрдэнэсийн сантай танилцах үйл ажиллагааг зохион байгууллаа. Уг арга хэмжээг Монголбанк, Банк Санхүүгийн Академи, Хадгаламжийн даатгалын корпораци, арилжааны 4 банк хамтран зохион байгуулав.

БЗД-ийн Залуучуудын холбоотой хамтран ЕБС-ийн 50 төгсөгчдөд “Төв банк юу хийдэг вэ?” сэдвээр лекц уншин, гарын авлага түгээж, залуучуудын сонирхсон асуултуудад хариулав.

Залуучуудад санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

Нийт 11 их, дээд сургууль “Хувь хүний санхүү” хичээлийг сургалтын хөтөлбөртөө оруулсан. Үүнтэй уялдуулан ХНХЯ-наас “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд политехник коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн сургалтын хөтөлбөрт “Хувь хүний санхүүгийн мэдлэг”, “Хувь хүний санхүү, бизнес, аж ахуй эрхлэлт” зэрэг хичээлийг оруулсан бөгөөд тус хичээлийг заах Улаанбаатар хот болон 21 аймгийн 93 мэргэжлийн багш нар, арга зүйчдэд мэдлэг олгох, чадавхжуулах “сургагч багш” бэлтгэх сургалтыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран 2 удаа зохион байгуулав. Бэлтгэгдсэн багш нар нь жил бүр сургалтын 85 байгууллагын 38 000 орчим сурагчдад хүрч ажиллах юм.

Мөн ХНХЯ-ны Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллах уулзалт хийн, 5 дугаар сарын 22-24-нд нийт 100 ажилтанд санхүүгийн боловсрол олгох сэдвээр сургалт зохион байгуулав. Монголбанк, Монголын Банкны Холбоотой хамтран “Таны санхүүгийн боловсролд: Мөнгөө хэрхэн зөв удирдах вэ?” сэдэвт санхүүгийн боловсрол олгох лекц, нээлттэй арга хэмжээг 3-р сарын 31-ний өдөр Корпорейт Конвейншн Центрт дахин зохион байгуулав. Лекцэнд 1000 гаруй хүн хамрагдаж, өдөр тутмын үргүй зардлыг бууруулах, амьдралын түвшин, чанараа бууруулахгүйгээр хуримтлалтай болох, мөнгийг өөрийнхөө ирээдүйд зориулан хэрхэн төлөвлөх, хөрөнгөтэй болох энгийн аргууд, түүнчлэн санхүүгийн төлөвлөгөөтэй амьдрах нь зэрэг сэдвээр мэдээлэл авлаа.

Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

Монголбанк, Бичил санхүүгийн хөгжлийн сан, БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв /НТБҮТ/ хамтран насанд

хүрэгчдэд санхүүгийн боловсрол түгээх “Хувь хүний санхүү” багшийн номыг боловсруулан, хэвлүүлэв. Орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох “СУРГАГЧ БАГШ бэлтгэх” сургалтыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Бичил санхүүгийн хөгжлийн сан хамтран 2018 оны 04-р сард баруун бүсийн Говь-Алтай, Баянхонгор аймагт, 06-р сард зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт тус тус зохион байгуулж сургалтад нийт 193 багш оролцож, мэдлэг чадвараа дээшлүүллээ. Сургалтын хүрээнд аймгийн төр захиргааны байгууллага, арилжааны банкны төлөөлөл болон сэтгүүлчдэд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”, “Эдийн засгийн нөхцөл байдал”, “Хөрөнгийн зах зээл” зэрэг сэдвээр мэдээлэл өгөв.

Олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

Санхүүгийн мэдлэг олгох www.sankhuuginbolovsrol.mn цахим хуудсыг хөгжүүлэн, олон нийтэд мэдээлэл түгээхэд идэвхтэй ашиглаж байна. “Монголбанкны мэдээлэл” товхимолд санхүүгийн боловсрол олгох буланг тогтмол ажиллуулж байна. Мөн санхүүгийн боловсрол олгох видео шторкуудыг бэлтгэж, 2018 оны эхний хагас жилд “Валютын ханш гэж юу вэ?”, “Зээлийн мэдээллийн сан гэж юу вэ?” сэдвээр видео хичээл боловсруулан олны хүртээл болголоо.

Үүнээс гадна, Монголын үндэсний олон нийтийн радиогоор Даваа гараг бүрт санхүүгийн боловсрол олгох “Санхүүгийн мод” нэвтрүүлгийг шууд эфирээр түгээн ажиллаж байна. “Санхүүгийн боловсрол” facebook page-ийг 2018 оны 05 сард нээснээр нийт 365 дагагчтай болж, мэдээлэл үзсэн байдал нь 19760-д хүрсэн бөгөөд иргэдээс ирүүлсэн асуултад тухай бүр хариулж, мэдээ мэдээлэл түгээн ажиллаж байна.

Харилцагч байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажилласан байдал:

Дэлхийн банкны техникийн туслалцааны хүрээнд орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох зурагт ном боловсруулах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн /ОНССМДХ/ мониторинг хийх зөвлөмжийг хүлээн авав.

ХБНГУ-ын Хадгаламжийн банкны Олон улсын сан Монголбанктай хамтран “Монгол Улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хосолсон сургалт”, “Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд буюу 2018 оны 2 дугаар улиралд:

- Төслийн хүрээнд онол, практик хосолсон сургалтын Нягтлан бодох бүртгэлийн 5 модуль хичээлийг 06-р сарын 11-15-ны өдөр амжилттай зохион байгуулав.
- ХБНГУ-ын Потсдам хотноо 2018 оны 04 дүгээр сарын 08-наас 04 дүгээр сарын 15-ны хооронд Хадгаламжийн банкны олон улсын сангийн академиас (Sparkassenakademie) зохион байгуулсан “сургагч багш бэлтгэх” сургалтад Төв банк, арилжааны банкны 15 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож, “сургагч багш”-ийн эрхээ авав.
- Нийт 11 банк тус төсөлд хамрагдаж байгаагаас 10-тай нь харилцагчид зөвлөх банкны мэргэжилтэн бэлтгэх хосолмол сургалтын дадлагын явцтай танилцав.

3.4. Мөнгө, санхүүгийн болон гадаад секторын статистик мэдээллийг олон улсын мэдээлэл түгээх тусгай стандартын дагуу нийтэд мэдээлж эхэлнэ;

ОУВС-гийн гишүүн орнуудын төв банкны эзэмшилд буй гадаад валютын нөөцийн хөрвөх чадварыг тодорхойлох, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ОУВС нь “Мэдээлэл түгээх тусгай стандарт (SDDS)”-д нэгдсэн гишүүн орноос “Гадаад валютын албан нөөц, түүний хөрвөх чадвар: Тоон мэдээний маягтыг боловсруулах удирдамж”-д заасан 4 маягтын дагуу албан нөөцийн мэдээлэл, гадаад өрийн статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах, бодлогын судалгаа, шинжилгээнд ашиглах зорилгоор гадаад өрийн тоон мэдээллийг гарын авлагад заасны дагуу тус тус бэлтгэн ирүүлэхийг шаарддаг. Энэ дагуу маягтуудыг Монгол хэлэнд хөрвүүлэх, холбогдох тоон мэдээллийг бэлтгэн ОУВС-д хүргүүлэх, ирүүлсэн санал, зөвлөмжийн дагуу нэмэлт тооцооллыг эцэслэн боловсруулаад байна. Харин гадаад валютын албан нөөцийн мэдээллийг олон нийтэд мэдээлэхтэй холбоотойгоор “Монголбанкны үйл ажиллагаанд хамаарах төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулан олон нийтэд мэдээлэн ажиллаж байна. .

ТӨСЛИЙН ТООЦОО, СУДАЛГАА

1. ИНФЛЯЦИ

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн жилийн инфляци 2018 оны 7 дугаар сарын байдлаар Улсын хэмжээнд 7.7 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 8.8 хувь байна. Инфляцид дараах хүчин зүйлс голлох нөлөөг үзүүллээ.

1) Цаг агаарын нөхцөлөөс үүдэн хатуу түлшний үнэ өнгөрсөн оны 8-11 дүгээр сар болон 2018 оны 1-3 дугаар сард нийт 60.6 хувиар өссөн.

2) Махны үнэ 6 дугаар сарын дунд хүртэл өсч, оны эцэс рүү хямдардаг улирлын хандлагаасаа зөрж 7 дугаар сарын дунд хүртэл өссөнөөр 6 болон 7-р сарын инфляци өсгөхөд нөлөөллөө.


3) Өнгөрсөн онд хураасан ургацын хэмжээ бага (төмс, хүнсний ногооны ургац 2016 онтой харьцуулахад 20-40 хувиар буурсан) байсан нөлөөгөөр хүнсний ногооны үнэ өмнөх оны мөн үеэс 10-50 хувиар өндөр түвшинд хадгалагдаж байна.

4) Дэлхийн зах зээл дээрх нефтийн бүтээгдэхүүн болон Монгол улсад импортлогдож буй шатахууны хилийн үнэ 40 орчим хувиар өссөнөөс шалтгаалан дотоодын зах зээлд шатахууны үнэ өнгөрсөн оны мөн үеэс 250 орчим (тайлант оны 5-7 дугаар сард 130 орчим) төгрөгөөр нэмэгдлээ.

Зураг 10. Улсын болон Улаанбаатар хотын инфляци



Зураг 11. Улаанбаатар хотын жилийн инфляцийн задаргаа



Эх сурвалж: ҮСХ

Ингэснээр мах болон хүнсний ногооны үнийн өндөр өсөлтөөс үүдэн Улаанбаатар хотын суурь болон ерөнхий инфляцийн зөрүү нэмэгдлээ. Суурь инфляци сүүлийн саруудад харьцангуй тогтвортой хадгалагдаж, 7 дугаар сарын байдлаар 7.5 хувь байна.

**Хүснэгт 1. Жилийн инфляцид голлох нөлөө үзүүлсэн бараа, бүтээгдэхүүнүүд
7 дугаар сарын байдлаар:**

Нэр төрөл	Жин	Жилийн өсөлт	Жилийн инфляцид эзлэх хувь
Хатуу түлш	0.03	53.8%	1.6%
Мах	0.10	12.2%	1.1%
Хүнсний ногоо	0.02	45.8%	1.0%
Шатахуун	0.06	15.3%	0.8%
Согтууруулах ундаа ⁸	0.06	9.5%	0.5%

Эдийн засаг эрчимжиж, нийт мөнгөний нийлүүлэлт өндөр өсөлттэй байгаа хэдий ч энэ нь эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамтыг нэмэгдүүлэхгүй байна. Түүвэр судалгаа⁹-наас үзэхэд иргэдийн инфляцийн хүлээлт 2018 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас буурч, цаашид инфляци хэвэндээ хадгалагдана гэсэн хандлага давамгайлсан хэвээр байна.

Мөн цаашид дэлхийн зах зээл дээрх нефтийн үнийн өсөлттэй холбоотойгоор шатахууны үнэ өсч, инфляцийг нэмэгдүүлэх эрсдэл байгаа ч нөгөө талаас одоогийн үнийн өсөлтийн багагүй хэсгийг тодорхойлж буй түр зуурын шинжтэй хүчин зүйлсийн нөлөө саарснаар инфляци 2018 онд зорилтот түвшинд хадгалагдахаар байна.

ШИГТГЭЭ 1. ӨР, ОРЛОГЫН ХАРЬЦААНД ДЭЭД ХЯЗГААР ТОГТООХ

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, өрхийн хямралд өртөх эмзэг байдлыг бууруулах зорилгын хүрээнд өрхийн өрийн хэт өсөлтийг хязгаарлах мөчлөг сөрсөн макро зохистой бодлогыг хэрэгжүүлэхэд олон улсад түгээмэл ашигладаг хэрэгслүүдийн нэг нь өр, орлогын харьцаа (ӨОХ)-ны хязгаарлалт юм.

Уул уурхайн салбарт түшиглэсэн, жижиг нээлттэй эдийн засагтай орнуудын хувьд санхүүгийн зах зээл нь гадаад эдийн засгийн орчноос ихээхэн хамааралтай байдаг. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн түр зуурын эерэг шокийн нөлөөгөөр эдийн засаг сэргэж, эрсдэл буурах үед банкууд зээлийн шаардлагыг сулруулж зээл олголтыг нэмэгдүүлдэг бол нөгөө талаас орлого өснө гэсэн хүлээлтийн дагуу иргэд ирээдүйн орлогоо барьцаалан зээл авч хэрэглээгээ нэмэгдүүлдэг. Үүний үр дүнд өрхийн өр, зээлийн хэмжээ хурдацтай нэмэгдэх нь түр хугацаанд хэрэглээгээр дамжин эдийн засгийн өсөлтийг дэмждэг. Түүхий эдийн үнэ буурч, эдийн засаг уналтад ороход; 1) зээлтэй өрхүүд хэрэглээгээ огцом танаж, хямралыг гүнзгийрүүлэх, 2) иргэдийн бодит орлого буурч, ажлын байр хумигдсанаар хэрэглээний зээлийн чанар муудаж, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг. Иймд мөчлөг сөрсөн макро зохистой бодлогын хүрээнд өрхийн хэрэглээний зээл хэт ихээр өсч, өрхүүд өрийн дарамтад орохоос урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх нь санхүүгийн болон бодит эдийн засгийн савлагааг бууруулах ач холбогдолтой.

⁸ 2018 оны 1 дүгээр сараас импортын архи, тамхины онцгой албан татварыг 10%-иар нэмэгдүүлсэн.

⁹ “Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны тайлан” Монголбанк, 2018 оны 2 дугаар улирал

Өр, орлогын харьцаа нь зээлдэгчийн нийт зээлийн сарын төлбөрийг тухайн зээлдэгчийн татварын дараах сарын орлогын сүүлийн 12 сарын дунджид харьцуулсан харьцаа юм. Энэхүү харьцаанд хязгаарлалт тогтоосноор зээлдэгчийн авч болох нийт зээлийн хэмжээ нь түүний орлого, төлбөрийн чадвартай нийцтэй байж, иргэдийн өрийн дарамт нэмэгдэхгүй байх ач холбогдолтой. ОУВС-гийн судалгаагаар 2018 онд 42 улс ӨОХ-нд хязгаарлалт тогтоох замаар өрхийн өрийн болзошгүй эрсдэлийг хязгаарлах бодлого хэрэгжүүлж байна. ӨОХ нь дараах эрсдэлүүдийг бууруулахад голчлон чиглэдэг. Үүнд:

Зээлийн хэт өсөлтийг хязгаарлаж, зээлийн мөчлөгийн далайцыг бууруулах

ӨОХ-ны хязгаарлалтыг чангаруулснаар зээлдэгчийн боломжоос нь давсан зээлийг хязгаарлаж, зээлийн эрэлтийг бууруулна. Ингэснээр зээлийн хэт өсөлтийг хязгаарлан, эдийн засгийн халалт бий болохоос сэргийлдэг.

Үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөс бий болохоос сэргийлэх

Эдийн засаг хурдтай өсөх үед үл хөдлөх хөрөнгийн эрэлт нэмэгдэж, үнийн хөөс бий болох хандлагатай байдаг. Иргэд үнэ нь өссөн орон сууцыг зээлээр худалдан авах, түүнийг барьцаалан хэт их зээл авснаар өрхийн өрийн түвшин нэмэгддэг. Харин үнийн хөөс хагарч, үл хөдлөх хөрөнгийн үнэ буурахад өндөр үнээр орон сууц худалдан авсан иргэд зээлээ төлөхгүй болж, улмаар зээлийн чанарт сөргөөр нөлөөлдөг. Үл хөдлөх хөрөнгийн эрэлтийг үнийн хөөс бий болгохгүй түвшинд хадгалж, үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөс бий болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор олон улсад ӨОХ-ны хязгаарлалтыг зээл үнэлгээний харьцааны хязгаарлалттай хослуулан ашигладаг.

Банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх

ӨОХ-г хязгаарласнаар зээлдэгчийн өрийн дарамт багасч, төлбөрийн чадвар сайжрах тул санхүүгийн байгууллагуудын дархлаа сайжирдаг. Үүний зэрэгцээ ӨОХ-г чангаруулах шийдвэрийг олон нийтэд оновчтой тайлбарлан таниулах нь хүлээлтийн сувгаар дамжин банкуудын эрсдэлийн удирдлагад эерэгээр нөлөөлж, зээлийн хэт өсөлтийг бууруулдаг.

Монгол улсын банкны салбарын нийт зээлийн хэмжээ 2018 оны 2 дугаар улиралд 15.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.6 хувиар өссөн. Энэхүү өсөлтийн 10.7 нэгж хувийг зөвхөн хэрэглээний зориулалттай зээл бүрдүүлж байна. Мөн 2018 оны 2 дугаар улирлын байдлаар өрхийн нэрлэсэн орлого 11.2 хувийн өсөлттэй байхад өрхийн зээлийн хэмжээ 24 хувиар өсч, өрхүүд дунджаар сарын орлогынхоо 70 орчим хувийг зээлийн эргэн төлөлтөд зарцуулж байна. Хэрэглээний зээл цаашид улам эрчимжих нь дараах эрсдэлүүдийг нэмэгдүүлэхээр байна.

1. 2018 оны 5 дугаар сарын 31-ний байдлаар хэрэглээний зээлтэй иргэд сард дунджаар татварын дараах орлогынхоо 69 хувийг зээлийн төлбөрт төлж байгаа бол энэ төрлийн нийт зээлийн 28 хувийг авсан зээлдэгчид татварын дараах орлогынхоо 75 буюу түүнээс дээш хувийг зээлийн сарын төлбөрт төлж байна. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр 2018 онд Монгол улсын нэг иргэний амьжиргааны баталгаажих доод түвшин 198600 төгрөг байгаа нь татварын дараах өрхийн дундаж орлогын¹ 24.4 хувийг эзэлж байна. Иймд татварын дараах орлогынхоо 75.6 болон түүнээс дээш хувийг зээлийн сарын төлбөрт төлж буй зээлдэгчид амьжиргааны наад захын хэрэглээгээ санхүүжүүлэхэд хүндрэлтэй болж байгаа тул цаашид өрхийн хэрэглээний зээл нэмэгдэх орон зай хязгаарлагдмал байна.

2. Эдийн засгийн тэлэлтийн үед эдийн засгийн идэвхжил сайжирч иргэдийн орлого өсөхөд банкууд ӨОХ-ны шаардлагыг сулруулан хэрэглээний зээлийг хэт ихээр нэмэгдүүлэх, улмаар өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг хөөрөгдөх, эдийн засгийн мөчлөгийн савалгааг ихэсгэх, хэрэглээний импортыг өсгөж төлбөрийн тэнцлийн дарамтыг үүсгэх эрсдэлтэй байна.

3. Харин эдийн засгийн идэвхжил сулрах үед ажил эрхлэлт хумигдан өрхийн орлого буурч, нэг талаас зээлийн эргэн төлөлт муудах, нөгөө талаас өрхийн хэрэглээ (ДНБ-ий 60 хувийг бүрдүүлдэг) огцом хумигдан борлуулалт саарснаар эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Иймд Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2018 оны 6 дугаар сарын хурлаар 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг зээлдэгчийн татварын дараах орлогын 70 хувиар тогтоох шийдвэр гаргасан. Энэхүү шийдвэр гарснаар:

- Иргэдийн хэрэглээний зээлийн хэт өсөлтийн нөлөөгөөр санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдаж, бодит эдийн засгийн мөчлөгийн савалгаа нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх;
- Банкны зээлийн эх үүсвэрийг бизнес, хөрөнгө оруулалт, ажил эрхлэлтийг дэмжих салбарт чиглүүлж, иргэдийн орлогын өсөлтөд түшиглэсэн өнөөгийн ба ирээдүйн тогтвортой хэрэглээг дэмжих;
- Банкууд зээлийн зохистой бодлого баримталж, зээлдэгчийн санхүүгийн сахилга батыг урамшуулж, санхүүгийн эх үүсвэрийг оновчтой хуваарилснаар бизнесийн зээлийн нийлүүлэлт нэмэгдэн хүү буурах;
- Өр, орлогын харьцаа өндөр, олон давтамжтай сунгадаг иргэдийн хэрэглээний зээлийн өсөлтийг аажмаар сааруулах замаар иргэдийн өрийн дарамтыг бууруулж, амьжиргааг хамгаалах ач холбогдолтой.


¹ 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол улсын ажил эрхэлж буй иргэдийн гарт олгох дундаж цалингийн хэмжээ 811,386 төгрөгтэй тэнцэж байна.

II. БОДИТ СЕКТОР


2.1. Нийт нийлүүлэлт

Эдийн засаг 2018 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өслөө. Эдийн засгийн дийлэнх салбаруудад өсөлт гарахад мөнгөний бодлого зөөлөрч, зээлийн хүү буурч, зээл олголт нэмэгдсэн, гадаад болон дотоод зах зээлд оролцогчид, хөрөнгө оруулагчдын итгэл сайжирсан, экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ 2018 оны эхний хагас жилд өндөр түвшинд хадгалагдсан, уул уурхайн салбарын томоохон бүтээн байгуулалт хийгдэж буй зэрэг хүчин зүйл голлон нөлөөллөө.

Зураг 12. ДНБ-ий жилийн өсөлт



Зураг 13. ДНБ-ий жилийн өсөлтөд эзлэх хувь





Эх сурвалж: ҮСХ

Үйлдвэрлэл талаас барилгаас бусад салбарын үйл ажиллагааны идэвхжил нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтийг тэтгэж байна. Уул уурхайн бус салбар 2018 оны эхний хагас жилийн байдлаар 7.5 хувиар өслөө. Салбар бүрээр авч үзвэл худалдаа 1.0 нэгж хувь, боловсруулах салбар 0.8 нэгж хувь, бусад үйлчилгээний¹⁰ салбар 1.2 нэгж хувь болон бүтээгдэхүүний цэвэр татвар¹¹ 2.5 нэгж хувиар эдийн засгийн өсөлтөд голлох нөлөөг үзүүлсэн. Нөгөөтэйгүүр уул уурхай 0.3 нэгж хувь, эрчим хүч 0.2 нэгж хувиар өсөлтийг тэтгэж, хөдөө аж ахуй, тээврийн салбар төдийлөн өндөр нөлөө үзүүлсэнгүй.

¹⁰ Бусад үйлчилгээний салбарын өсөлтийн дийлэнх хэсгийг санхүү, даатгалын үйл ажиллагаа бүрдүүлдэг.

¹¹ Бараа, бүтээгдэхүүнд ногдуулж буй дотоодын НӨАТ, импортын НӨАТ, гаалийн албан татвар болон онцгой албан татвараас бүрддэг.

Зураг 14. Аж үйлдвэрийн салбаруудын өсөлт**Зураг 15. Үйлчилгээний салбаруудын өсөлт***Эх сурвалж: УСХ*


2.2. Нийт эрэлт

Энэ оны эхний хагас жилийн ДНБ-ий өсөлтөд хөрөнгө оруулалт, өрхийн хэрэглээ, экспортын өсөлт голлон нөлөөллөө. Эдийн засгийн өсөлтийг даган импортын хэрэглээ нэмэгдэж байна.

Нийт хөрөнгө оруулалт (хөрөнгийн хуримтлал)-ын хэмжээ эхний хагас жилд 36.9 хувиар өсч, эдийн засгийн өсөлтөд 12.6 нэгж хувийн голлох нөлөөг үзүүлэв. Хөрөнгө оруулалтын нөлөөгөөр үндсэн хөрөнгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 39.9 хувиар нэмэгдсэн бол борлуулахад болон хэрэглэхэд бэлэн бараа материалын нөөц хөрөнгө 31.2 хувиар өслөө. Үндсэн хөрөнгийн хуримтлал өсөхөд Оюу толгой төслийн 2 дугаар шатны хөрөнгө оруулалттай холбоотой машин тоног төхөөрөмж худалдан авалт, орон сууцны бус барилга байгууламжийн өсөлт голлон нөлөөлж байна.

Эхний хагас жилийн байдлаар өрхийн нэрлэсэн орлого 11.2 хувиар, өрхийн зарлага 7.6 хувиар өслөө. Өрхийн орлого өсөхөд цалин, хувийн аж ахуйн орлого нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Өрхийн орлого өсч байгаа ч өрхийн зарлага орлогоосоо давсан хэвээр байна. Орлогоос давсан зардлыг хэрэглээний зориулалттай зээл (хэрэглээний зээл, цалин болон тэтгэвэр барьцаалсан зээл)-ээр санхүүжүүлж байна. Эхний хагас жилд засгийн газрын хэрэглээ 3.6 хувиар өсч, эдийн засаг дахь нийт эрэлтийн өсөлтөд 0.5 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн.

Зураг 16. ДНБ-ий жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр



Зураг 17. Хөрөнгө оруулалтын өсөлт




Эх сурвалж: УСХ

Бараа, үйлчилгээний экспорт эхний хагас жилд бодит дүнгээр 13.6 хувиар өсч, эдийн засгийн өсөлтөд 10.7 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэхэд зэсийн баяжмал болон түүнд агуулагдах металлын агууламж, төмрийн хүдрийн экспорт өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бол нөгөөтэйгүүр, нүүрс, алт, газрын тосны экспорт саарчээ.

Эдийн засгийн идэвхжилийг даган үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын шаардлагатай машин тоног төхөөрөмж, аж үйлдвэрийн орц, нефтийн бүтээгдэхүүний импортын өсөлт өндөр байна. Мөн өрхийн хэрэглээ нэмэгдэхийн хэрээр хэрэглээний зориулалттай импорт ч өсөлттэй байна. Улмаар 2018 оны эхний хагас жилд бараа, үйлчилгээний импорт бодит дүнгээр экспортын өсөлтөөс давж, 24.4 хувиар өссөн нь өсөлтийг 21.0 нэгж хувиар сааруулах нөлөөтэй байлаа.

III. УЛСЫН ТӨСӨВ

2018 оны эхний 7 сарын төсвийн гүйцэтгэл: Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн тайлант хугацаанд 5052 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 4761 тэрбум төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 291 тэрбум төгрөгийн, анхдагч тэнцэл 871 тэрбум төгрөгийн эерэг дүнтэй байв.

Зураг 18. Нэгдсэн төсвийн орлого, зардал, тэнцэл**Зураг 19. Нэгдсэн төсвийн орлого, зардлын жилийн өөрчлөлт (%)***Эх сурвалж:* Сангийн яам

Эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн, зарим төрлийн татвар өөрчлөгдсөн, барааны импортын дүн өмнөх оны мөн үеэс 39.9 хувиар өссөнтэй холбоотойгоор нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого бүрдүүлэлт 2017 оны мөн үеэс 29.3 хувиар буюу 1153 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ. Татварын орлого (тэнцвэржүүлсэн орлогын 88.5 хувийг бүрдүүлсэн) 31 хувиар, татварын бус орлого 4 хувиар өсчээ.

Татварын орлогыг бүрэлдэхүүн хэсгээр задалж харвал импорттой холбоотой орлого 467 тэрбум төгрөгөөр, орлогын албан татвар 278 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын орлого 145 тэрбум төгрөгөөр, дотоодын бараа, үйлчилгээний татвар 98 тэрбум төгрөгөөр өмнөх оны мөн үеэс тус тус нэмэгджээ.

2018 оны эхний 7 сарын байдлаар төсвийн зарлага өмнөх оноос 6.1 хувиар (271 тэрбум төгрөг) тэлж 4761 тэрбум төгрөгт хүрлээ. Төлөвлөсөн дүнтэй харьцуулахад урсгал зардал 87.1 хувь (555.7 тэрбум төгрөгөөр дутуу), хөрөнгийн зардал 41.0 хувь (331.4 тэрбум төгрөг дутуу), эргэж төлөгдөх цэвэр зээл 68.3 хувийн (58.8 тэрбум төгрөг дутуу) зарцуулалттай байна. Сүүлийн жилүүдийн хандлагатай адил оны эхний саруудад төсвийн зардлын гүйцэтгэл тайлант онд бага байна. Батлагдсан төсвөөр 2018 онд нийт зардал өнгөрсөн оноос 7.5 хувиар буюу 671 тэрбум төгрөгөөр өсөхөөр хүлээгдэж байна. Үүний дийлэнх хэсгийг хөрөнгийн зардлын болон урсгал шилжүүлгийн өсөлт бүрдүүлнэ.

Хүснэгт 2. Монгол улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

тэрбум төгрөг	2017	2018	Өмнөх 3 жилийн дундаж /2015.07-2017.07/	2018.07	
	Гүй.	Бат.		Гүй.	%
Нийт орлого	7922	7863	3487	5620	116.7
Ирээдүйн өв сан	358	509	73	409	144.9
Тогтворжуулалтын сан	326	123	53	158	218.9
Тэнцвэржүүлсэн орлого	7239	7231	3361	5052	113.2
Татварын орлого	6303	6269	2923	4471	116.5
Импорттой холбоотой татварын орлого	1860	2114	816	1411	115.3
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1032	1095	421	761	121.8
Гаалийн албан татвар	512	537	201	367	124.1
Онцгой албан татвар	316	482	194	283	93.4
Орлогын албан татвар	1610	1408	678	1159	113.1
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1314	1425	650	854	107.0
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	986	823	402	557	119.6
НӨАТ-н буцаан олголт	-147	-198	-55	-93	63.6
Бусад татварын орлого	679	698	341	583	114.3
Татварын бус орлого	936	962	437	581	93.2
Нийт зардал	8981	9652	4428	4761	75.5
Анхдагч зардал	7825	8501	4004	4181	74.9
Урсгал зардал /-хүүний зардал/	5850	6305	3144	3434	87.1
Хөрөнгийн зардал	1646	1929	616	562	41.0
Цэвэр зээл	329	267	244	185	68.3
Хүүний зардал	1156	1151	424	579	80.6
Нийт тэнцэл	-1742	-2420	-1067	291	
ДНБ-д эзлэх хувь	-6.5%	-8.0%	-3.5%	1.0%	
Анхдагч тэнцэл	-586	-1269	-643	871	
ДНБ-д эзлэх хувь	-2.2%	-4.2%	-2.1%	2.9%	

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд 2210 тэрбум төгрөгийн эх үүсвэр улсын төсөвт шаардлагатай байгаагаас 1423 тэрбум төгрөгийг дотоод үнэт цаасны эргэн төлөлтөд, 667 тэрбум төгрөгийг гадаад үнэт цаасны эргэн төлөлтөд, 120 тэрбум төгрөгийг гадаад төслийн зээлийг төлөхөд тус тус зарцуулсан. Дээрх 2210 тэрбум төгрөгийн ихэнх хэсгийг буюу 1514 тэрбум төгрөгийг төсвийн орлого бүрдүүлэлт, Засгийн газраас Төв банкинд байрших харилцах болон хадгаламжийн данснаас төлж, үлдсэн хэсгийг Ирээдүйн өв сангийн шилжүүлэг, гадаадын хөтөлбөрийн болон төслийн зээлээр бүрдүүллээ.

Монгол улсын Хөгжлийн банкны одоогийн олгож буй зээлийн санхүүжилт нь өмнөх зээлийн эргэн төлөлтөөр хийгдэж байна. Энэ оны эхний 7 сарын байдлаар өмнө олгосон зээлээс 408.2 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдэж, шинээр 441.5 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон байна.

ШИГТГЭЭ 2. ИНСТИТУЦИЙН ЧАНАР

Тодорхойлолт, ач холбогдол

Институци буюу тогтолцоо гэдэг ойлголт нь тухайн улс, үндэстний соёл уламжлал, зан заншил, хууль ёс, дүрэм журам гэх мэт нийгмийн харилцааг уялдуулдаг *албан болон албан бус зарчим, зуршлуудыг нийлүүлсэн ухагдахуун юм*. Улс орны эдийн засгийн хөгжлийн хурдцыг газарзүйн онцлог, байгалийн баялаг, хөгжлийн түвшин гэх зэрэг хүчин зүйлсээс илүүтэй тогтолцооны хэлбэр нь тайлбарлаж байгаа талаар *Acemoglu болон Robinson (2012)* нар дүгнэсэн байдаг. Дэлхийн түүхэн хөгжлийн явцад олон янзын соёл, төрт ёсны хэлбэрүүдийн дотроос *хүртээмжтэй, ардчилсан, хуулийн засаглалтай улс орнууд илүү их баялаг хуримтлуулдаг* хандлагыг тоон мэдээллүүд харуулдаг. Тиймээс эдийн засгийн өсөлтийг дэмжихүйц сайн засаглалын үзүүлэлтүүдийг хэмжих олон аргуудыг эдийн засагчид санал болгосноос Дэлхийн банк, Дэлхийн эдийн засгийн форум зэрэг байгууллагуудын эрхлэн гаргасан үзүүлэлтүүд хамгийн түгээмэл ашиглагддаг. Тэдгээр тоон өгөгдлүүдээс дэлхийн улс орнуудыг харьцуулж хийсэн олон судалгаануудад эдийн засгийн тогтвортой өсөлттэй эерэг хамааралтай байгааг харуулсаар байна.

Засаглалын чанарыг хэмжих нь


Эдийн засгийг тогтвортой өсөлтөд хүргэх төрийн чиг үүрэг нь *хувийн хэвшлийн хэвийн үйл ажиллагаа, харилцан итгэлцлийг хангахад чиглэсэн* байдаг. Сайн төрийн үндсэн үүрэг нь аюулгүй байдал, шударга ёс, хувийн өмч, хууль болон гэрээний хэрэгжилтийг хангах бөгөөд зам тээврийн дэд бүтэц, харилцаа холбоо, эрчим хүч, ус, дулаан болон хог хаягдлын менежмент зэрэг төдийлөн хувийн сектор хийж гүйцэтгэх боломжгүй зохицуулалтуудыг хэрэгжүүлэх чиг үүрэг хүлээдэг. Мөн эрүүл мэнд, боловсролын үйл ажиллагааг хянах, зохицуулах, удирдахаас гадна үйл ажиллагааны зөвшөөрөл олгох, дүрэм журам боловсруулж хэрэгжилтийг хянах ажлыг зохицуулдаг. Тэгвэл эдгээр үндсэн чиг үүргийг улс орнуудын төр засаг нь хэрхэн хэрэгжүүлж чадаж байгааг иргэд, бизнес эрхлэгчдээс асуух болон бусад тогтсон тоон өгөгдлүүдийг харьцуулах зэргээр улс орнуудын үнэлгээг гаргадаг.

Эрсдэлийг хуваарилах нь


Сайн засаглалын хэв шинж, хувьсал нь эдийн засаг, бизнесийн орчны тодорхой бус байдлыг бууруулж улмаар эдийн засгийн үйл ажиллагааг дэмждэг (North, 1990). Эдийн засгийн өсөлт буюу үр ашигтай үйл ажиллагааг нэмэгдүүлэх нь өөрөө эрсдэлтэй үйл ажиллагаа учраас үүнийг төр болон хувийн хэвшлийн аль нь үүрэх талаар нэгдсэн ойлголттой байх нь тогтолцоо талаасаа тодорхой бус байдлыг хамгийн ихээр бууруулдаг. Төр нь эдийн засгийн үйл ажиллагаанаас татвар хэлбэрээр санхүүждэг учраас эдийн засгаас татсан хөрөнгөөр эдийн засгийг өөрийг нь өсгөнө гэдэг нь нийт эдийн засгаас үргэлж илүү өндөр үр ашигтай хөрөнгө оруулалт, зарцуулалт хийнэ гэсэн үг бөгөөд энэ нь статистикийн хувьд боломжгүй зорилт байдаг. Тиймээс төрийн үүрэг чиглэл нь эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлд байх нь бодитой зорилт болдог. Харин төр бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, хувь эзэмшдэг бол уг бизнес нь мөчлөгийн хувьд хувийн бизнесүүдийн эрсдэлийн мөчлөгөөс зөрж байвал эдийн засгийн тогтвортой хөгжилд нийцтэй байдаг.

Монгол улсын засаглалын байдал

Засаглалын чанарын хувьчилсан эрэмбэ (ДБ)



Тулгамдсан асуудлууд (ДЭЗФ)



Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Монгол улсын тогтолцооны чанарыг бусад улсуудтай харьцуулахад дундаж түвшинд байгаа бөгөөд *хуулийн хэрэгжилт, ЗГ-ын үр ашигтай байдал, авилгатай тэмцэх чиглэлээр бусад орнуудаас харьцангуй муу* үзүүлэлттэй байгааг цаашид сайжруулах шаардлагатай байна. Мөн валютын зохицуулалт, авилга, бодлогын тогтворгүй байдал, төрийн үйлчилгээний чанар, боловсон хүчний бэлтгэл зэрэг *төрийн үндсэн чиг үүргийн үзүүлэлтүүдийг сайжруулахад* анхаарал хандуулж шийдвэрлэх нь бизнес эрхлэгчдийн хувьд томоохон саад бэрхшээлийг шийдэхээр байна.

IV. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

4.1. Төсөөлөлд ашигласан гадаад зах зээлийн таамаглал

Гадаад эрэлт

БНХАУ болон ОХУ -ын эдийн засгийн өсөлт 2018 оны 2-р улиралд нэмэгдсэн, АНУ-ын эдийн засаг хэвээр хадгалагдсан бол Евро бүсийн эдийн засаг буурсан байна. Цаашид, (i) АНУ-ын Холбооны нөөцийн банк энэ ондоо багтаж мөнгөний бодлогоо аажмаар чангаруулах төлөвтэй, (ii) БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарах хандлагатай байгаа тул манай улсын экспортын бүтээгдэхүүний гадаад эрэлт сайжрах ааргүй байна. (iii) АНУ-аас ОХУ-д тавьсан хориггоо чангаруулсан ч газрын тосны үнэ өсөхөөр байгаа нь Оросын эдийн засгийн өсөлтийг дэмжих бол (iv) Евро бүсийн мөнгөний зөөлөн бодлого дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг дэмжсэн хэвээр байхаар байна.

Зураг 20. Гадаад эрэлтийн өөрчлөлт, хувиар



Эх сурвалж: Рубини, EIU, Блүмберг, ОУВС

Хятадын эдийн засгийн өсөлт 2018 оны эхний хагас жилд хүлээлтээс давж 6.7 хувьд хүрсэн. Хэдийгээр хувийн секторын өрийн хэмжээ, санхүүгийн тэнцлийн алдагдал өндөр хэвээр байгаа боловч төсвийн зөөлөн бодлогоор Засгийн газрын зардал, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн, Хятадын Ардын Банк эдийн засгийг дэмжих зорилгоор банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг 2018 оны 6-р сард 5 нэгж хувиар бууруулсан, жижиглэн худалдааны салбар идэвхжин худалдаа, хөрөнгө оруулалт өссөн нь эерэг нөлөө үзүүлээ. Үүний зэрэгцээ инфляци нам түвшинд, ажилгүйдэл 2018 оны 2-р улиралд 3.8 хувьд хүрч буурсан зэргээс харахад өрхийн хэрэглээ өсөхөөр байна.

БНХАУ-ын 2018 оны эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 6.6 хувь гэж шинжээчид үзэж байсан ч хурдацтай өсч буй хувийн секторын өрийн хэмжээ, Худалдааны маргаан анхаарал татсан хэвээр байна. Иймд Засгийн газраас өрийн хэмжээг дунд хугацаанд бууруулах, санхүүгийн зохицуулалтыг сайжруулах бодлогын арга хэмжээнүүдийг намынхаа 19 дүгээр их хурлаар баталсан. Энэхүү арга хэмжээ нь эдийн засгийн өсөлтийг дунд, урт хугацаанд өсөлтийг сааруулж болзошгүй гэж шинжээчид болгоомжилж байна. Түүнчлэн 2018-19 онд үргэлжлэхээр байгаа АНУ, БНХАУ хоорондын худалдааны зөрчилдөөний нөлөөгөөр дотоод эдийн засгийг дэмжих зорилгоор төсвийн болон мөнгөний бодлогыг аажмаар сулруулах хүлээлт үүсээд байна. Үүнтэй холбоотойгоор 2018 оны өсөлтийг 6.5 хувь болгож бууруулаад байна.

Харин ОХУ-ын эдийн засагт нефтийн үнийн өсөлт нь эдийн засагтаа эергээр нөлөөлж байгаа бөгөөд төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдэх хандлагатай байна. Эдийн засгийн тэлэлт, төсвийн тэлэлтийг баланслуулах зорилгоор Мөнгөний бодлогынхоо хүүг өсгөөд байна. 2018 оны эхний хагаст хувийн хэрэглээ 3.3 хувиар, нийт хөрөнгө оруулалт 2.8 хувиар, экспорт 5.8 хувиар, аж үйлдвэрлэл 2.2 хувиар тус тус нэмэгдсэн зэргээс шалтгаалан эдийн засаг нь өсөлттэй гарлаа. ОХУ-д тавьсан хоригоо АНУ 2018 оны 8 дугаар сард чангаруулсан, ам.долларын ханш чангарахаар байгаа нь тус эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөр байна. Гэсэн хэдий ч хувийн хэрэглээний өсөлт 2018 онд 3.8-4.0 хувьд хүрч өсөхөөр байгаа, ОПЕК-ийн үйлдвэрлэлээ танах тохиролцоог 2018 оныг дуустал хэвээр хадгалах шийдвэрт хүрсэн, АНУ-аас Иран Улсад тавьсан хоригийн 2-р үе шат 11-р сард хэрэгжиж эхлэх хүлээлт зэргээс хамааран газрын тосны үнэ өндөр түвшинд хадгалагдах төлөв, ОХУ-ын Засгийн газар татварын шинэчлэлтийн хүрээнд ирэх 6 жилд жилийн 13 тэрбум ам.долларыг төсвийн орлогод төвлөрүүлснээр 2018-19 онд төсөв ДНБ-ий 0.3 хувийн ашигтай ажиллахаар байгаа¹² нь Оросын эдийн засаг сэргэж 2018 онд 2.3 хувиар, 2019 онд 1.6 хувиар өснө гэж шинжээчид үзэж байна.


Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2018-2019 онд 1.8-1.9 орчим хувьд харьцангуй тогтвортой байх төлөвтэй байна. Европын төв банкны уламжлалт бус мөнгөний тэлэх бодлого 2018-19 онуудад үргэлжлэх төлөв, хэрэглээ нэмэгдэж эдийн засгийг дэмжих хэдий ч Евро бүсийн худалдааны түнш орнууд, хөгжиж буй орнуудын эдийн засаг удааширснаас бүсийн экспорт саарах хүлээлттэй зэргээс шалтгаалан өсөлт 2018 онд 1.8 хувь, 2019 онд 1.9 хувь хүрч өсөхөөр байна.

¹² Учир нь Оросын Засгийн газар төсвийнхөө алдагдлыг хэрхэн санхүүжүүлэх, олон улсын байгууллагаас зээл авах эсэх зэрэг төсвийн тодорхой бус байдал шинжээчдийн дунд байсаар байв.

Гадаад хүү

АНУ-ын ажилгүйдлийн түвшин буурч, хөдөлмөрийн зах идэвхжиж, иргэдийн бодит орлого болон хувийн хэрэглээ өссөн, инфляци өссөн, дэлхийн санхүүгийн зах зээл тогтворжиж эхэлсэн зэргээс үүдэн Холбооны нөөцийн банк бодлогынхоо хүүг 2018 оны 2-р улиралд 0.25 нэгж хувиар нэмэгдүүлсэн нь ам.долларын ханш голлох валютууд болон алтны эсрэг чангарахад нөлөөлөв.

Зураг 21. Холбооны нөөцийн банкны хүү, хувиар



Эх сурвалж: Блүмберг (-төсөөлөл)*

Холбооны нөөцийн банк энэ ондоо багтаж хамгийн багадаа 2 удаа буюу 9 дүгээр, 12 дугаар сард, 2019 онд гурван ч удаа бодлогын хүүгээ өсгөх магадлал өндөр байгаа бөгөөд АНУ-ын эдийн засаг 2018 онд 3.0 хувиар өсч, инфляци 2.4 хувьд хүрэх хүлээлт үүсээд байна.

Худалдааны нөхцөл

Гадаад худалдааны нөхцөл 2018 онд тогтвортой байх боловч 2019 онд муудахаар байгаа нь гадаад орчны сөрөг хүчин зүйл болж байна. 2018 оны эхний хагаст зэс, алт, нүүрс, газрын тосны үнэ өндөр түвшинд хадгалагдсан нөлөөгөөр экспортын үнэ хүлээлтээс сайжирсан. Цаашид газрын тосны үнэ өсөх төлөвтэй байгаа ч БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарах, том гүрнүүдийн хоорондын худалдааны зөрчилдөөн зэргээс шалтгаалан дэлхийн зах дээрх металлын үнэ буурч, манай экспортын үнийг бууруулах хандлагатай байна.

Судалгааны зарим агентлаг 2018 оны нийлүүлэлтийн төсөөллийг нэмэгдүүлсэн, АНУ, БНХАУ худалдааны зөрчилдөөн голлон нөлөөлж зэсийн

үнэ 2018 оны 8 дугаар сард 6105 ам.долларт хүрч буурсан байна. Цаашид зэсийн эрэлт нь Хятадын эдийн засгийн өсөлт, макро бодлого, олон улсын геополитикоос хамаарна. Харин зэсийн нийлүүлэлтэд Чили дэх уурхайн ажилчдын цалин, ажлын нөхцөлтэй холбоотой асуудал¹³ болон сэргээгдэх эрчим хүч, цахилгаан тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл ирэх хоёр жилд өсөх зэрэг хүчин зүйлс нөлөөлөхөөр байна. Дэлхийн цэвэр зэсийн үйлдвэрлэлийн хэмжээ 2018 онд 21.4 сая тонноос 2019 онд 22.3 сая тонн хүрч нэмэгдэхээр байгаа нь дунд хугацаанд үнэ буурах хүлээлт бий болоход нөлөөлж байна.

Цаашид АНУ-ын ажилгүйдлийн түвшин буурах, Холбооны нөөцийн банк бодлогынхоо хүүг ахин нэмэгдүүлэх төлөвтэй байгаагийн зэрэгцээ хөгжингүй орнуудын инфляци тогтвортой нам түвшинд хадгалагдахаар байгаа нь ам.долларын өгөөжийг нэмэгдүүлж 2018-2019 онд алтны үнэ буурахад нөлөөлнө гэж үзэж байна.


БНХАУ-ын Засгийн газар агаарын бохирдлыг бууруулах зорилгоор хорт хий бага ялгаруулдаг өндөр чанартай нүүрс импортлох зорилт тавьж байна. Энэхүү зорилтын хүрээнд Хятадын дотоодын нүүрс олборлолт (“China Shenhua Energy” хоёр том ил уурхайнхаа үйл ажиллагааг зогсоосон) буурч, нүүрсний үнэ оны сүүлийн хагаст өсөх төлөвтэй байлаа. Цаашид Хятадын эрчим хүчний нүүрсний импорт энэ ондоо тогтвортой хадгалагдах бол АНУ ба Евро бүсийн орнууд байгаль орчны бохирдлыг бууруулах зорилгоор нүүрсний хэрэглээг бууруулахаар байгаа ч газрын тосны өндөр үнэ нүүрсийг хямдаар орлуулах боломжийг хязгаарлаж байгаа тул 2018 оны хувьд үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдахаар байна. Түүнчлэн Хятадын Засгийн газраас хэрэгжүүлж буй нүүрсний үнэ тогтворжуулах бодлогын хүрээнд эрчим хүчний нүүрс олборлогч голлох Шаньси, Өвөр Монгол болон Шаанси мужын үйлдвэрлэлийг 250 сая тонноор нэмэгдүүлж болзошгүй гэж Австралийн Нөөц, Эрчим хүчний байгууллагын тайланд дурджээ. Энэ нь Монгол Улсын нүүрсний экспортод таагүй нөлөөтэй байх магадлалтай. Хятадын Засгийн газраас ирэх 5 жилд нүүрсийг байгалийн хийгээр орлуулах, нар, салхины эрчим хүчийг түлхүү ашиглахыг зорьж байгаа тул дунд, урт хугацаанд нүүрсний үнэ буурахаар байна.

Төмрийн хүдрийн үнэ буурах хандлагатай байна. 2018 оны эхнээс буурч \$63/тн хүрсэн төмрийн хүдрийн үнэ 8-р сард \$65-т хүрсэн нь Хятадын аж үйлдвэрийн PMI индекс 2018 оны 8 дугаар сард 51.3 болж нэмэгдсэн, Хятадын гангийн үйлдвэрлэл тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна. Цаашид хөрөнгийн зах зээлийн уналт

¹³ Хөдөлмөрийн гэрээ байгуулах хэлэлцээр эцэслэгдээгүй – ажилчдын үйлдвэрийн эвлэлийн гишүүдийн 84 хувь “ВНР” компаниас хүргүүлсэн сүүлийн цалингийн саналаас татгалзсан

удаан үргэлжлэхгүй бөгөөд төмрийн хүдрийн гол экспортлогч орнууд болох Австрали, Бразилын нийлүүлэлт нэмэгдэхээр байгаагаас ОУВС, Дэлхийн банк, Австралийн Нөөц, Эрчим хүчний байгууллага болон Блүүмбергийн шинжээчид нэг тонн төмрийн хүдрийн дундаж үнийн төсөөллийг 2019 онд 62\$/тн болгож бууруулав.

Зураг 22. Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

4.2. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл


Эдийн засгийн төсөөллийг хийхдээ ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т тусгагдсан мөнгөний болон төсвийн бодлогын арга хэмжээнүүд хэрэгжиж, уул уурхайн бүтээн байгуулалт үргэлжилнэ, төрийн болон хувийн секторын ажилчдын цалин нэмэгдэнэ гэсэн таамаглалт нөхцөлүүдийг ашигласан.

Суурь төсөөллөөр эдийн засгийн идэвхжил цаашид нэмэгдэхээр байна. Зэсийн баяжмал дахь алтны агууламж эргэн сэргэж, нүүрсний зах зээл тогтвортой байгаа нь уул уурхайн салбарын өсөлтийг нэмэгдүүлэх бол 2019 онд түүхий эдийн үнэ буурахаар хүлээгдэж байгаа нь уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хумих нөлөө үзүүлнэ. Харин 2020 онд зарим түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнэ эргэн нэмэгдсэнээр уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэхээр байна.

Хөрөнгийн дотогшлох урсгал сайжрах, бизнес эрхлэгчдийн итгэл сэргэх зэрэг хүчин зүйлсийн голлох нөлөөгөөр уул уурхайн бус салбарын өсөлт харьцангуй тогтвортой хадгалагдахаар байна. 2018 оны сүүлийн хагаст эдийн засгийн өсөлтийг боловсруулах, худалдаа, бусад үйлчилгээ, барилга,

уул уурхай, тээврийн салбар үргэлжлэн тэтгэхээр байна. Харин энэ онд мал төллөлт олон жилийн дунджаас бага хувьтай, том малын зүй бус хорогдол харьцангуй өндөр байгаа нь хөдөө аж ахуйн салбарын өсөлт саарахад хүргэж байна. Мөн нүүрсний экспортын хэмжээ өмнөх оны өндөр түвшинг давахааргүй байгаа нь авто замын ачаа эргэлтийг бууруулж тээврийн салбарын өсөлтийг сааруулах бол банкуудын ашигт ажиллагаа төдийлөн нэмэгдэхгүй улмаар санхүү, даатгалын зуучлалын үйл ажиллагаа идэвхжихээргүй байна. Харин 2019 онд цаг агаарын нөхцөл хэвийн, Активын чанарын үнэлгээний хүрээнд хийгдэх ажлууд жигдэрснээр бизнесийн зориулалттай олгох зээл болон банкны ашигт ажиллагаа нэмэгдэж, хөрөнгө оруулалтын хэмжээ хэвийн түвшиндээ хүрч өснө гэж үзсэнээр уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл 2018 онтой харьцуулахад бага зэрэг нэмэгдэнэ. Төсвийн хумих бодлого цаашид үргэлжлэх, уул уурхайн томоохон бүтээн байгуулалтын эдийн засагт үзүүлэх нөлөө саарах, 2019 онд нэмэгдэхээр хүлээгдэж буй цалингийн өсөлтөөс үүдэн үйлдвэрлэлийн өртөг нэмэгдэх зэрэг нөлөөгөөр 2020 онд уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл хумигдах төлөвтэй байна.

Зураг 23. Улирлын ДНБ-ий жилийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

Хүснэгт 3. ДНБ болон инфляцийн төсөөлөл


Он	ДНБ-ий өсөлт %			Инфляци %		
	Нийт	Уул уурхайн	Уул уурхайн бус	Нийт	Хүнсний	Хүнсний бус
2018	5.0 - 7.5	0.5 - 3.5	5.0 - 9.0	6.5 - 8.0	5.5 - 7.0	6.5 - 8.5
2019	5.0 - 8.5	0.0 - 4.0	6.0 - 10.0	7.0 - 9.5	3.5 - 6.0	8.5 - 11.0

Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

ШИГТГЭЭ 3. ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГ

Эдийн засгийн мөчлөгийг тодорхойлох нь бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчдэд цаашдын бодлого, үйл ажиллагаагаа төлөвлөхөд чухал мэдээллийг өгдөг. Ерөнхийд нь эдийн засгийн нийт үйлдвэрлэлд гарч буй өсөлт, бууралтын хандлагыг эдийн засгийн мөчлөг гэж үзэн түүнийг тодорхойлдог.

Зураг 24. Эдийн засгийн мөчлөг



Макро эдийн засгийн мөчлөг нь эдийн засгийн ерөнхий төлөвийг илтгэх тул бодлогын шийдвэр гаргалтад чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, эдийн засаг уналтын үед компаниуд үйл ажиллагааныхаа цар хүрээг хумих арга хэмжээ авдаг бол эдийн засаг өсөлтийн үед бизнесээ тэлж, зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэхийг хичээдэг байна. Эдийн засгийн өрнөлийн үед хэрэглээ, хөрөнгө оруулалт тэлэх тул эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт нэмэгддэг. Энэ шалтгаанаар инфляци өсч түүний зорилтот түвшнээс харьцангуй удаан хугацаа давахаар нөхцөл байдалд төв банк мөнгөний бодлогыг хатууруулж, инфляцийг зорилтот түвшин рүү бууруулах арга хэмжээг авдаг. Ийнхүү төв банк инфляцийг хяналтандаа авахгүй тохиолдолд эдийн засгийн өргөжилтийн үед бий болсон баялаг нь үнийн өсөлтөд идэгдэх, эдийн засгийн дараагийн тогтворгүй байдалд хүргэх эрсдэлтэй байдаг.

Түүнчлэн байгалийн баялаг ихтэй орнуудын өмнө тулгардаг том сорилт нь мөчлөг сөрсөн бодлогыг хэрэгжүүлэх явдал байдаг. Мөчлөг сөрсөн бодлогод түүхий эдийн үнэ өсөлттэй үед баялгийн санд орох хуримтлалыг нэмэгдүүлэх, үнэ буурсан үед тухайн санг эх үүсвэр болгон ашиглах зэрэг макро бодлогын арга хэрэгслүүдийг ашиглан эдийн засгийг тогтвортой байдлыг хангана. Эдгээр бодлогын шийдвэр гаргалт бодитой, үр ашигтай байхын тулд эдийн засгийн мөчлөгийг үнэн зөв тооцох, түүний цаашдын төлөвийн төсөөллийг бодитойгоор гаргах нь нэн чухал юм. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын эдийн засгийн мөчлөгийг Үндэсний эдийн засгийн судалгааны хороо (NBER) нь графикт суурилсан аргачлал болох BBQ алгоритмаар тооцдог.

Даваажаргал, Хүслэн (2018) нар дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий тоо мэдээг ашиглан Монгол улсын эдийн засгийн мөчлөгийг “BBQ” алгоритмаар тодорхойлсон. Үр дүнг Зураг 25 болон Зураг 26-т харуулав.


Зураг 25. Монголын ДНБ, эдийн засгийн уналтын үеүд



Эх сурвалж: Даваажаргал, Хүслэн (2018) нарын тооцоо

Зураг 25 болон Зураг 26 дээр сүүдэрлэсэн хэсэг нь эдийн засгийн уналтыг үеүдийг илэрхийлнэ. Харин сүүдэрлээгүй хэсэг нь эдийн засгийн өргөжилтийн үеүдийг харуулна. Энэхүү мөчлөгийн тооцоог эдийн засагт тохиолдсон гадаад шокуудтай хэр уялдаатай байгааг харьцуулахад дараах үр дүн гарч байна: 2001Q4-өөс 2003Q1-ийн хооронд зэсийн үнийн уналт, 2004Q2-оос 2005Q1-ийн хооронд газрын тосны үнийн өсөлт, 2008Q4-өөс 2010Q1-ийн хооронд дэлхийн эдийн засгийн хямрал, 2011Q3-аас 2012Q1-ын хооронд уул уурхайн экспорт болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт, 2015-2016 онд нүүрсний үнийн уналт зэрэг нь манай эдийн засгийн уналтын үеүдтэй давхцаж байжээ.

Зураг 26. Монголын эдийн засгийн мөчлөг




Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

4.3. Инфляцийн төсөөлөл

Төсөөллийн хугацаанд инфляци харьцангуй тогтвортой байж, зорилтот түвшний орчимд хадгалагдах төлөвтэй байна. Суурь төсөөллөөр малын зүй бус хорогдол өндөр байсан, хаваржилт сайнгүй, зуншлага оройтсноос үүдэн махны үнэ 2018 онд өмнөх оноос өсч, хүнсний инфляцийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлэх бол 2019 онд цаг агаар хэвийн байж, махны нийлүүлэлт хэвийн түвшинд очиж, хүнсний ногооны үнэ тогтворжино гэж таамагласнаар хүнсний инфляци 2018 оноос буурахаар төсөөлж байна. Харин 2020 оны хувьд дэлхийн зах зээл дээрх үр тарианы нийлүүлэлт буурч улмаар хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх¹⁴, мөн цалин нэмэгдэх нөлөөгөөр хүнсний инфляци буцаад өсөх төлөвтэй байна.

Эрэлтийн шинжтэйгээр инфляци бага зэрэг нэмэгдэх боловч нэг удаагийн шинжтэй хүчин зүйлс (хэрэглээний сагсны өөрчлөлт, суудлын автомашины татвар, хатуу түлшний үнийн огцом өсөлт) саарч 2018 онд хүнсний бус инфляци 2017 онтой харьцуулахад буурахаар байна. Харин уул уурхайн бус салбарын идэвхжил, цалин нэмэгдэх нөлөөгөөр 2019 онд хүнсний бус жилийн инфляци өсөх бол 2020 онд буурах төсөөлөлтэй байна.

Зураг 27. Жилийн инфляцийн төсөөлөл



Эх сурвалж: Монголбанкны тооцоолол

4.4. Төсөөллийн тодорхой бус байдал

Эдийн засгийн бодлого өөрчлөгдөх, бүтцийн шинжтэй өөрчлөлт бий болох, таамаглалд ашигласан нөхцөлүүд өөрчлөгдөх болон урьдчилан

¹⁴ Евро бүс болон Оросын ургац хураалт сүүлийн 3 жилийн хамгийн бага түвшиндээ хүрсэн бөгөөд цаашид энэ хандлага үргэлжлэхээр байна - "Reuters" агентлаг.

харах боломжгүй гадаад, дотоод хүчин зүйлсийн гэнэтийн өөрчлөлт зэргээс шалтгаалж төсөөлөл бодит гүйцэтгэлээс зөрөх эсвэл дараагийн төсөөлөлд өөрчлөлт орох боломжтой. Макро эдийн засгийн бодлого, дотоод, гадаад эдийн засгийн орчинд нөлөөлж болзошгүй дараах тодорхой бус байдлууд байна.

Эдийн засгийн дотоод орчны тодорхой бус байдал

- Бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн болзошгүй доголдол эсвэл илүүдэл нь инфляцийн төсөөллийг өөрчлөх эрсдэлтэй. Тухайлбал, цаг агаарын нөхцөл, зуншлагын байдлаас шалтгаалан мах, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний нийлүүлэлт, улмаар үнэ өсөх, урьдчилан зарлаагүй төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний үнэ (нефтийн үнэ) нэмэгдэх зэрэг нь төсөөллийг өөрчлөх эрсдэлтэй.
- Улсын секторын цалингийн өсөлтийг даган хувийн секторын цалин нэмэгдэх, зардал өсөх, улмаар ашигт ажиллагаа буурах хувь, хэмжээ ААНБ-үүдийн хариу үйлдлээс хамаарах бөгөөд энэ хандлага тодорхой бус байна. Сүүлийн жилүүдэд өрхийн өрийн дарамт нэмэгдэж байгаагаас цалингийн өсөлтийн орлогын нөлөө харьцангуй бага байх боломжтой юм. Харин орлогын нөлөө бага байх тохиолдолд цалингийн инфляцид үзүүлэх нөлөөлөл түүхэн хандлагаасаа өөр байна.
- Уул уурхайн зарим томоохон төсөл хэзээ эхлэх, хэрхэн санхүүжих, мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх эсэх нь тодорхой бус хэвээр байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөөлөлд тусгагдаагүй төсөл хөтөлбөрүүд хэрэгжих, төсвийн зардал төлөвлөгөөнөөс нэмэгдэх тохиолдолд эдийн засгийн суурь төсөөлөл өөрчлөгдөнө.
- Экспортын бүтээгдэхүүний хилийн боомтуудаар хязгаарлалтгүй дамжин өнгөрөх чадвар хангагдаж, цаашид бүрэн хүчин чадлаар тээвэрлэлт хийгдэх боломж бүрдсэн тохиолдолд нүүрсний олборлолт, экспортын төлөв улам сайжрах боломжтой юм.
- Хөдөө аж ахуйн салбарын хувьд цаг агаарын нөхцөл байдлаас үлэмж хамаарч үйлдвэрлэл нь өөрчлөгдөхөөс гадна бэлчээрийн даацыг харгалзан үзэж, малын тоо, толгойг нэмэгдүүлэхээс илүүтэй ашиг шимийг сайжруулахад чиглэсэн төрийн бодлогын нөлөө ирэх жилүүдэд ажиглагдаж болохуйц байна.
- Банкны систем дэх зээлийн долларжилт нэмэгдэх, цаашид санхүүгийн системд эрсдэл хуримтлагдах, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.
- Аливаа урьдчилж мэдэгдээгүй эдийн засгийн бодлогын өөрчлөлт нь

төсөөллийн тодорхой бус байдлыг бий болгоно.

Эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал

- АНУ, БНХАУ хоорондын худалдааны зөрчилдөөн Хятадын эдийн засгийн цаашдын төлөвт тодорхой бус байдлыг нэмэгдүүлж буй нь Монгол улсын төдийгүй дэлхийн эдийн засгийн төлөвт эрсдэл үүсгэсэн хэвээр байна. Тухайлбал, худалдааны зөрчилдөөнөөс хамааралтай бодлогын гэнэтийн шийдвэрээс шалтгаалж экспортын гол бүтээгдэхүүний эрэлт болон үнэ өөрчлөгдөх зэрэг нь манай эдийн засгийн өсөлтийн төлөвт шууд нөлөө үзүүлнэ.
- Хятадын засгийн газраас өрийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дунд хугацаанд баримтлах санхүүгийн зохицуулалтыг сайжруулах, чангатгах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх төлөвтэй боловч 2018-19 онд худалдааны зөрчилдөөний нөлөөгөөр дотоод эдийн засгийг дэмжих зорилгоор төсвийн болон мөнгөний бодлогыг аажмаар сулруулж болзошгүй байна.
- Хятадын Засгийн газраас дотоод эрэлтэд суурилсан тэнцвэртэй өсөлт бий болгох зорилгоор агаарын бохирдол, ажилгүйдлийг бууруулах, зээлийн өсөлтийг хязгаарлах арга хэмжээ авч хэрэгжүүлэх төлөвтэй байна. Үүний нөлөөгөөр Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбар удааширч улмаар гангийн үйлдвэрлэл хумигдах, нүүрс, төмрийн хүдрийн эрэлт буурах эрсдэлтэй байна.
- ОХУ-ын мөнгөний бодлогын төлөв хэвээрээ үргэлжлэх эсэх, төсвийн чанга бодлогын хүрээнд төсвийн зардлыг танасан ч төсвийн алдагдал буураагүй байна. 2019 оноос хэрэгжиж эхлэх татварын шинэчлэлтүүд нь төсөөллийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна.
- Дэлхийн зах зээл дээрх нефтийн үнэ, түүнийг даган дотоодын зах зээл дээрх бензиний үнэ хэрхэн өөрчлөгдөх нь төсөөллийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна.
- Хөгжиж буй орнуудын эдийн засгийн төлөвт АНУ-ын гадаад бодлогын хүлээлт, Холбооны Нөөцийн банк мөнгөний бодлогоо аажмаар чангаруулах төлөв нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сааруулж, Хөгжиж буй орнуудаас хөрөнгө гадагшлах эрсдэл үүсгээд байна.


Улс орнууд хоорондын геополитикийн асуудлууд, хориг арга хэмжээнүүд нь манай эдийн засгийн гадаад орчинд нөлөөлж болзошгүй байна. Том гүрнүүд хоорондын худалдааны маргаан, түүнээс улбаалсан олон улсын санхүүгийн гүйлгээ, төлбөр тооцооны системд гарч болох эрсдэлүүд нь манай эдийн засгийн хувьд томоохон тодорхой бус байдлыг бий болгож байна.

V. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


5.1. Мөнгөний нийлүүлэлт, зээл

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт алгуур нэмэгдэж, 2018 оны 7 дугаар сарын байдлаар 22.9 хувьд хүрсэн. Түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнэ өсч, экспортын орлого нэмэгдсэн, уул уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт, ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд донор байгууллагуудаас орж ирсэн гадаад санхүүжилтийн эх үүсвэр зэргээс үүдэн мөнгөний нийлүүлэлтийн өсөлт эрчимжсэн. Төсвийн алдагдал болон Засгийн газрын дотоод бондын үндсэн төлбөрт гадаад санхүүжилтийн эх үүсвэрийг зарцуулснаар Засгийн газрын банкны системээс авсан цэвэр зээлийн дүн буурч, банкны систем дэх зээлийн эх үүсвэр нэмэгдсэнээр зээл олголт өсч байна. Гэхдээ иргэдэд олгож байгаа хэрэглээний зориулалттай зээл бизнесийн зориулалттай зээлээс хурдацтай өссөн хэвээр байна.

Зураг 28. M2 мөнгөний жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр /актив/



Зураг 29. M2 мөнгөний жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр /пассив/




Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг эх үүсвэр талаас дүгнэвэл хадгаламжийн долларжилт үргэлжлэн буурч байна. Энэ нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзэл буурч, төгрөгт итгэх итгэл сайжирсантай холбоотой юм. Мөнгөний нийлүүлэлт 22.9 хувиар өссөнөөс 18.7 нэгж хувийг төгрөгийн харилцах, хадгаламжийн өсөлт бүрдүүлж байна. Долларжилт буурснаар санхүүгийн системийн эрсдэл даах чадвар сайжирч, үр ашиг нь нэмэгдэн санхүүгийн системийн тогтвортой байдлыг дэмжинэ.

Сүүлийн 6 улирлын турш хэрэглээний зээл нийт зээлийн өсөлтийг тэтгэж байна. Зээл 2018 оны 7 дугаар сарын байдлаар 17.7 хувиар нэмэгдсэний 11

нэгж хувийг хэрэглээний зээл дангаараа бүрдүүлээ. Хэрэглээний зээлийн өсөлт цаашид хурдацтай нэмэгдсээр байвал өрхийн өрийн дарамт нэмэгдэж, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдах эрсдэлтэй. Харин эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, зах зээлийн идэвхжилийг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй бизнесийн зээлийн өсөлт сүүлийн жилүүдэд бага түвшинд байна. Сүүлийн саруудад бизнесийн зээлийн өсөлт аажмаар нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа ч энэ нь худалдаа, уул уурхай, боловсруулах салбарт гадаад валютаар олгосон зээлийн өсөлтөөр тайлбарлагдаж байна.

Зураг 30. Зээлийн жилийн өсөлт, салбаруудын бүрэлдэхүүнээр



Зураг 31. Бизнесийн, хэрэглээний зээлийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

ШИГТГЭЭ 4. ДОЛЛАРЖИЛТЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Мөнгөний үндсэн гурван үүрэг болох өртөг хэмжих, төлбөрийн хэрэгсэл, баялаг хуримтлуулах зорилгоор үндэсний мөнгөн тэмдэгтийн оронд гадаад валютыг өргөн ашиглах үзэгдлийг долларжилт гэдэг¹. Банкны системийн нийт актив болон пассивт эзлэх гадаад валютын актив болон пассивын хэмжээ нэмэгдэх нь санхүүгийн долларжилт нэмэгдэж буйг илэрхийлэх нэг үзүүлэлт болдог. Олон улсын туршлагаас харахад гадаад дотоод хүүний зөрүү, гадны хөрөнгө оруулагчдын эрсдэлийн хүлээлт, богино хугацаатай өгөөж хайсан хөрөнгийн урсгал, эдийн засгийн нээлттэй байдал, өсөлтийн хурд, ханш, инфляцийн хэлбэлзэл зэрэг нь санхүүгийн долларжилтод нөлөөлдөг байна².

Монгол улсын хувьд гадаад орчин таатай үед банк, санхүүгийн байгууллагууд гадаад зах зээлээс эх үүсвэр босгосноор пассивын долларжилт нэмэгддэг. Банкны системийн хувьд долларжилт нэмэгдэх нь макро эдийн засаг, банк санхүүгийн салбарт дараах сөрөг үр дагаврыг дагуулдаг. Үүнд:

Санхүүгийн хямралд хүргэх: Гадаад зах зээлээс эх үүсвэр босгосон банк гадаад валютаар зээл олгож, зээлийн долларжилтыг нэмэгдүүлдэг. Ингэснээр тухайн банкны хувьд ханшийн эрсдэлийг бууруулах боловч зээлийн эрсдэл нэмэгдэх нөхцөл бүрддэг. Гадаад сөрөг шокийн нөлөөгөөр дотоод валютын ханш сулрахад валютын зээлийн төгрөгөөр илэрхийлэгдэх дүн өсч, гадаад валютын орлогогүй, ханшийн эрсдэлийг удирдах чадамж муутай зээлдэгчид зээлээ төлж чадахгүй болж, зээл чанаргүйдэх эрсдэл хуримтлагддаг³.

Эдийн засгийн агших үеийн сөрөг нөлөө нэмэгдэх: Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах үед долларжилт өндөртэй эдийн засгийн хувьд дотоодын хөрөнгө оруулалт илүү ихээр буурдаг. Валютын ханш сулрахад иргэд, ААН-ийн гадаад валютын зээл чанаргүйдэх, банк ханшийн алдагдалд орж, өөрийн хөрөнгийн хүрэлцээ муудна. Энэ нь банкны зээл олгох чадварыг доройтуулж, дотоод хөрөнгө оруулалтыг улам ихээр бууруулдаг. Харин долларжилт бага тохиолдолд ханш сулрахад санхүүгийн салбарт агшилт бага байх тул мөчлөгийн сөрөг нөлөө бага байдаг⁴.

Макро эдийн засгийн эмзэг байдал нэмэгдэх: Хадгаламж, харилцахын долларжилт өндөр байх нь валютын ханш богино хугацаанд хүчтэй хэлбэлзэх нөхцөл болдог. Үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэл буурах, ханш сулрах хүлээлт үүссэн үед иргэд, ААН-үүд инфляци, ханшийн хэлбэлзлээс хөрөнгөө хамгаалах зорилгоор хадгаламжаа гадаад валют руу хөрвүүлж, дотоод валютын ханшийн сулрах дарамтыг эрчимжүүлж, мөнгөний эрэлтийн хэлбэлзлийг нэмэгдүүлдэг. Түүнчлэн импортын орц өндөртэй эдийн засгийн хувьд ААН-үүд үнээ өөрчлөхдөө ханшийн хүлээлтийг тусгадаг тул санхүүгийн долларжилт өндөр эдийн засагт валютын ханшийн инфляцид үзүүлэх нөлөө өндөр, инфляци ихээр хэлбэлздэг. Банкны хадгаламж, ханш, инфляци, мөнгөний эрэлтийн хэлбэлзэл нэмэгдэхэд эдийн засагт тодорхой бус байдал үүсч, макро эдийн засгийн эмзэг байдал нэмэгддэг⁵.

Мөнгөний бодлогын нөлөөг сулруулах: Мөнгөний эрэлтийн хэлбэлзэл, ханшийн инфляцид үзүүлэх нөлөө нэмэгдсэнээр мөнгөний бодлогын инфляци, эдийн засагт үзүүлэх нөлөө суларч, Төв банкны эдийн засагт нөлөөлөх чадвар хязгаарлагддаг.

¹ Д.Энхзаяа. (2011). Монголын эдийн засаг дахь долларжилт. In Монголбанк, Судалгааны Төвхимол 6 (pp. 203-234). Улаанбаатар: Монголбанк.

² Basso, H. S., Calvo-Gonzalez, O., & Jurgilas, M. (2007, May). *Financial Dollarization - The Role of Banks and Interest Rates*. EDB Working Paper Series.

³ Luca, A., & Petrova, I. (2008). *What Drives Credit Dollarization in Transition Economies?* *Journal of Banking and Finance*, 858-869.

⁴ Yeyati, E. L., & Rey, H. (2006). *Financial Dollarization: Evaluating the consequences*. *Economic Policy*, 61-118.

⁵ De Nicolo, G., Honohan, P., & Ize, A. (2003). *Dollarization of the Banking System: Good or Bad?* IMF.

Төсвийн тогтвортой байдлыг бууруулах: Засгийн газар гадаад зах зээлд бонд гаргах, зээл авах зэргээр гадаад өрийг нэмэгдүүлэх нь санхүүгийн долларжилтын нэг хэлбэр юм. Төсвийн орлого голчлон дотоод валютаар бүрддэг тул валютын ханш сулрах үед гадаад өрийн дарамт, төсвийн алдагдал нэмэгдэж, өрийн тогтвортой байдал буурах эрсдэлтэй.

Зураг 32. Монгол Улсын санхүүгийн долларжилт



Эх сурвалж: Монголбанк

Манай улсын хувьд хадгаламжийн долларжилт 2004 онд хамгийн өндөр буюу 42 хувьд хүрснээс хойш алгуур буурч 2018 оны 6 дугаар сард 21.4 хувьд хүрсэн. Зээлийн долларжилт 2005 онд 47.2 хувьд, 2009 оны IV улиралд сүүлийн 10 жилийн дээд түвшин буюу 37 хувьд хүрсэн. 2018 оны I улирлын байдлаар нийт зээлийн 21.8 хувийг гадаад валютын зээл бүрдүүлж байна. Долларжилт буурч байгаа боловч банкуудын гадаад валютын зээлийн харилцах, хадгаламжид эзлэх хэмжээ 60 хувь байгаа нь ханш чангарах үед зээлийн долларжилт нэмэгдэж болзошгүй байна.

Бусад улс орны туршлагаас харахад долларжилтыг бууруулах зорилгоор доорх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Үүнд:

Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх

- Ханш болон инфляцийн хэлбэлзлийг бууруулах,
- Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх,
- Гадаад өрийн тогтвортой байдлыг хадгалах,
- Төсвийн сахилгыг нэмэгдүүлэх,

Долларжилтыг бууруулах сэдлийг урамшуулах


- Валютын ханшийн эрсдэлтэй зээлийн эрсдэлийн жинг ялгаатай тогтоох
- Ханшийн эрсдэлийг удирдах үүсмэл хэрэгслийн захыг хөгжүүлэх,
- Заавал байлгах нөөцийн хувийг гадаад пассивт өндрөөр тогтоох гэх мэт.

Монголбанк банкны пассивын долларжилтыг бууруулах, төгрөгөөр хөрөнгө татан төвлөрүүлэх сэдлийг урамшуулах зорилгоор 2018 оны 3-р сарын 23-ны өдөр банкны заавал байлгах нөөцийн хувь хэмжээг төгрөгийн хувьд 10.5 хувиар, гадаад валютын хувьд 12 хувиар тогтоосон.


5.2. Мөнгөний зах, хүүний түвшин

Монголбанк нь бодлогын хүүгээр дамжуулан богино хугацаат хүүгийн түвшинд нөлөөлж, улмаар инфляцийг тогтворжуулахыг зорьдог. Тиймээс Монголбанкны хувьд богино хугацаат хүүний түвшинг хянах, хэлбэлзлийг бууруулах бодлогын арга хэмжээг авч ажиллах нь чухал ач холбогдолтой юм.

Зураг 33. БХЗ-ын хүү



Зураг 34. БХЗ-ын арилжааны хэмжээ



Эх сурвалж: Монголбанк

Монголбанк нь богино хугацаатай хүүний хэлбэлзлийг бууруулах зорилгоор тэгш хэмт хүүний коридор системийг 2013 оноос нэвтрүүлж, хүүний коридорын өргөнийг тогтмол 4 нэгж хувиар тогтоож байв. Эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, төгрөгийн ханш огцом сулрах дарамт нэмэгдсэнтэй холбоотойгоор Монголбанк төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2016 оны 8 дугаар сараас +3/-1 нэгж бүхий хүүний тэгш бус хэмтэй коридор системд шилжсэн. Гэвч тоон үзүүлэлтүүдээс харахад дээрх хугацаанд банк хоорондын зах (БХЗ)-ын хүүний далайц болон бодлогын хүүнээс хазайх абсолют хазайлт нэмэгдсэн байв. Тодруулбал БХЗ-ын жигнэсэн дундаж хүүний далайц 2016 оны сүүлийн хагаст 2.3 нэгж хувь, 2017 оны эхний хагаст 3.3 нэгж хувь болж өмнөх онуудтай харьцуулахад дунджаар 0.8 нэгж хувиар нэмэгджээ.

Хүснэгт 4. БХЗ-ын хүүний бодлогын хүүнээс хазайх хазайлт, нэгж хувь

Хэлбэлзэл		
2016	1-7 сар	0.7
	8-12 сар	1.0
2017	1-5 сар	0.8
	6-12 сар	0.3
2018		0.2


БХЗ-ын хүүний хэлбэлзэл ийнхүү нэмэгдсэнээс шалтгаалан Монголбанк тэгш хэмт хүүний коридор системийг 2017 оны 6 дугаар сард буцаан нэвтрүүлэв. Зураг 33-аас харахад 2017 оны 6 дугаар сараас эхлэн БХЗ-ын хүүний хэлбэлзэл буурч, бодлогын хүүтэй ойролцоо тогтох болжээ. Тухайлбал, БХЗ-ын жигнэсэн дундаж хүү 2018 оны 7 дугаар сарын байдлаар 9.8 нэгж хувь буюу бодлогын хүү 10 нэгж хувьтай ойролцоо байна.

Тэгш хэмт хүүний коридор системийг буцаан нэвтрүүлснээр хүүний түвшний хэлбэлзэл буурснаас гадна БХЗ-ын идэвхжил нэмэгдсэн байна. БХЗ дээрх банкуудын хэлцлийн давтамж 2018 оны 7 дугаар сарын байдлаар 718 хүрсэн нь сүүлийн 3 жилд хамгийн өндөрт тооцогдох юм. Зураг 34-т үзүүлснээр 2017 оны 6 дугаар сараас өмнө буурах хандлагатай байсан банк хоорондын хэлцлийн хэмжээ тэгш хэмт хүүний коридор системийг буцаан нэвтрүүлснээр өсөх хандлагатай болжээ. Үүнтэй зэрэгцэн банкууд хоорондоо ТБҮЦ арилжаалах явдал нэмэгдсэн. БХЗ дээр хийгдсэн нийт арилжааны дүн 2017 онд 7.4 их наяд байсан бөгөөд үүний дунджаар 27 хувь нь ТБҮЦ-ны хэлцэл байсан бол 2018 оны эхний 7 сарын байдлаар нийт хэлцлийн дунджаар 48 хувийг ТБҮЦ-ны хэлцэл эзэлж байна. Монголбанк 2018 оны 4 дүгээр сард ТБҮЦ-ны хугацааг уртасгаж (7 хоногоос 28 хоног), давтамжийг бууруулсан нь (долоо хоногт 3 удаа байсныг 1 удаа) банк хоорондын зах дээрх ТБҮЦ-ны арилжаа нэмэгдэхэд эергээр нөлөөлсөн байна.

Хүснэгт 5. БХЗ-ын хэлбэлзэл 2016-2018 он

Хэлцлийн төрөл /Он	2016 он		2017 он		2018 он
	1/1 – 8/17	8/18-12/31	1/1-6/15	6/16-12/31	1-7 сар
Репо	77	116	77	39	153
ТБҮЦ	112	70	92	132	291
Овернайт	430	301	340	182	274
Нийт	619	487	509	353	718

Хадгаламж, зээлийн хүү: Төгрөгийн зээлийн хүү буурсантай холбоотой зээл болон хадгаламжийн хүүний зөрүү багасах хандлагатай байна (Зураг 35). Өнгөрсөн оны 7 дугаар сартай харьцуулахад уг зөрүү 1.6 нэгж хувиар буурчээ. Хөнгөлөлттэй зээлийг хасаж тооцсон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) сүүлийн 7 сард дунджаар 18.8 хувь, хадгаламжийн ЖДХ 12.6 хувь байна. Харин валютын зээлийн хувьд 10.6 хувь, хадгаламжийн хувьд 5.3 хувь байна.

Зураг 35. Хадгаламж, зээлийн хүү*Эх сурвалж: Монголбанк*

Бодлогын хүүний бууралтыг даган 2018 оны байдлаар зээлийн хүү сард дунджаар 0.17 нэгж хувиар, харин хадгаламжийн хүү 0.08 нэгж хувиар буурсан. Эдийн засгийн ерөнхий төлөв байдал сэргэсэн, зээлийн хүү буурсан зэрэг нь зээлийн хэмжээг нэмэгдүүлжээ.


5.3. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

2017 оны сүүлийн хагаст 77.3 төгрөгөөр суларсан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2018 оны эхний улирлын байдлаар тогтвортой байсан бол 2 дугаар улирлын эцсийн байдлаар оны эхнээс 35.69 төгрөгөөр сулав. Тодруулбал 2018 оны 1 дүгээр улиралд төгрөгийн ам.доллартай харьцах ханш өмнөх оны эцсээс 1.4 хувиар чангарсан бол 2 дугаар улиралд 2.9 хувиар суларч 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2463.25 төгрөгт хүрч, улирлын эхнээс 0.02 хувиар, оны эхнээс 1.5 хувиар тус тус суларсан байна. Төлбөрийн тэнцлийн бараа, үйлчилгээний худалдааны дансны алдагдал 2018 оны 5 дугаар сарын байдлаар оны эхнээс -42.3 сая ам.доллар болж буурсан, ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн санхүүжилтүүд орж ирж буйтай холбоотойгоор зах зээлд оролцогчдын хүлээлт эерэг болсон зэрэг нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамт буурах суурь нөхцөл болжээ.


Харин 2018 оны 2 дугаар улирлын эцэст гадаад зах зээл дээрх уул уурхайн экспортын гол түүхий эдийн үнийн уналт, хөрөнгө оруулалт, нефть ба хэрэглээний бүтээгдэхүүний импортын биет хэмжээ, үнийн өсөлт зэрэгтэй

холбоотойгоор 2018 оны 6 дугаар сард гадаад худалдааны импортын хэмжээ өмнөх сараас 13.9 хувиар өссөн, банкны системийн гадаад валютын цэвэр урсгалын ам.доллараар илэрхийлсэн дүн -112.3 сая ам.доллар болж буурсан зэрэг гадаад хүчин зүйлс болон улирлын шинж чанартай нөлөөллөөс шалтгаалан харьцангуй тогтвортой түвшинд байсан төгрөгийн ам.доллартай харьцах ханшид сулрах дарамт ирсэн.

Зураг 36. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш



Зураг 37. Ханшийн өдрийн хэлбэлзлийн хистограм



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн ханшийн өдрийн дундаж хэлбэлзэл 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.07 нэгж хувиар буурч 0.05 хувьтай байлаа. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш тайлант хугацаанд өдөрт хамгийн ихдээ 0.21 хувиар чангарч, 0.61 хувиар суларсан нь өмнөх оны мөн үеэс 0.15 болон 0.05 нэгж хувиар харгалзан бага байжээ. Өнгөрсөн оны мөн үед ханшийн өдрийн хэлбэлзэл нийт өдрийн 83.7 хувьд нь ± 0.2 хувийн интервалд байсан бол энэ оны 7 сарын 31-ний байдлаар нийт өдрийн 96.5 хувьд нь дээрх интервалд хэлбэлзжээ.

ШИГТГЭЭ 5. ГАДААД ВАЛЮТЫН ЗАХЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Монголбанк 2017 онд БНСУ-ын Төв банктai хамтарсан Мэдлэг түншлэлийн хөтөлбөрийн хүрээнд “Монгол Улсын гадаад валютын захыг хөгжүүлэх” төслөөр гадаад валютын захыг хөгжүүлсэн БНСУ-ын туршлагыг судалж, тус улсын сайн туршлагад үндэслэн манай оронд хэрэгжүүлж болох зөвлөмжийг энд товчлон танилцуулж байна. Үүнд:

1. Гадаад валютын брокерын системийг нэвтрүүлэх: Монголбанк 2017 онд валют арилжааны цахим талбарыг нэвтрүүлснээр валютын захын хөгжилд ахиц гарсан. Гэвч одоогийн байдлаар тус цахим талбар нь голчлон банк хоорондын, том дүнтэй арилжаа хийгддэг, өртөг өндөр тул оролцогчдын хамрах хүрээ хязгаарлагдмал, ханшийн хэлбэлзлийг бууруулах чадамж харьцангуй бага байна. Гадаад валютын брокерын системийг нэвтрүүлж, хөгжүүлснээр спот арилжаанд оролцогчдын хүрээ нэмэгдэж, нууцлалыг хамгаалах, өндөр хурдтай арилжааг гүйцэтгэх, өргөжилтийн үр өгөөж бий болгон валютын захын үр ашгийг нэмэгдүүлдэг болохыг БНСУ-ын туршлага харуулж байна.
2. Гадаад валютын арилжааны нэгдсэн мэдээллийн сан бий болгох: Өнөөдөр гадаад валютын захын мэдээлэл зөвхөн банкны арилжааны мэдээлэлд тулгуурладаг. Гэтэл валютын ханшид арилжаа хийдэг санхүүгийн бусад байгууллагын мэдээлэл чухал нөлөөтэй. Валют арилжааны мэдээлэл нэгдсэн байдлаар зах зээлд оролцогч нарт хүрч байвал төгрөгийн гадаад валютаар илэрхийлэгдэх үнэ илүү бодитой, эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэй байх боломж дээшилж, валютын захын үр ашиг нэмэгдэнэ. Нөгөөтэйгүүр, хөрөнгийн урсгалын мэдээлэл сайжирч, гэнэтийн хэлбэлзлээс үүсэх эрсдэл хуримтлагдаж байгаа эсэхийг хянах, цаг алдалгүй илрүүлж, арга хэмжээ авах боломжийг дээшлүүлэх давуу талтай. БНСУ 1999 онд хөрөнгийн чөлөөт урсгалын дэглэмд шилжсэний дараа БНСУ-ын Төв банк “Гадаад валют арилжааны мэдээллийн систем”-ийг нэвтрүүлсэн. Уг системд 1162 оролцогч байгууллага хамрагддаг бөгөөд гадаад валютын арилжаа, гадаад худалдаа, ГШХО, гадаад валютын позиц, гадаад валютын шилжүүлэг, гадаад валютын үүсмэл хэрэгслүүдийн гүйлгээ зэрэг 104 төрлийн мэдээллийг өдөр бүрийн давтамжтайгаар системд оруулж, төрийн байгууллагуудад хяналт, зохицуулалт, мэдээлэл түгээх чиглэлээр ашигладаг байна.

Урьдчилан дохиологч систем хөгжүүлэх: Системийн хэмжээний томоохон хямрал бий болохоос өмнө системд эрсдэл хуримтлагдаж байгаа эсэхийг илрүүлж, шаардлагатай арга хэмжээ авахад Урьдчилан дохиологч систем чухал үүрэгтэй. БНСУ-ын Засгийн газар 1997 оны хямралын дараа Урьдчилан дохиологч системийг санхүүгийн зах зээл, гадаад сектор, түүхий эдийн зах (үүн дотроо газрын тос), хөдөлмөрийн зах, үл хөдлөх хөрөнгийн зах гэсэн 6 чиглэлээр нэвтрүүлсэн. Уг системийн хүрээнд макро болон санхүүгийн захын тоон үзүүлэлтүүд, загварууд, чанарын өгөгдлүүдэд тулгуурлан ирэх 12 сарын хугацаанд хямрал болох магадлалыг тооцож, шинжилгээний үр дүнг шийдвэр гаргах түвшинд тогтмол танилцуулдаг байна.

VI. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗАХ ЗЭЭЛ


6.1. Төлбөрийн тэнцэл

Энэ оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн санхүүгийн дансны ашиг 61 хувиар өсч 877.3 сая ам.долларт хүрсэн боловч урсгал ба хөрөнгийн дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 2.0 дахин өсч 778.4 сая ам.долларт хүрснээр нийт төлбөрийн тэнцэл 198.5 сая ам.долларын алдагдалтай гарсан. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 149.7 сая ам.доллараар муудсан үзүүлэлт юм.

Зураг 38. Төлбөрийн тэнцэл



Зураг 39. Урсгал ба хөрөнгийн тэнцэл



Эх сурвалж: Монголбанк

Урсгал ба хөрөнгийн данс. Урсгал ба хөрөнгийн дансны алдагдал оны эхний 7 сард өмнөх оны мөн үеэс 390.6 сая ам.доллараар өсөхөд барааны дансны ашиг 35 хувиар буюу 321.7 сая ам.доллараар буурч, үйлчилгээний дансны алдагдал 20 хувиар буюу 127.1 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 40. Урсгал тэнцлийн ДНБ-нд эзлэх хувь




Эх сурвалж: Монголбанк


Манай орны урсгал тэнцлийн алдагдал 2010 оноос эхлэн дотоодын эдийн засаг сэргэлт болон уул уурхайн бүтээн байгуулалттай холбоотойгоор импорт огцом тэлж, 2012 онд ДНБ-ий 44 хувьд хүрч байсан. Харин барааны тэнцэл ашигтай гарч эхэлснээр урсгал тэнцлийн алдагдал буурч 2014 онд ДНБ-ий 16 хувь, 2015 онд 8 хувь, 2016 онд 6 хувь, 2017 онд 10 хувийг эзэлсэн бол 2018 оны эхний хагаст 11 хувьд хүрээд байна.

Гадаад худалдаа тэлж байна. Энэ оны эхний 7 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 26%-иар буюу 1,525 сая ам.доллараар өсч 7,832 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 17%-иар буюу 598 сая ам.доллараар, импорт 40%-иар буюу 929 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 333 сая ам.доллараар буурч 851 сая ам.долларын ашигтай байна.

Зураг 41. Барааны гадаад худалдаа



Зураг 42. Үйлчилгээний гадаад худалдаа



Эх сурвалж: Монголбанк

Энэ оны эхний 7 сард алт, газрын тосны экспортын биет хэмжээ буурсан, зэс, нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеийн түвшинд байсан. Харин дэлхийн зах дээрх түүхий эдийн үнэ сэргэж манай зэс болон нүүрсний хилийн үнэ өмнөх оны мөн үеэс 33 хувь, 16.4 хувиар тус тус өссөнөөр зэсийн экспортын орлого 287 сая ам.доллараар, нүүрсний экспортын орлого 207 сая ам.доллараар нэмэгдсэн нь экспортын өсөлтийн дийлэнх хувийг эзэлж байна. Харин Оюу толгойн далд уурхай болон нүүрсний угаах үйлдвэрүүдийн бүтээн байгуулалт, нүүрсний тээвэр нэмэгдэж байгаатай холбоотой хөрөнгө оруулалтын шинж чанартай барааны импорт эрчимтэй өсөв. Тухайлбал, энэ оны эхний 7 сард машин тоног төхөөрөмж, эд ангийн импорт 259 сая ам.доллараар буюу 46 хувиар, барилгын материалын импорт 156 сая ам.доллараар буюу 71 хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 158 сая ам.доллараар буюу 35 хувиар нэмэгдсэн. Түүнчлэн, эдийн засаг идэвхжиж, дотоод эрэлт нэмэгдсэнээр хэрэглээний бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 27 хувиар, 2017 онд ургац алдсантай холбоотойгоор улаан буудайн импорт өмнөх оноос 229 тонноор буюу 43.8 сая ам.доллараар өсчээ.


Үйлчилгээний дансны алдагдал өсөв. Үйлчилгээний дансны алдагдал 2018 оны эхний 7 сард өмнөх оны мөн үеэс 127.5 сая ам.доллараар өсчээ. Үүнд экспорт, импортын тээврийн үйлчилгээний зардлын өсөлт болон бизнесийн үйлчилгээний дансны алдагдал голчлон нөлөөлөв. Харин барилгын ажил

үйлчилгээний алдагдал бага зэрэг буурчээ.


Орлогын дансны алдагдал бага хэмжээгээр буурав. Орлогын дансны алдагдлын хэмжээ 2018 оны эхний 7 сард 670.2 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар буюу 51.2 сая ам.доллараар буурсан. Орлогын дансны алдагдал буурахад хувийн шилжүүлэг буюу эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондын урсгал шилжүүлэг 39.7 сая ам.доллараар өсч, гадаад зээлийн хүүгийн төлбөр 21.2 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөллөө.

Санхүүгийн дансны ашиг өслөө. Санхүүгийн дансны ашиг 2018 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 61 хувиар өсч, 877.3 сая ам.долларт хүрэв. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 51 хувиар буюу 353.7 сая ам.доллараар, гадаад зээл 141 хувиар буюу 442.0 сая ам.доллараар, худалдааны зээл 215 хувиар буюу 167.7 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн. Тодруулбал, томоохон уул уурхайн компанийн бүтээн байгуулалтын хүрээнд 2018 оны эхний 7 сарын байдлаар манай улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 64.1 хувиар буюу 250 сая ам.доллараар өсөв. Мөн Өргөтгөсөн санхүүжилтийн хүрээнд 2018 оны 5 дугаар сард АХБ-наас Монгол улсын Засгийн газарт олгогдсон 100 сая ам.долларын гадаад зээл бусад хөрөнгө оруулалтын дансны ашгийн хэмжээ нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Зураг 43. Санхүүгийн данс



Зураг 44. Гадаад валютын нөөц



Эх сурвалж: Монголбанк

Гадаад валютын албан нөөц. 2018 оны эхний 7 сард төлбөрийн нийт тэнцэл алдагдалтай гарснаар гадаад валютын албан нөөц буурч 7 дугаар сарын эцэст ГВАН 2953.0 сая ам.долларт хүрсэн. Хэдийгээр ГВАН өндөр түвшинд байгаа боловч хурдтай тэлж буй импортын төлбөрүүд нэмэгдсэнээр ГВАН сүүлийн гурван сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 5.7 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрээд байна.

ШИГТГЭЭ 6. МОНГОЛБАНКНЫ ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО


Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг баримталж, ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцсон.

2013 оноос гадаад зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурч, манай улсын экспорт болон гадаадын шууд хөрөнгө оруулалт орох урсгал эрс буурсан, төв банкнаас төсвийн шинж чанартай үйл ажиллагааг санхүүжүүлсэн, төсвийн хэт тэлэлт явагдсан зэргээс үүдэн төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн сулрах дарамт нэмэгдсэн. Монголбанкнаас ханшийн сулрах дарамтыг бууруулах зорилгоор гадаад валютын дотоодын захад 2014 онд 2.5 тэрбум, 2015 онд 1.1 тэрбум, 2016 онд 1.7 тэрбум ам.долларыг тус тус нийлүүлсэн.

Харин 2016 оны сүүлээс экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ өсч, засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан бондуудыг дахин санхүүжүүлж, ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн зэрэгтэй холбоотойгоор валютын орох урсгал сайжирсны дээр Монголбанк ГВУН-ийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч эхэлсэн.

Үүний хүрээнд 2017 онд 1.0 тэрбум, 2018 оны эхний хагас жилийн байдлаар 0.1 тэрбум ам.долларыг дотоодын валютын захаас худалдан авч, уг дүнгээр гадаад валютын цэвэр нөөцийг нэмэгдүүллээ.

Зураг 45. Монголбанкнаас гадаад валютын дотоодын захад нийлүүлсэн цэвэр интервенц



Монголбанк нь холбогдох хууль, журмын дагуу дараах хэлбэрээр гадаад валютын дотоодын захад оролцдог. Үүнд:

Гадаад валютын дуудлага худалдаа

Монголбанкнаас гадаад валютын дуудлага худалдааг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагт тогтмол зохион байгуулж дуудлага худалдаанд зөвхөн банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй банкууд оролцдог.

Дуудлага худалдааны бус интервенц

Төв банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд “Монголбанк нь Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэнэ”, Валютын зохицуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1-д “Монголбанк нь Монгол Улсын валютын гадаад нөөцийг нэмэгдүүлэх, зохицуулах зорилгоор тус улсын болон гадаад орны банк, бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс валют, цэвэршүүлсэн алт худалдан авч болно” гэж тус тус заасны дагуу дуудлага худалдааны бус аргаар Сангийн яам болон бусад аж ахуйн, нэгж байгууллагаас валют худалдан авах үйл ажиллагааг хэрэгжүүлж, Сангийн яамны санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. Дуудлага худалдааны бус интервенцийг дэлгэрэнгүйгээр харуулбал:

1. Валютын захад нийлүүлсэн:

- Шатахууны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд 2014 онд 903.5 сая, 2015 онд 235.9 сая ам.долларыг форвард хэлцлээр нийлүүлсэн.
- Дуудлага худалдааны бус оролцоогоор 2014 онд 295.0 сая, 2015 онд 212.5 сая, 2016 онд 126.4 сая ам.долларыг тус тус нийлүүлсэн.
- Харин 2016 онд МУЗГ-ын гадаад зах зээл дээр арилжаалсан 500 сая ам.долларын Мазаалай бондын эх үүсвэрээс 476.2 сая ам.долларыг Монголбанкны ээлжит болон ээлжит бус дуудлага худалдаагаар банкуудад нийлүүлсэн.

2. Валютын захаас татсан:

- Монголбанк Сангийн яамнаас 2014 онд 370.0 сая, 2015 онд 264.9 сая, 2016 онд 132.6 сая, 2017 онд 760.1 сая, 2018 онд 100.0 сая ам.долларыг тус тус худалдан авсан.
- ГВУН-ийг нэмэгдүүлэх зорилгоор томоохон уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогч байгууллагуудаас 2016 онд 21.8 сая, 2017 онд 238.4 сая, 2018 оны хагас жилийн байдлаар 127.8 сая ам.долларыг тус тус худалдан авсан.

Хүснэгт 6. Монголбанкнаас гадаад валютын дотоодын захад нийлүүлсэн цэвэр интервенц

сая ам.доллараар

Он	Дуудлага худалдаа		Дуудлага худалдааны бус			Нийт
	Ам.доллар	Юань	Ам.доллар	Юань	Бусад валют	Цэвэр дүн
2014 он	1,260.4	582.1	659.3	-	3.0	2,504.8
2015 он	795.9	450.0	(133.7)	-	3.7	1,115.8
2016 он	951.4	278.2	448.2	(17.3)	-	1,660.5
2017 он	78.3	16.4	(1,141.3)	-	-	(1,046.6)
2018 он*	118.6	-	(216.9)	-	-	(98.3)

*-2018 оны II улирлын байдлаар

Эх сурвалж: Монголбанк

6.2. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2018 оны 2 дугаар улирлын эцэст -32,780.6 сая ам.доллар байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гадаадаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадаадад хийсэн хөрөнгө оруулалтаас 32.8 тэрбум ам.доллараар их байна.


Хүснэгт 7. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц – 2018 оны 1-р улирлын байдлаар (тэрбум ам.доллар)

А. ГАДААД АКТИВ		5.6	Б. ГАДААД ПАССИВ		38.4
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)		0.5	6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)		19.0
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт		0.4	6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт		10.5
1.2 Бусад хөрөнгө		0.1	6.2 Бусад хөрөнгө		8.4
2. Багцын хөрөнгө оруулалт		0.3	7. Багцын хөрөнгө оруулалт		4.4
2.1 Хөрөнгийн хувьцаа		0.3	7.1 Хөрөнгийн хувьцаа		0.1
2.2 Өрийн бичиг		0.0	7.2 Өрийн бичиг		4.3
3. Санхүүгийн дериватив		0.0	8. Санхүүгийн дериватив		0.0
4. Бусад хөрөнгө оруулалт		1.8	9. Бусад хөрөнгө оруулалт		15.0
4.1 Худалдааны зээл		0.3	9.1 Худалдааны зээл		0.3
4.2 Зээл		0.1	9.2 Зээл		12.4
4.2.1 Төв банк		0.0	9.2.1 Төв банк		0.2
4.2.2 Засгийн газар		0.1	9.2.2 Засгийн газар		1.4
4.2.3 Банк санхүүгийн байгууллага		0.0	9.2.3 Банк санхүүгийн байгууллага		3.9
4.2.4 Аж ахуйн нэгж		0.0	9.2.4 Аж ахуйн нэгж		6.8
4.3 Бэлэн мөнгө ба харилцах		1.4	9.3 Бэлэн мөнгө ба харилцах		2.3
4.4 Бусад актив		0.0	9.4 Бусад пассив		0.0
5. Нөөц актив		3.0	В. ПОЗИЦ		(32.8)
5.1 Мөнгөжсөн алт		0.3	10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)		(18.5)
5.2 Зээлжих тусгай эрх		0.1	11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)		(4.1)
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө (цэвэр)		0.0	12. Санхүүгийн дериватив (цэвэр)		(0.0)
5.4 Бэлэн валют ба харилцах		1.8	13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)		(13.2)
5.5 Үнэт цаас		0.9	14. Нөөц актив		3.0
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)		0.0			
5.7 Бусад нөөц актив		0.0			


Эх сурвалж: Монголбанк

Гадаад актив. Монгол Улсаас эдийн засгийн харьяат бусад оруулсан хөрөнгө оруулалтын дүн 2018 оны 2 дугаар улирлын байдлаар 5.6 тэрбум ам.доллар байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэхүү үзүүлэлт нь 44 хувиар буюу 1,695 сая ам.доллараар өссөн бөгөөд үүнд гадаад валютын албан нөөц болон шууд хөрөнгө оруулалтын дансны активын өсөлт голлох нөлөөг үзүүлжээ. Нийт гадаад активын 54 хувийг гадаад валютын албан нөөц, 32 хувийг бусад хөрөнгө оруулалт, 9 хувийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 5 хувийг багцын хөрөнгө оруулалтын активууд бүрдүүлж байна.

Зураг 46. Гадаад актив



Зураг 47. Гадаад пассив



Эх сурвалж: Монголбанк

Гадаад пассив. Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн 38.4 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 10 хувиар буюу 3,483 сая ам.доллараар өссөн үзүүлэлт ба үүнд шууд болон бусад хөрөнгө оруулалтын өсөлт голлох нөлөөг үзүүлсэн байна. Нийт гадаад пассивын 49 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 39 хувийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 11 хувийг багцын хөрөнгө оруулалтын пассив эзэлж байна. Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 55 хувь буюу 10.5 тэрбум ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, 45 хувийг буюу 8.4 тэрбум ам.долларыг толгой компаниас авсан зээл эзэлж байна.

ШИГТГЭЭ 7. МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ДИАГНОСТИК ШИНЖИЛГЭЭ

Гадаад секторын энэхүү диагностик (оношилгоо) шинжилгээгээр төлбөрийн тэнцэл, гадаад валютын албан нөөц, гадаад өрийн харьцааны үзүүлэлтүүдийг тооцож, босго утгуудтай харьцуулан шинжлэх замаар эдийн засгийн гадаад секторын төлөв, бүтцийн эмзэг байдалд дүгнэлт өгөхийг зорилоо. Уг шинжилгээг ОУВС-гийн макро эдийн засгийн диагностик шинжилгээний жишиг аргачлал болон бусад гадаад секторын нийтлэг харьцаа үзүүлэлтүүдэд үндэслэн гүйцэтгэв¹.

Хүснэгт 8. Гадаад секторын эмзэг байдлын харьцаа үзүүлэлтүүд

		2014	2015	2016	2017	2018Н1	Эмзэг байдал бага байх нөхцөл
1. Гадаад худалдаа, урсгал тэнцэл	Урсгал тэнцэл/ДНБ	-16	-8	-6	-10	-5.5	Тогтвортой, эерэг
	Худалдааны тэнцэл/ДНБ	-9	-1.3	0.0	2.4	-0.7	Тогтвортой, эерэг
	Экспорт/Импорт	103	114	139	134	122	Өндөр
2. Гадаад санхүүжилт	ГШХО/ДНБ	1.9	0.7	1.4	13	7	Тогтвортой өндөр
	ГШХО/Гадаад өр	1.1	0.4	0.6	5	3	Тогтвортой өндөр
3. Гадаад валютын нөөцийн хүрэлцээ	ГВАН/Импорт	4.5	5.0	4.9	8.0	6.1	3 сар <
	ГВАН/Мөнгөний нийлүүлэлт	30	28	24	49	42	5% - 20%
	ГВАН/Богино хугацаат өр	68	50	50	95	85	100%
	ГВАН/ ГВАН(АРА ЕМ)	39	31	28	58	57	100%-150%
4. Гадаад өрийн тогтвортой байдал*	Өрийн үйлчилгээ/Экспорт	18	29	29	52	34	20%-иас ихгүй
	Хүүний төлбөр/Экспорт	7	11	14	13	11	Бага
	Гадаад өр/ДНБ	179	193	221	240	224	Тогтвортой бага
	Гадаад өр/Урсгал дансны орох урсгалууд	338	412	412	385	343	Бага
	эмзэг байдал бага						
	эмзэг байдал дунд зэрэг						
	эмзэг байдал өндөр						

Урсгал тэнцэл, гадаад худалдаа: Манай эдийн засгийн хувьд экспортын орлого нь түүхий эдийн үнийн хэлбэлзлээс өндөр хамааралтай, гадаад өр, зээл өндөр байдал нь урсгал тэнцлийн эмзэг байдалд нөлөөлж байна. Урсгал тэнцлийн алдагдал 2010-2013 онд хамгийн өндөр түвшиндээ буюу дунджаар ДНБ-ий -34.3 хувьд хүрсэн. Энэ жилүүдэд экспортын үнэ буурч, импорт хэмжээ өсөхөд урсгал тэнцлийн алдагдал өсч байв. Тухайлбал 2009, 2012, 2015 онд экспортын үнэ 20 хувь, 9 хувь, 19 хувиар унахад экспортын орлого 25 хувь, 6 хувь, 19 хувиар тус тус буурч, улмаар төсвийн орлого буурах, эдийн засгийн өсөлт саарахад хүрсэн. Урсгал тэнцлийн алдагдлыг шууд хөрөнгө оруулалт болон гадаад зээлээр нөхөж ирсэн нь гадаад өглөг хуримтлагдахад нөлөөлсөн. 2016 оны сүүлээс экспортын үнэ, хэмжээ харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж байсан хэдий ч гадаад өрийн хүүний төлбөр өссөн, гадаадын хөрөнгө оруулалтын ногдол ашгийн хуваарилалт нэмэгдсэн, импорт хурдтай тэлсэн зэрэг шалтгаанаар урсгал тэнцлийн алдагдал (2018 оны эхний хагаст ДНБ-ий -5.5%) өмнөх онуудын мөн үеэс өсөөд байна.

¹ Д.Ган-Очир, 2012. "Монголын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ: Инфляци, эдийн засгийн өсөлтийн хөтөч үзүүлэлтийг тодорхойлох нь", IMF, & WB., 2012. *Revisiting the Debt Sustainability Framework for Low-Income Countries.*, Seth & Ragab, 2012. *Macroeconomic Vulnerability in Developing Countries: Approaches and Issues,*

Байгалийн баялаг ихтэй орнуудын эдийн засгаа түүхий эдийн үнээс хамааралтай байдлыг бууруулах стратеги нь түүхий эдийг дахин боловсруулж, чанарыг сайжруулан экспортлох, түүхий эдийн экспортод түшиглэсэн үйлчилгээний салбарыг дэмжих, бодит ханшийг хэт чанга эсвэл хэт сул үнэлэгдсэн бус, нийцтэй түвшинд хадгалах, макро эдийн засаг болон институцийн таатай орчин (өмчийн эрх, гэрээний хариуцлагыг бэхжүүлэх)-г бүрдүүлж, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх зэрэгт тулгуурладаг (Ahrend (2008)).

Хөрөнгийн урсгал: Манай эдийн засгийн өсөлтөд ГШХО өндөр хувь нэмэр оруулж ирсэн хэдий ч хөрөнгийн урсгалын хэлбэлзэл өндөр байгаа нь гадаад санхүүжилтийн дутагдалд орох эрсдэл өндөр болж, улмаар эдийн засгийн өсөлтийг тогтвортой түвшинд хадгалахад сөргөөр нөлөөлөх, банкны системд нэмэлт эрсдэл хуримтлагдах нөхцөл болдог. Сүүлийн жилүүдэд ГШХО/Гадаад өрийн харьцаа буурсан буюу гадаад өр дэх тогтвортой хөрөнгө оруулалтын хувь буурч, бонд болон зээлээр санхүүжсэн өр төлбөрүүд нэмэгдэж байгаа нь эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Хөрөнгийн урсгалыг оновчтой удирдах Азийн орнуудын туршлагаас харахад 1. Хөрөнгийн урсгалыг ГШХО хэлбэрээр татах (бондоос илүүтэй), 2. Хөрөнгийн урсгалын хэлбэлзлийг бууруулах, 3. Банкны систем дэх хөшүүргийн харьцааг хязгаарлах нь түүний эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж, үр ашиг хүртэхэд тусалдаг байна (Forbes (2012)).

Гадаад валютын нөөцийн хүрэлцээ: Гадаад валютын албан нөөцийг импортын хэрэглээ (6.1 сар) болон мөнгөний нийлүүлэлтийг хамрах байдал (42%)-аар шинжихэд хүрэлцээтэй түвшинд, харин гадаад өр төлбөрийг барагдуулах хүрэлцээ бага байна. Мөн ГВАН-ийн зохистой түвшинг ОУВС-гийн аргачлал ARA EM metric¹ (ГВАН-ийн зохистой түвшин = экспортын 5%+мөнгөний нийлүүлэлтийн 5%+богино хугацаат өр төлбөр 30% + бусад өр төлбөрийн 15%) ашиглан тооцвол нөөц 2010-2012 онд зохистой түвшинд, 2013-2016 онд зохистой түвшнээс хэт бага байсан. 2017 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарсан, ОУВС-гийн ӨСХ-ийн эхний санхүүжилтүүд орж ирснээр Зохистой түвшин 30 пунктээр нэмэгдэж, 2018 оны эхний хагаст 58 хувьд хүрээд байгаа хэдий ч минимум шаардлага (100%)-аас даруй 42 пунктээр дутуу байна.


Өнгөрсөн хугацааг эргэн харвал эдийн засагт гадаад сөрөг шок бий болсон үед ханшийг хамгаалах бодлого барьснаар 2013-2015 онд 23 сарын дотор гадаад цэвэр нөөц 3.8 тэрбум ам.доллараар буурч, сөрөг түвшинд хүрсэн сургамж бий. ГВАН сүүлийн 1.5 жилийн хугацаанд эрчимтэй өсч хуримтлагдсан ч үндэсний аюулгүй байдлын зорилтот түвшинд хүрээгүй байна.

Гадаад өр, өрийн үйлчилгээ: Гадаад өр сүүлийн жилүүдэд хурдтай нэмэгдэж, манай орны гадаад өрийн дарамт өссөнөөр нийт гадаад өрийн хэмжээ 2017 онд ДНБ-ээс 2.4 дахин их, урсгал дансны орох урсгалаас 3.8 дахин их байсан. Харин 2018 оны 2 дугаар улирлын байдлаар гадаад өрийн өсөлт саарахын зэрэгцээ ДНБ, урсгал дансны орох урсгалын өсөлтөөс шалтгаалан дээрх харьцаа үзүүлэлтүүд бага зэрэг буурлаа. Гэвч өрийн үйлчилгээ 2018 оны эхний хагаст экспортын орлогын 34 хувийг эзэлж байгаа нь босго утгаас өндөр бөгөөд өрийн үйлчилгээний дарамт өндөр байгааг харуулж байна.

¹ *Assessment of Reserve Adequacy* буюу ГВАН-ийн зохистой түвшин = Экспортын орлогын 5%+мөнгөний нийлүүлэлтийн 5%+богино хугацаат гадаад өр төлбөрийн 30%+бусад өр төлбөрийн 10%

Дээрх шинжилгээг нэгтгэн дүгнэхэд манай гадаад валютын нөөцийн хүрэлцээ сайжирч байгаа ч хангалттай түвшинд хүрээгүй, эдийн засагт гадаад секторын эмзэг байдал өндөр, гадаад шокийн эдийн засагт үзүүлэх нөлөө хүчтэй хэвээр байна. Эдийн засгийн гэнэтийн цочролыг шингээх эсхүл түүний сөрөг үр дагаврыг хохирол багатай даван туулах чадвар, дархлааг бэхжүүлэхийн тулд гадаад тэнцвэрийг худалдааны тэнцэл болон гадаад өрийн зохистой түвшинг хослуулах байдлаар бүрдүүлэх нь зүйтэй байна. Энд эдийн засгийн цочролыг саармагжуулах болон шингээх чадварыг сайжруулах, хөрөнгийн урсгалын хэлбэлзлийн сөрөг нөлөөг бууруулахын тулд төсөв болон мөнгөний бодлогыг тууштай, мөчлөг сөрсөн байдлаар хэрэгжүүлэх, хөрөнгийн урсгалын өндөр хэлбэлзлийг макро зохистой бодлогоор бууруулах шаардлагатай. Түүнчлэн, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхээс гадна гадаад сөрөг цочролын үед уян хатан ханшийн бодлого барьснаар валютын ханш шок шингээгчийн үүрэг гүйцэтгэж, гадаад худалдаанд чөлөөт зохицуулалт хийгдэж (экспортыг дэмжиж, импортын хурд саарах), эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрт байдал хадгалагдах нөхцөл болдог.

Зураг 48. Гадаад валютын нөөцийн хүрэлцээ



6.3. Монгол Улсын нийт гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өр 2018 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 27.7 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеээс 2,176 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Засгийн газар, бусад салбар шууд хөрөнгө оруулалтын гадаад зээлийн өсөлт голчлон нөлөөлж байна.

Улсын салбар: Засгийн газрын гадаад өр 898 сая ам.доллараар нэмэгдэж 6.9 тэрбум ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 252 сая ам.доллараар нэмэгдэж 2.1 тэрбум ам.долларт хүрчээ.


Хувийн хэвшил: Банк, бусад сектор болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 1,025 сая ам.доллараар нэмэгдэж 18.7 тэрбум ам.доллар болсон байна.

Хүснэгт 9. Гадаад өрийн үлдэгдэл / тэрбум \$/

Үзүүлэлт	6/30/2017	6/30/2018	YoY, %	%2*
Нийт гадаад өр	25.6	27.7	9%	100%
I. Засгийн газар	6.0	6.9	15%	25%
II. Төв банк	1.9	2.1	13%	8%
III. Банк	2.2	2.3	6%	8%
Богино хугацаат	0.7	0.8	7%	
Урт хугацаат	1.5	1.5	5%	
IV. Бусад сектор	7.9	8.0	1%	29%
Богино хугацаат	0.5	0.6	19%	
Урт хугацаат	7.4	7.3	0%	
V. Хөрөнгө оруулагч зээл	7.6	8.4	11%	30%


*Нийтэд эзлэх %

Зураг 49. Гадаад өрийн үлдэгдэл



Банкны салбарын гадаад өр. Банкны салбарын гадаад өрийн үлдэгдэл 2018 оны 2 дугаар улиралд 2,299 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар буюу 123 сая ам.доллараар өсчээ. Уг салбарын гадаад өрийн 41 хувийг урт хугацаат зээл, 26 хувийг бонд, өрийн бичиг, 21 хувийг богино хугацаат зээл, үлдсэн 13 хувийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Зураг 50. Гадаад өрийн үлдэгдэл



Бусад (банкны бус) салбарын гадаад өр. Банкнаас бусад салбар буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр 2018 оны 2 дугаар улирлын эцэст 16,402 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 903 сая ам.доллараар өссөн дүнтэй байна. Салбарын нийт зээлийн 51 хувь буюу 8.2 тэрбум ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн

нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээл (компани хоорондын зээллэг) байна. Энэ төрлийн зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь үгүй, улмаар харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай юм.

Нийт гадаад өр ба ДНБ-ий харьцаа (223%) нь тухайн улсын өрийн эргэн төлөх чадварыг эдийн засгийн үйл ажиллагааных нь хүрээнд хэмждэг үзүүлэлт юм.

Нийт гадаад өр ба экспортын харьцаа (441%) нь гадаад өрийн хэмжээг бараа, үйлчилгээний экспортын хэмжээний хувьд хэмжиж, өрийн дарамтыг тухайн улсын гадаад орлогын үндсэн эх үүсвэрт нь харьцуулдаг.

Нийт гадаад өр ба Төсвийн орлогын харьцаа (1470%) нь тухайн Засгийн газрын (ялангуяа төсөвт гадаад өрийн дарамт өндөр байгаа үед) дотоодоосоо орлого бий болгох чадамжийг харуулдаг.

ШИГТГЭЭ 8. МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ

Байгаль орчин, нийгэмд ээлтэй тогтвортой санхүүжилтийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх хүрээнд Монгол Улсын Тогтвортой Санхүүжилт (ТоС)-ийн үндсэн зарчим болон салбарын удирдамжийг банкууд 2015 оны 1-р улирлаас эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж байна. Цаашид тогтвортой санхүүжилтийн зарчим, шаардлагыг банкнаас бусад санхүүгийн салбарт нэвтрүүлэх, хамрах цар хүрээг өргөжүүлэх зорилгоор Монголын Банкны Холбоо (МБХ)-ны Удирдах зөвлөлөөс Монголын Тогтвортой Санхүүжилтийн Хөгжлийн Холбоо (ТоС Холбоо) ГҮТББ-ыг үүсгэн байгуулж, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс үйл ажиллагааг нь албан ёсоор эхлүүлээ.

ТоС Холбоо нь цаашид Монгол улсыг бүс нутагтаа тогтвортой санхүүжилтийн манлайлал, мэдлэгийн төв болгон хөгжүүлэх алсын хараатай ажилладаг бөгөөд санхүүгийн салбар болон бизнесийн байгууллагад байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх, тогтвортой санхүүжилт, ногоон зээл, хөрөнгө оруулалтын дэд бүтцийг бий болгох, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжихэд манлайлан ажиллахыг зорьж байна.

Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг дэмжих, Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлын асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулахыг зорин, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Сангийн яам (СЯ), Ногоон уур амьсгалын сан (НУАС) болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран төр, хувийн хэвшлийн хамтарсан үндэсний хэмжээний санхүүгийн байгууллага болох Монголын Ногоон Санхүүгийн Корпораци (МНСК)-ийг байгуулах төслийг хэрэгжүүлж байна.

Дэлхийн хүн амын өсөлт, эдийн засгийн хөгжил, технологийн дэвшлийг даган, хүрээлэн байгаа орчин, байгалийн баялагт хандах хандлага, хэрэглээ тогтмол өөрчлөгдөж олон талын үр дагаврыг үүсгэж байна. Уур амьсгалын өөрчлөлт, хөрс-агаар-усны бохирдол, эрчим хүчний эх үүсвэр, байгалийн нөөц, хоол хүнсний хомсдол, хүлэмжийн хийн ялгарал зэрэг асуудлууд нь ядуурлын түвшинг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтөд сөргөөр нөлөөлж буй гол хүчин зүйл болж байна.

Монгол Улс дахин сэргээгдэхгүй байгалийн нөөц баялагт тулгуурласан эдийн засгийн бүтэцтэй, эрчим хүчний эх үүсвэр дутмаг байгаа нь хүрээлэн буй орчноо доройтуулах, хүлэмжийн хийн ялгаралтыг нэмэгдүүлэх, үр ашиг багатай хэрэглээг нэмэгдүүлж, байгаль экологид сөрөг нөлөө үзүүлж байна. Үүний зэрэгцээ ядуурал, ажилгүйдэл, хүний эрх зөрчигдөх, хөдөлмөр хамгааллын доголдол, цаашлаад Монголын нүүдэлчний соёл, ахуй уламжлал алдагдах эрсдэл байгааг шийдвэрлэх шаардлагатай байна.

Эдгээр асуудалд шийдэл олох зорилгоор 2016 оны 4 дүгээр сард Улсын Их Хурлаас Монгол Улсын 2016-2030 оны Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад уялдуулан соёрхон баталлаа. Уг үзэл баримтлал нь монгол хүнийг эрүүл саруул орчинд амьдрах, найдвартай ажлын байраар хангах, орлогын эх үүсвэртэй, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын хүртээмжтэй, чанартай тогтолцоотой, чинээлэг хангалуун амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үндсэн зарчимд тулгуурласан.

Түүнчлэн уг үзэл баримтлалын баримт бичигт шинэ хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд, хөгжлийн сангуудын оролцоог онцолсон байдаг. Энэхүү баримт бичгийг бодитойгоор хэрэгжүүлэх, хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийн загвар руу шилжихэд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг эдийн засгийн бодлогод тусгаж, уялдуулах шаардлага зайлшгүй гарч байна.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын санхүүгийн салбарын 95 хувийг бүрдүүлж буй банкны салбарын хувьд тогтвортой хөгжлийг дэмжсэн санхүүжилтийг олгох, банкнаас зээл, хөрөнгө оруулалт хүсч буй ААН, иргэдийг байгаль орчин, нийгэмд ээлтэйгээр үйл ажиллагаа явуулах шаардлага тавих, ногоон төсөл хэрэгжүүлэхийг дэмжих санхүүжилтийн хөшүүргийг бий болгох зэрэг оролцоо нэн чухал ач холбогдолтой байна. Иймд МБХ, Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Нидерландын хөгжлийн банк (НХБ) болон Худалдаа хөгжлийн банкнаас хамтран 2013 оны 5 сард анх удаа зохион байгуулсан “Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн Форум”-ын хэлэлцүүлгийн үеэр Монгол Улсын төрийн байгууллагын холбогдох албан тушаалтнууд, банкны болон бизнесийн салбарын төлөөлөгчид ногоон хөгжлийг хамтдаа хэрхэн бий болгох бодлогын асуудлыг хэлэлцсэн бөгөөд цаашид зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний нэг нь банк, санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагууд болон банкны харилцагчдын дунд тогтвортой санхүүжилтийн талаарх мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэх, чадвар чадамжийг бий болгох ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзэн Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн юм.

Энэхүү шийдвэрийн дагуу МБХ, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Монголбанк, СЗХ, нийт банкуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулж Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмууд болон 4 салбарын удирдамж /уул уурхай, барилга, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр/-ийг боловсруулах ажлыг ОУСК, НХБ-ны зөвлөхүүдийн тусламжтайгаар гүйцэтгэн, улмаар 2014 оны 12 дугаар сард Монгол Улсын “Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн Форум 2014” арга хэмжээг зохион байгуулж, анх удаа хөтөлбөрийн талаар олон нийтэд танилцуулж, 2015 оны 1 дүгээр сараас эхлэн ТоС-ийн зарчмуудыг банкууд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлсэн. Эдгээр зарчим нь байгаль орчин, хүний эрх, соёлын өв, ногоон эдийн засаг, санхүүгийн хүртээмж, ил тод байдал зэрэг тулгамдаж буй чухал асуудлыг тусгасан бөгөөд банкнаас санхүүжүүлж буй төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлж, бууруулах, цаашлаад ногоон төслүүдийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд банкуудад дэмжлэг, чиглэл өгөх зорилготой юм.


Өнөөдрийн байдлаар банкуудаас ТоС-ийн зарчмуудыг хэрэгжүүлж, өөрсдийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн удирдлагын системийг бүрдүүлэн, зээл, санхүүжилт олгохдоо байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тооцоолон ажиллаж байна. Мөн уул уурхай, барилга, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл зэрэг байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй салбаруудад тавигдах тусгай шаардлагуудыг тодорхойлж, бизнесийн үйл ажиллагааг аль болох дэмжих, зөвлөгөө өгөх, сөрөг үр дагаврыг бууруулах арга замыг эрэлхийлэн хамтран ажиллаж байна.

VII. ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Засгийн газар, Монголбанк хамтран 2013 оны 6 дугаар сараас “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр” (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Хөтөлбөрийн хүрээнд банкуудаар дамжуулан иргэдэд хөнгөлөлттэй хүү (8 хувь)-тэй орон сууцны зээл олгон, уг зээлийг МИК ОССК ХХК-аас үүсгэн байгуулсан Тусгай зориулалтын компани (цаашид ТЗК гэх)-иар дамжуулан үнэт цаасжуулах үйл ажиллагааг явуулж байна.

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр манай улсын орон сууцны зах зээл ихээхэн тэлсэн бөгөөд 2012 онд орон сууцны зээлийн үлдэгдэл ДНБ-ий 5.1 хувьтай тэнцэж байсан бол 2017 оны байдлаар 15.9 хувьд хүрчээ. Банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл хөтөлбөр хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2012 оны 12 дугаар сарын байдлаар 845.2 тэрбум төгрөг байсан бол 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4.3 их наяд төгрөг (ТЗК-д худалдсан зээлийг оруулснаар) болж өссөн байна.

Зураг 51. Банкуудын орон сууцны ипотекийн зээлийн үлдэгдэл, зээлийн өсөлт



ОУВС-ийн хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш Монголбанк хөтөлбөрийн эх үүсвэрийг өөрийн эзэмшил дэх ИЗББ-ын зөвхөн үндсэн төлбөрөөр санхүүжүүлж эхэлсэн бөгөөд 2017 оны 5 дугаар сараас хойш 2018 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд нийт 223.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Монголбанкнаас олгоод байна. Харин Засгийн газраас ИЗББ-ын купоны төлбөртэй тэнцэх хэмжээний эх үүсвэр буюу 120 тэрбум төгрөгийг 2018 оны улсын төсөвт тусгаж, үүнээс 2018 оны 7 дугаар сарын байдлаар 59.6 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Монголбанкаар дамжуулан банкуудад

олгожээ.

Монголбанк хөтөлбөрийн хэрэгжилтийн тасралтгүй байдлыг хангахаас гадна санхүүжилтийн тогтолцоог сайжруулах, ипотекийн зээлийн хөтөлбөрийг макро эдийн засгийн төлөв байдалтай уялдуулан урт хугацаанд хэрэгжих боломжийг бүрдүүлэх, санхүүгийн системд үүсч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор Дэлхийн банкнаас техник туслалцаа аван ажиллаж байна. Дэлхийн банкнаас Монгол Улсад хэрэгжүүлж буй EMSO (Economic Management Support Operation Program) хөтөлбөрийн нэг зорилт болох “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг Засгийн газарт шилжүүлэх ажлын хүрээнд Монголбанк нь Барилга хот байгуулалтын яам, Сангийн яам зэрэг хөтөлбөрт оролцогч талуудтай хамтран ажиллаж байна.

VIII. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

8.1. Санхүүгийн салбар

Санхүүгийн салбар нь санхүүгийн хөрөнгийг төвлөрүүлэн үр ашигтайгаар эдийн засагт хуваарилах, эрсдэлийг бууруулах, төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх дэд бүтцээр хангах замаар эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлдэг.

Хөгжингүй орнуудтай харьцуулахад хөгжиж буй орнуудын санхүүгийн салбар нь банк төвтэй, хөрөнгийн зах зээлийнх нь хөгжил сул байх хандлага ажиглагддаг. Үүнд хуримтлал бага, институцийн хөгжил, засаглалын төлөвшил сул, иргэдийн санхүүгийн мэдлэг, боловсрол дутмаг байдал нь голлон нөлөөлдөг. Манай улсын хувьд санхүүгийн системийн 95 хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж, санхүүгийн зах зээл хөгжлийнхөө эхэн үед явж байна. Хэдийгээр 2018 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 539 банк бус санхүүгийн байгууллага, 289 хадгаламж зээлийн хоршоо, 17 даатгалын компани, 303 хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тоо жил бүр олширч, үйл ажиллагааных нь цар хүрээ өргөжин тэлсээр байгаа боловч, санхүүгийн зах зээлд банкны салбартай харьцуулахад бага хувийг эзэлсэн хэвээр байгаа юм.

Хүснэгт 10. Санхүүгийн дэд секторуудын актив, ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/

	Актив		Ашиг		Өөрийн хөрөнгө	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь
2018 оны II улирал						
Банк	30 259	94.7%	32	36.3%	3 180	74.3%
ББСБ	1 144	3.6%	47	52.1%	888	20.8%
Даатгал	282	0.9%	6.3	7.1%	127	3.0%
ХЗХ	176	0.6%	1.1	1.2%	29	0.7%
Үнэт цаасны оролцогч	93	0.3%	3.0	3.4%	56	1.3%
2017 он						
Банк	28 773	95.2%	249	73.9%	3 150	76.7%
ББСБ	969	3.2%	67	19.8%	758	18.5%
Даатгал	245	0.8%	13.2	3.9%	115	2.8%
ХЗХ	153	0.5%	5.5	1.6%	15	0.4%
Үнэт цаасны оролцогч	89	0.3%	2.7	0.8%	69	1.7%
2016 он						
Банк	25 338	95.5%	176	70.7%	2 936	79.5%
ББСБ	787	3.0%	59	23.6%	579	15.7%
Даатгал	208	0.8%	11.4	4.6%	106	2.9%
ХЗХ	113	0.4%	3.8	1.5%	12	0.3%
Үнэт цаасны оролцогч	73	0.3%	-1.1	-0.4%	61	1.6%

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн салбарт тогтворгүй байдал үүсвэл эргээд бодит эдийн засагт сөргөөр нөлөөлөх, эдийн засагт учирсан савалгааг нэмэгдүүлэх зэрэг эрсдэлийг дагуулдаг. Үүний нэг тод жишээ бол АНУ-ын моргейжийн зах зээлээс үүдэлтэй 2008 онд тохиосон дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал юм. Уг хямрал нь санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дан ганц уламжлалт микро зохистой бодлогыг хэрэгжүүлэх нь хангалтгүй болохыг бодлого боловсруулагчдад тодорхой харуулсан. Улмаар тус хямралын дараа улс орнууд санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн макро зохистой бодлого хэрэгжүүлэх суурь, боломж бүхий уламжлалт институцийг шинэчлэн зохион байгуулах, шинээр үүсгэн бий болгох, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүрэг (мандат)-ийг хуулиндаа тодорхой тусгах хандлага ажиглагдаж байна.

Хүснэгт 11. Макро болон микро зохистой бодлогын ялгаа

	Макро зохистой бодлого	Микро зохистой бодлого
Ойрын зорилго	Системийн хэмжээний хүндрэлийг хязгаарлах	Тухайн байгууллагын хүндрэлийг хязгаарлах
Туйлын зорилго	ДНБ-ий алдагдлаас зайлсхийх	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах
Санхүүгийн байгууллагуудын харилцан хамаарал, нийтлэг эмзэг байдал	Чухал	Хамааралгүй
Зохистой бодлогын хэрэгжилт	Нийт системийн хувьд, дээрээс доош (top-down) чиглэнэ.	Тухайн байгууллагын эрсдэлийн хувьд, доороос дээш (bottom-up) чиглэнэ.

Эх сурвалж: Borio (2003)

Дэлхий нийтийн чиг хандлагыг даган манай улс 2010 онд Төв банк / Монголбанк/-ны тухайн хуульд нэмэлт өөрчлөлт оруулан Монгол Улсын санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийг үүсгэн байгуулсан. СТБЗ нь макро эдийн засаг болон санхүүгийн салбарт тулгамдаж буй зарим асуудлыг тухай бүрт нь хурлаараа авч хэлэлцэн зохих шийдвэр, зөвлөмжийг гарган ажилладаг бөгөөд 2010 оноос хойш нийт 31 удаагийн хуралдаанаар 142 багц асуудлыг авч хэлэлцээд байна. Мөн түүнчлэн олон нийтийн санхүүгийн салбарын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, санхүүгийн салбарын талаарх бодит мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй, цаг тухайд нь хүргэж, бодит хүлээлтийг төлөвшүүлэх замаар санхүүгийн салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх, түүний тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд СТБЗ-өөс 2013 оноос хойш хагас жил тутам “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г бэлтгэн гаргаж буй бөгөөд одоогоор эхний 11 дугаарыг бэлтгэн олон нийтийн хүртээл болгоод байна. Түүнчлэн УИХ 2018 оны 1 дүгээр сард Төв банк /Монголбанк/-ны тухайн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж макро зохистой бодлого хэрэгжүүлэх эрх үүргийг Монголбанкинд олгосон. Ингэснээр Монголбанк нь банкуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах уламжлалт үүрэг, функц дээр нэмж банк, санхүүгийн системийн тогтолцооны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг тодорхойлж, үнэлэн түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор макро зохистой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэгтэй болсон. Энэхүү чиг үүргийн дагуу Монголбанк нь макро зохистой бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлээд байгаа

бөгөөд тухайлбал Мөнгөний бодлогын хорооны 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар иргэдийн өрийн дарамтыг хязгаарлаж улмаар санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх зорилгоор банкнаас олгох иргэдийн хэрэглээний зээлд Өр-орлогын харьцааны дээд хязгаарыг 70 хувиар тогтоогоод байна.

ШИГТГЭЭ 9. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН 9 ДҮГЭЭР СТАНДАРТ

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс боловсруулсан санхүүгийн хэрэгслийг ангилах, хэмжих, түүний үнэ цэнийн бууралтыг тооцох тухай санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 9 (СТОУС 9)-ийг дэлхий нийтээр 2018 оноос эхлэн мөрдөж байна. СТОУС 9 “Санхүүгийн хэрэгсэл” нь дараах үе шаттай. Үүнд:

1. Ангилах, хэмжих
2. Үнэ цэнийн бууралтыг тооцох
3. Хейджийн бүртгэл.

СТОУС 9-ийн дагуу банкууд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг тэнцэлд анх бүртгэхдээ эрсдэлийн сан буюу үнэ цэнийн бууралтыг байгуулах, эрсдэлийн сангийн параметруудийг оновчтойгоор тооцоолох, харгалзах тоон мэдээллийн баазыг бүрдүүлэх шаардлагатай. Өмнөх Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 39 (НББОУС 39) “Санхүүгийн хэрэгсэл: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт”-ээс ялгарах гол ялгаа нь бодитоор алдагдал үүсэхээс гадна ирээдүйд алдагдал үүсч болзошгүй санхүүгийн хэрэгсэлд эрсдэлийн сан байгуулах явдал юм.

Хүснэгт 12. Одоо мөрдөж буй болон шинэ стандарт хоорондын гол ялгаа

Дд	Үзүүлэлт	НББОУС 39 (IAS 39)	СТОУС 9 (IFRS 9)
1	Хамрах хүрээ	Санхүүгийн хэрэгслүүд буюу санхүүгийн актив, пассив хамаарна. Өмнөх ба шинэ стандартын хамрах хүрээ адилхан. Шинэ стандартад банкнаас дотоод хэрэгцээндээ ашиглахаар тодорхойлсон санхүүгийн хэрэгслийг бодит үнэ цэнээр үнэлж болохоор заасан.	
2	Активыг ангилах, хэмжих	Санхүүгийн хэрэгслийг дараах 4 ангиллын алинд тодорхойлсноос шалтгаалж, ялгаатай ангилна: • Хугацааны эцэс хүртэлх • Зээл, авлага • Бодит үнэ цэнийн үнэлгээ • Борлуулахад бэлэн	Санхүүгийн хэрэгслийг гэрээнд заасан мөнгөн урсгалын шинж чанар, байгууллагын бизнес загвараас шалтгаалан дараах 3 төрлөөр ангилна: • Хорогдуулсан өртөг • Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжих бодит үнэ цэнэ • Ашиг, алдагдлаар дамжих бодит үнэ цэнэ

3	Үнэ цэнийн бууралт	• Үнэ цэнийн бууралтыг үндсэн 4 ангиллын алинд тодорхойлсноос шалтгаалж ялгаатай тооцдог. • Санхүүгийн хэрэгслийг анх бүртгэхдээ эрсдэлийн сан байгуулахгүй бөгөөд эрсдэл үүсээгүй буюу бодитоор алдагдал үүсээгүй гэж үзвэл цаашид ч сан байгуулахгүй байж болно. • Үнэ цэнийн бууралтыг эргэн төлөгдөх хугацаа хүртэл үүсэх нийт эрсдэлд үндэслэн тооцно.	• Бүх санхүүгийн хэрэгсэлд нэг шаардлага тавьж, үнэ цэнийн бууралт тооцдог бөгөөд анх тэнцэлд бүртгэхдээ эрсдэлийн сан байгуулна. • Бодитоор алдагдал үүсэхээс гадна ирээдүйд алдагдал үүсч болзошгүй санхүүгийн хэрэгсэлд шууд сан байгуулна. • Үнэ цэнийн бууралтыг 3 үе шаттайгаар байгуулна: - о Ойрын 12 сард алдагдал хүлээх, - о Өндөр эрсдэлтэй, - о Эргэн төлөгдөх хугацаа хүртэл хүлээх эрсдэл.
---	--------------------	---	--

Дээрх хүснэгтэд үзүүлсэнчлэн шинэ стандартын дагуу банкууд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг тэнцэлд анх бүртгэхдээ эрсдэлийн сан буюу үнэ цэнийн бууралтыг байгуулах шаардлагатай болж байгаа бөгөөд эрсдэлийн сангийн параметруудийг оновчтойгоор тооцоолох, харгалзах тоон мэдээллийн баазыг бүрдүүлэх шаардлагатай болно.

БНХАУ, Тайланд, Индонези зэрэг зарим улс СТОУС 9-ийг нэвтрүүлэх хугацааг 2019 он хүртэл хойшлуулах шийдвэр гаргажээ. Монголбанк Олон улсын валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хийсэн активын чанарын иж бүрэн үнэлгээний үр дүнгээр 2019 он хүртэл банкуудтай хамтран хэрэгжүүлэх шат дараалсан арга хэмжээг авч дууссаны дараа 2020 оноос эхлэн СТОУС 9-ийг банкуудад мөрдүүлэх нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Улмаар уг стандартыг Сангийн яамтай хамтран урьдчилан боловсруулсан төлөвлөгөөний дагуу нэвтрүүлэхээр ажиллаж байна.


8.2. Банкны салбарын өнөөгийн байдал, цаашдын төлөв

Банкны салбар 2018 оны 7 дугаар сарын байдлаар нийт 14 банк, 1,529 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хадгаламжийн дансны тоо 3.0 саяд, зээлдэгчдийн тоо 929 мянгад хүрлээ.

Активын бүтэц, өөрчлөлт


Салбарын нийт активын хэмжээ 2018 оны эхний хагас жилд анх удаа 30 их наяд төгрөгийг давж өмнөх оны эцсээс 12.5 хувиар буюу 3.3 их наяд төгрөгөөр өслөө. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд банкуудын Засгийн газрын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтаас бусад актив нэмэгдсэн бол Төв банкны үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт 3.1 их наяд төгрөгөөр, цэвэр зээлийн үлдэгдэл 2.0 их наяд төгрөгөөр өссөн нь активын өсөлтөд голлох нөлөөг үзүүлжээ.

Зураг 52. Активын бүтэц, өсөлт (их наяд төгрөгөөр)



3.33 <-Нийт өсөлт

Нийт активыг бүтцээр нь авч үзвэл 47.4 хувь нь зээл, 19.9 хувь нь мөнгөн хөрөнгө, 13.3 хувь нь Төв банкны үнэт цаас, 5.3 хувь нь Засгийн газрын үнэт цаас, үлдэх 14.1 хувь нь бусад төрлийн хөрөнгө байна. Активын бүтцэд гарсан томоохон өөрчлөлтөөс харахад Төв банкны үнэт цаасны эзлэх хувь 7.5 нэгжээр өссөн бол Засгийн газрын үнэт цаасны эзлэх хувь 8.1 нэгжээр буурлаа. Харин сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч байсан зээлийн нийт активт эх эзлэх хувь 2017 оны сүүлээс тогтворжих хандлага гарсан болно.


Зураг 53. Зээлийн үлдэгдэл (их наяд төгрөгөөр), өсөлт

Зээл, зээлийн өсөлт. Банкны салбарын зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны эхний хагас жилд 15.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19.7 хувиар өсчээ. Энэхүү өсөлт нь 2015 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд ирээдүйд баялаг бүтээх бодит секторт зээл олголт сэргэх хандлага ажиглагдлаа. Тухайлбал, 2016-2017 оны зээлийн өсөлтийг иргэдийн хэрэглээ болон үндсэн хөрөнгө санхүүжүүлэх зориулалттай зээл олголт бүрдүүлж байсан бол 2018 оны эхнээс энэ

байдал өөрчлөгдөж байгууллагын болон иргэдийн зээл олголт ойролцоо түвшинд хүрсэн.

Байгууллагын зээлийн өсөлтийг аж ахуйн нэгжийн хэмжээгээр задалж үзэхэд 1 тэрбум төгрөгөөс их борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийн зээл өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар нэмэгдсэн бол түүнээс жижиг бизнесийн зээл 37.3 хувиар өсчээ.


Эдийн засгийн секторүүдын зээл олголт, төлөлтийг авч үзэхэд уул уурхай, худалдааны салбарын зээл нэмэгдэж байгаа бол боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарын зээлийн өсөлт харьцангуй бага байна. Үүнээс гадна хэрэглээний зээлийн өсөлт өндөр хэвээр байна.

Зураг 54. Эдийн засгийн голлох салбаруудын зээлийн үлдэгдэл (их наяд төгрөгөөр), нийт зээлд эзлэх хувь, жилийн өсөлт

Зээлийн чанар


2018 оны 7 дугаар сарын эцэст нийт зээлийн 86.0 хувь буюу 13.3 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 6.7 хувь буюу 1035.9 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ангилалд, 7.3 хувь буюу 1,129.1 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд багтжээ.

Зураг 55. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр), тэдгээрийн нийт зээлд эзлэх хувь




2016 оны эцсээс эдийн засаг сэргэж эхэлсэн хэдий ч банкны салбарын зээлийн чанар төдийлөн сайжрахгүй байна. Тухайлбал, банкны салбарын хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл өмнөх жилийн мөн үеэс 16.7 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 19.2 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Чанаргүй зээл өсөхөд барилгын салбарын зээлийн чанар үргэлжлэн муудаж байгаа нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, орон сууцны борлуулалт муусантай холбоотойгоор тайлант жилд барилгын салбарын чанаргүй зээл 92.2 хувиар өссөн бол харин худалдааны салбарын чанаргүй зээл 17.9 хувиар буурлаа.

Эдийн засгийн салбарын чанаргүй зээлийн хувийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад уул уурхай болон худалдааны салбарын чанаргүй зээлийн хувь 3-4 нэгжээр тус тус буурсан бол барилга болон бусад салбарын чанаргүй зээлийн хувь 6-8 нэгжээр тус тус өсчээ. Харин иргэдийн зээл давамгайлсан үл хөдлөх хөрөнгө болон хэрэглээний зээлийн чанар харьцангуй тогтвортой байна.

Зураг 56. Тухайн салбар дахь чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хувь**Эх үүсвэрийн бүтэц, өөрчлөлт**

Тайлант сард банкны салбарын нийт эх үүсвэр 26.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үес 14.0 хувиар буюу 3.3 их наяд төгрөгөөр өслөө. Эх үүсвэрийн өсөлтөд банкуудын иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагаас татсан харилцах, хадгаламж өмнөх оны мөн үеэс харгалзан 24.9; 23.8 хувиар нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Зураг 57. Активын бүтэц, өсөлт (их наяд төгрөгөөр)

Харилцахын өсөлтөд хувийн болон улсын байгууллага, Засгийн газрын хөрөнгө 259 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн өсөлтөд иргэд, улсын


байгууллагын хадгаламж 1.1 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүллээ. Хадгаламжийн өсөлтийг төрлөөр нь ангилбал хугацаатай хадгаламж өмнөх оны мөн үеэс 28.5 хувиар өсч 9.9 их наяд төгрөгт, хугацаагүй хадгаламж 8.4 хувиар өсч 2.4 их наяд төгрөгт хүрчээ. Харилцах, хадгаламжийн өсөлтийг сүүлийн жилүүдийн дундаж өсөлттэй харьцуулахад өндөр байна.

Нийт эх үүсвэрийг бүтцээр нь авч үзвэл банкны салбарын нийт эх үүсвэрийн 65.5 хувийг харилцах, хадгаламж, 20.6 хувийг банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, үлдэх 13.8 хувийг банкнаас дотоод, гадаадын зах зээл дээр гаргасан үнэт цаас, төслийн санхүүжилт зэрэг бусад төрлийн эх үүсвэр бүрдүүлж байна.


8.3. Банкны салбарын эрсдэл даах чадвар

2018 оны 6 дугаар сарын байдлаар банкны системийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12.5 хувь, нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 15.8 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцаанаас харгалзан 3.5; 3.8 нэгжээр тус тус өндөр байна. Мөн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт нь Монголбанкнаас тогтоосон доод хязгаарлалтаас 17.2 нэгжээр илүү буюу 42.1 хувь байна. Гадаад валютын нээлттэй позиц, өөрийн хөрөнгийн харьцаа -11.8 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон хувь болох +/-40 хувь дотор байна.

Зураг 58. Банкны системийн эрсдэл даах чадварын үзүүлэлт



Зураг 59. Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



ШИГТГЭЭ 10. ЭРСДЭЛИЙН НЭМЭГДЛИЙН ТҮВШИН

Эдийн засгийн өсөлтийн онолд эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг тодорхойлогч нэг чухал хүчин зүйл нь капитал (хүмүүн болон биет) хуримтлал гэж үздэг. Капитал хуримтлалыг бүрдүүлдэг гол эх үүсвэр нь дотоод хуримтлал бөгөөд дотоод хуримтлал багатай хөгжиж буй улс орнуудын хувьд гадаад санхүүжилт (ГШХО, багцын хөрөнгө оруулалт, зээл зэрэг) нь капитал хуримтлалыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих чухал эх үүсвэр болж байна.

Хүснэгт 13. Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ, өөрчлөлтүүд

Огноо	Moody's		Fitch		Standard and Poors	
	Үнэлгээ	Төлөв	Үнэлгээ	Төлөв	Үнэлгээ	Төлөв
2005	VII/18		B+	•		
	X/4	B1			B	•
	XI/1				B	(+)
2006	XII/29				B+	▲
	XII/26				BB-	▲
	IX/20		B+	(+)		
2007	VI/2		B+	•		
	XII/9		B+	(-)		
	XII/19				BB-	(-)
2008	I/18	B1	(-)	B	▼	(-)
	VI/10					
	X/30	B1	•			
	XI/11			B	•	
	XI/20				BB-	•
2010	XI/23		B+	▲	•	
	XII/19				BB-	(+)
	X/29				BB-	•
2011	IV/16				BB-	(-)
	XII/13		B+	(-)		
	IV/29				B+	▼
	V/26	B1	(-)			•
	VII/17	B2	▼			
2012	XII/11		B+	(-)		
	IV/29				B+	(-)
	XI/03				B	▼
	XI/04		B	▼	•	
	XI/24		B	•		
2013	I/14	B2	(-)	B	•	
	III/31	B2	(-)			
	IV/28				B	•
	VII/21			B	•	
	VIII/19				B-	▼
	VIII/26	B3	▼			•
	XI/18	Caal	▼	•		
2014	XI/21		B-	▼	•	
	II/15	Caal	•			
	II/20		B-	•		
	III/30	Caal	•			
	IV/18				B-	•
	XI/17		B-	(+)		
	XI/30	Caal	•			
2015	I/18	B3	▲	•		
	IV/20				B-	•
	VII/09		B	▲	•	

Зэрэглэлийн өөрчлөлт , ▲▼
Төлөв: (+)-эерэг, •-тогтвортой, (-)-сөрөг

Хүснэгт 14. Зээлжих зэрэглэлийн ангилал

Ангилал	Moody's	Fitch	S&P
Дээд зэрэглэл	Aaa	AAA	AAA
Өндөр зэрэглэл	Aa1	AA+	AA+
	Aa2	AA	AA
	Aa3	AA-	AA-
Дундаас дээгүүр зэрэглэл	A1	A+	A+
	A2	A	A
	A3	A-	A-
Дундаас доогуур зэрэглэл	Baa1	BBB+	BBB+
	Baa2	BBB	BBB
	Baa3	BBB-	BBB-
Хөрөнгө оруулалтын бус эрсдэлтэй	Ba1	BB+	BB+
	Ba2	BB	BB
	Ba3	BB-	BB-
Өндөр эрсдэлтэй	B1	B+	B+
	B2	B	B
	B3	B-	B-
Маш өндөр эрсдэлтэй	Caal	CCC	CCC+
	Caal2		CCC
	Caal3		CCC-
Туйлын өндөр эрсдэлтэй	Ca		CC
	Ca		CC
	Ca		C
Төлбөрийн чадваргүй, сэргэх магадлал бага	C	DDD	D
		DD	
		D	

Эх сурвалж: Moody's, Fitch, S&P's, Монголбанк

Аливаа улсын гадаад санхүүжилт татах чадавх нь тухайн улсын эрсдэлийн түвшингээс хамаардаг. Нью-Йоркийн их сургуулийн профессор Дамодараны судалгаанд дурдсанаар¹ улсын эрсдэлийг үнэлэх дараах голлох хэмжүүрүүд байна. Үүнд:

- Улсын зээлжих зэрэглэл
- Улсын эрсдэлийн оноо (risk score)
- Хөрөнгийн зах зээлийн хэлбэлзэл.

¹ Aswath Damodaran (2018) "Equity Risk Premiums (ERP): Determinants, Estimation and Implications – The 2018 Edition"

Эдгээрээс олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудын тодорхойлдог зээлжих зэрэглэлийн үнэлгээ нь тухайн улс гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас авсан зээлээ эргэн төлөх чадваргүй болох буюу дефолт (default) болох эрсдэлийг үнэлэх гол үзүүлэлт болохын зэрэгцээ улсын эрсдэлийн түвшинг илтгэх хамгийн түгээмэл ашиглагддаг, цогц, найдвартай хэмжүүр болдог.

Манай улсын хувьд 1999 оноос эхлэн олон улсад нэр хүндтэй, бие даасан зээлжих зэрэглэл тогтоогч Стандарт энд Пүүрс (Эс энд Пи), Фитч рэйтингс (Фитч) болон Мүүдис Инвесторс Сервис (Мүүдис) агентлагуудаар зээлжих зэрэглэлийн үнэлгээг тогтоолгож байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг Эс энд Пи агентлаг хамгийн сүүлд 2017.04.18-ны өдөр “-В”, төлөвийг “тогтвортой”, Фитч агентлаг 2018.07.09-ний өдөр “В”, төлөвийг “тогтвортой”, Мүүдис агентлаг 2018.01.18-ны өдөр “В3”, төлөвийг “тогтвортой” гэж тус тус үнэлсэн (Хүснэгт 13). Зээлжих зэрэглэлийн агентлагуудын хувьд Монгол Улсын эдийн засгийг богино хугацааны эрсдэл, сорилтуудтай тулгарч буй боловч ирэх жилүүдэд ОУВС-гийн хөтөлбөр үргэлжилж, уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэнээр эдийн засаг сэргэх, улсын төсөв, гадаад төлбөрийн чадвар сайжрах хүлээлттэй буюу Монгол Улсын дунд болон урт хугацааны эдийн засгийн төлөвийг эергээр үнэлсэн хэвээр байна.

Дэлхийн улс орнуудын эрсдэлийн түвшин харилцан адилгүй байдгаас үүдэлтэйгээр эрсдэлийн нэмэгдлийн түвшин (country risk premium) гэдэг ойлголт гарч ирдэг. Үүнийг энгийнээр хөрөнгө оруулагчид харьцангуй эрсдэл өндөртэй улсад хөрөнгө оруулалт хийхдээ эрсдэлгүй улсад¹ хөрөнгө оруулалт оруулснаар олох эрсдэлгүй өгөөжтэй харьцуулахад нэмэлтээр (эрсдэлийн урамшуулал болгон) шаардаж буй өгөөжийн түвшин гэж ойлгож болно. Улсын эрсдэлийн нэмэгдлийн түвшин өндөр (өөрөөр хэлбэл гадаад санхүүжилтийн зардал өндөр) байх нь тухайн улсын өрийн дарамтыг нэмэгдүүлэх, ханшийн дарамтыг өсгөх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг нөлөөтэй байдаг. Харин хөрөнгө оруулагчдын зүгээс авч үзвэл хөрөнгө оруулалт хийсэн улсын эрсдэлийн нэмэгдлийн түвшин өндөр байхын хэрээр өгөөжийн түвшин ихсэх боловч, үүнийг дагаад эрсдэлийн түвшин нэмэгддэг.

Олон улсад хамгийн түгээмэл ашиглагддаг улсын эрсдэлийн нэмэгдлийн түвшинг тооцоолох аргачлал нь Нью-Йоркийн их сургуулийн профессор Дамодараны улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээнд суурилсан аргачлал юм (Aswanath Damodaran, 2018). Уг аргачлалаар улсын дефолтын зөрүү (default spread) болон эрсдэлийн нэмэгдлийн түвшин хоорондоо дараах байдлаар шууд хамааралтай гэж үздэг.


$$\text{Эрсдэлийн нэмэгдлийн түвшин} = \text{Дефолтын зөрүү} * \frac{\sigma_{equity}}{\sigma_{country bond}}$$

Энд *Country default spread* - тухайн улсын дефолтын зөрүү, σ_{equity} - хөгжиж буй орнуудын хөрөнгийн зах зээлийн индексийн стандарт хазайлт, $\sigma_{country bond}$ - хөгжиж буй орнуудын Засгийн газрын бондын өгөөжийн стандарт хазайлт.

¹ Бодит байдалд хөрөнгө оруулахад огт эрсдэлгүй улс байхгүй боловч АНУ, Герман г.м эрсдэл маш багатай улсуудыг “эрсдэлгүй” гэж тодорхойлох нь бий.

Дамодаран улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг улсын дефолтын зөрүүнд хөрвүүлэх аргачлалыг боловсруулсан бөгөөд улмаар улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээний түвшин бүрт харгалзах улсын дефолтын зөрүүний утгуудыг тодорхойлсон байна.

Зураг 60. МУ-ын эрсдэлийн нэмэгдлийн түвшин (2017 оны эцсийн байдлаар)



Эх сурвалж: <http://pages.stern.nyu.edu>, <http://pages.stern.nyu.edu/~adamodar/>

Дээрх аргачлалын дагуу тооцсон улсуудын эрсдэлийн нэмэгдлийн түвшний тоон мэдээллээс харахад Монгол Улсын эрсдэлийн нэмэгдлийн түвшин 2017 оны эцсийн байдлаар 8.64 хувь байгаа нь бусад улсын дундажтай харьцуулахад өндөр байна (Зураг 60). Монгол Улсын дефолтын зөрүү, эрсдэлийн нэмэгдлийн түвшин харьцангуй өндөр тогтоход эдийн засгийн төрөлжилт бага, түүхий эдийн үнээс хамаарах хамаарал өндөр, мөчлөг дагасан макро эдийн засгийн бодлого хэрэгжүүлдэг, засаглалын тогтворгүй байдал зэрэг суурь хүчин зүйлс нөлөөлж байна.

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Жилийн инфляцид голлох нөлөө үзүүлсэн бараа, бүтээгдэхүүнүүд 7 дугаар сарын байдлаар:.....	76
Хүснэгт 2. Монгол улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл.....	83
Хүснэгт 3. ДНБ болон инфляцийн төсөөлөл.....	91
Хүснэгт 4. БХЗ-ын хүүний бодлогын хүүнээс хазайх хазайлт, нэгж хувь.....	101
Хүснэгт 5. БХЗ-ын хэлбэлзэл 2016-2018 он.....	102
Хүснэгт 6. Монголбанкнаас гадаад валютын дотоодын захад нийлүүлсэн цэвэр интервенц	110
Хүснэгт 7. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2018 оны 1-р улирлын байдлаар (тэрбум ам.доллар)	111
Хүснэгт 8. Гадаад секторын эмзэг байдлын харьцаа үзүүлэлтүүд.....	113
Хүснэгт 9. Гадаад өрийн үлдэгдэл /тэрбум \$/	116
Хүснэгт 10. Санхүүгийн дэд секторуудын актив, ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/	122
Хүснэгт 11. Макро болон микро зохистой бодлогын ялгаа	123
Хүснэгт 12. Одоо мөрдөж буй болон шинэ стандарт хоорондын гол ялгаа	124
Хүснэгт 13. Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ, өөрчлөлтүүд.....	131
Хүснэгт 14. Зээлжих зэрэглэлийн ангилал	131

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Инфляцийн хэлбэлзэл, түүний зорилтот түвшин	18
Зураг 2. Инфляцийн задаргаа.....	20
Зураг 3. Бодит эдийн засаг, санхүүгийн мөчлөг.....	25
Зураг 4. Эдийн засгийн салбаруудад олгосон зээлийн хувь.....	26
Зураг 5. Хөрөнгийн урсгал болон зээлийн өөрчлөлт.....	27
Зураг 6. УБ хотын сар, жилийн болон суурь инфляци	56
Зураг 7. УБ хотын жилийн инфляци (бүрэлдэхүүнээр).....	56
Зураг 8. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкны хаалтын ханшийн хэлбэлзэл (төгрөгөөр)	59
Зураг 9. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкны хаалтын ханшийн өөрчлөлт (хувиар илэрхийлсэн интервалаар)	60
Зураг 10. Улсын болон Улаанбаатар хотын инфляци.....	75
Зураг 11. Улаанбаатар хотын жилийн инфляцийн задаргаа	75
Зураг 12. ДНБ-ий жилийн өсөлт.....	79
Зураг 13. ДНБ-ий жилийн өсөлтөд эзлэх хувь	79
Зураг 14. Аж үйлдвэрийн салбаруудын өсөлт.....	80

Зураг 15. Үйлчилгээний салбаруудын өсөлт	80
Зураг 16. ДНБ-ий жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр	81
Зураг 17. Хөрөнгө оруулалтын өсөлт	81
Зураг 18. Нэгдсэн төсвийн орлого, зардал, тэнцэл	82
Зураг 19. Нэгдсэн төсвийн орлого, зардлын жилийн өөрчлөлт (%)	82
Зураг 20. Гадаад эрэлтийн өөрчлөлт, хувиар	86
Зураг 21. Холбооны нөөцийн банкны хүү, хувиар	88
Зураг 22. Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт	90
Зураг 23. Улирлын ДНБ-ий жилийн өсөлтийн төсөөлөл	91
Зураг 24. Эдийн засгийн мөчлөг	92
Зураг 25. Монголын ДНБ, эдийн засгийн уналтын үеүд	93
Зураг 26. Монголын эдийн засгийн мөчлөг	93
Зураг 27. Жилийн инфляцийн төсөөлөл	94
Зураг 28. М2 мөнгөний жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр /актив/	97
Зураг 29. М2 мөнгөний жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр /пассив/	97
Зураг 30. Зээлийн жилийн өсөлт, салбарын бүрэлдэхүүнээр	98
Зураг 31. Бизнесийн, хэрэглээний зээлийн жилийн өсөлт	98
Зураг 32. Монгол Улсын санхүүгийн долларжилт	100
Зураг 33. БХЗ-ын хүү	101
Зураг 34. БХЗ-ын арилжааны хэмжээ	101
Зураг 35. Хадгаламж, зээлийн хүү	103
Зураг 36. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш	104
Зураг 37. Ханшийн өдрийн хэлбэлзлийн хистограм	104
Зураг 38. Төлбөрийн тэнцэл	106
Зураг 39. Урсгал ба хөрөнгийн тэнцэл	106
Зураг 40. Урсгал тэнцлийн ДНБ-нд эзлэх хувь	106
Зураг 41. Барааны гадаад худалдаа	107
Зураг 42. Үйлчилгээний гадаад худалдаа	107
Зураг 43. Санхүүгийн данс	108
Зураг 44. Гадаад валютын нөөц	108
Зураг 45. Монголбанкнаас гадаад валютын дотоодын захад нийлүүлсэн цэвэр интервенц	109
Зураг 46. Гадаад актив	112
Зураг 47. Гадаад пассив	112
Зураг 48. Гадаад валютын нөөцийн хүрэлцээ	115
Зураг 49. Гадаад өрийн үлдэгдэл	116
Зураг 50. Гадаад өрийн үлдэгдэл	116

Зураг 51. Банкуудын орон сууцны ипотекийн зээлийн үлдэгдэл, зээлийн өсөлт.....	120
Зураг 52. Активын бүтэц, өсөлт (их наяд төгрөгөөр).....	126
Зураг 53. Зээлийн үлдэгдэл (их наяд төгрөгөөр), өсөлт.....	127
Зураг 54. Эдийн засгийн голлох салбаруудын зээлийн үлдэгдэл (их наяд төгрөгөөр), нийт зээлд эзлэх хувь, жилийн өсөлт.....	127
Зураг 55. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр), тэдгээрийн нийт зээлд эзлэх хувь.....	128
Зураг 56. Тухайн салбар дахь чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хувь	129
Зураг 57. Активын бүтэц, өсөлт (их наяд төгрөгөөр).....	129
Зураг 58. Банкны системийн эрсдэл даах чадварын үзүүлэлт.....	130
Зураг 59. Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар.....	130
Зураг 60. МУ-ын эрсдэлийн нэмэгдлийн түвшин (2017 оны эцсийн байдлаар)	133

ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

ШИГТГЭЭ 1. ӨР, ОРЛОГЫН ХАРЬЦААНД ДЭЭД ХЯЗГААР ТОГТООХ.....	76
ШИГТГЭЭ 2. ИНСТИТУЦИЙН ЧАНАР	83
ШИГТГЭЭ 3. ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГ	92
ШИГТГЭЭ 4. ДОЛЛАРЖИЛТЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	99
ШИГТГЭЭ 5. ГАДААД ВАЛЮТЫН ЗАХЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ	105
ШИГТГЭЭ 6. МОНГОЛБАНКНЫ ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО	109
ШИГТГЭЭ 7. МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ДИАГНОСТИК ШИНЖИЛГЭЭ	113
ШИГТГЭЭ 8. МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ.....	118
ШИГТГЭЭ 9. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН 9 ДҮГЭЭР СТАНДАРТ	124
ШИГТГЭЭ 10. ЭРСДЭЛИЙН НЭМЭГДЛИЙН ТҮВШИН.....	131

Тайлбар: Энэхүү төслийн баримт бичигт орсон шигтгээ судалгаанд хийгдсэн дүгнэлт нь Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй бөгөөд зөвхөн хувь судлаачдын санаа бодлыг илэрхийлж байгаа болно.

ТЭМДЭГЛЭЛ

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

Тэмдэглэл

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.